4 – 95 хувийн итгэх магадлалд хүргэх утга

$r$  – түлхүүр үзүүлэлтийн эзлэх хувь

$deff$  – түүврийн зохиомжийн нөлөөлөл буюу вариациудын харьцаа, өмнөх судалгаанаас тооцоогүй тохиолдолд 1.5 байхаар ихэвчлэн сонгодог

$RME$  – 95 хувийн итгэх магадлалын түвшинд таамаглаж байгаа харьцангуй алдаа

$pb$  – нийт хүн амд түлхүүр үзүүлэлт тооцсон хүн амын эзлэх хувь (зорилтот олонлогийн нийт эх олонлогт эзлэх хувь)

$RR$  – хариултын хувь

## Судалгааны асуулга

Судалгааны асуулга, үзүүлэлтийг тодорхойлохдоо судалгааны зорилго, хамрах хүрээ, мэдээллийн хэрэгцээ, шаардлагад үндэслэсэн. Судалгаанд дараах 2 асуулгыг оруулсан.

Үүнд:

- Өрхийн асуулга – Өрхийн гишүүдийн хүн ам зүйн мэдээлэл болон мэдээлэл, харилцаа холбоо, технологийн мэдээлэл
- Хүн амын асуулга – Хүн амын мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээ, ур чадвар, цахим худалдан авалтын талаарх мэдээллийг цуглуулсан.

## Судалгааны ёс зүй

ӨХХМХТТ Судалгааны үзэл баримтлал, асуулгыг ҮСХ-ны даргын 2021 оны А/75 тоот тушаалаар баталсан, үүнд судалгааг зохион байгуулах явцад гарч болзошгүй аливаа эрсдэл, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх арга замыг тусгасан. Судалгаанд сонгогдсон өрх, тухайн өрхөд амьдарч байгаа судалгаанд хамрагдах насны иргэдээс зөвшөөрөл авч ярилцлага хийсэн. 15-17 насны өсвөр насны хүүхдүүдийн хувьд тухайн өрхөд өөр насанд хүрсэн гишүүн байхгүй, насанд хүрсэн гишүүн нь утсаар ярилцлага өгөх боломжгүй тохиолдолд ярилцлага авсан. Судалгаанд хамрагдсан хүн бүрт сайн дурын үндсэн дээр оролцох, хүн амын мэдээллийн нууцлалыг хуулийн дагуу чандлан хадгалж, мэдээллийг нэргүйгээр ашиглах тухайгаа танилцуулсан. Түүнчлэн судалгаанд хамрагдсан хүн нь асуулгаас бүхэлд нь эсвэл аль нэг асуултад хариулахаас татгалзах, ярилцлагыг хэзээ ч зогсоох эрхтэй гэдгийг урьдчилан сануулж байв.

## Мэдээлэл цуглуулсан арга

МХХТ-ийн судалгааны мэдээлэл цуглуулалтад компьютер ашиглан утсаар ярилцлага авах (CATI) арга, CSPro 7.5 (тооллого, түүвэр судалгааны мэдээлэл боловсруулах систем) программыг ашигласан бөгөөд олон улсын стандарт асуулгыг өөрийн орны онцлогт уялдуулан шаардлагатай өөрчлөлтийг тусгасан.

Судалгааны мэдээлэл цуглуулалтад ашиглах программын туршилтын судалгааг ХАӨМС-гаас үндсэн түүвэртэй ижил зарчмаар түүвэрлэсэн 200 өрхөд 2021 оны 6 сарын 7-ноос 9-нд хооронд зохион байгуулав. Уг туршилтын судалгаанаас гарсан үр дүнд үндэслэн асуулга болон программд шаардлагатай засвар, өөрчлөлт хийж эцэслэн боловсруулсан.

## Сургалт

Судалгааны мэдээлэл цуглуулах ажилтнуудад зориулсан сургалтыг 30 хүнийг хамруулж, 2021 оны 10 дугаар сарын 24-ноос 10 дугаар сарын 25-ны өдрүүдэд 2 хоногийн хугацаанд Ковид-19 цар тахлаас үүдэн ОБЕГ-аас гаргасан зөвлөмжийн дагуу танхимын дүүргэлтийг 50 хувьд барьж онлайн болон танхимын холимог байдлаар зохион байгуулсан. Сургалтад ярилцлага авах арга зүй, асуулгын хуудас тус бүрийн асуултыг зааснаас гадна цаасан асуулгаар, таблет ашиглан, ярилцлага авахуулсан. Сургалтын эхний өдөр цаасан асуулга, 2 дахь өдөр таблет дээр хэрхэн дуудлага хийх, программд өгөгдлөө хэрхэн оруулах талаар танилцуулав. Судалгааны мэдээлэл цуглуулалтын багийн ахлагч нарт багийн ахлагчийн үүрэг, хариуцлага, хийх ажлын талаар, мэдээлэл цуглуулалтыг зайнаас хэрхэн зохион байгуулах тухай нэмэлт сургалтыг зохион байгуулав.

## Мэдээлэл цуглуулалт

Судалгааны мэдээлэл цуглуулалтад нийт 5 баг ажилласан, баг тус бүр багийн ахлагч, 5 ярилцлага авагч гэсэн бүрэлдэхүүнтэй байсан. Мэдээлэл цуглуулалтын ажил 2021 оны 10 дугаар сарын 30-наас эхэлж 12 дугаар сарын 12-ныг дуустал нийт 45 хоног үргэлжилсэн. Судалгааны мэдээлэл цуглуулалтад Windows 10 үйлдлийн систем бүхий таблет ашигласан бөгөөд дуудлагыг Micro sip программ ашиглан ҮСХ-ны судалгаанд ашигладаг албан ёсны (75331212) дугаар бүхий утаснаас хийсэн бөгөөд мэдээлэл оруулах болон ҮСХ-ны серверт дамжуулахад CSPro 7.5 программыг ашиглав.

## Мэдээлэл боловсруулалт


Мэдээлэл цуглуулалтын явцад сонгогдсон нэгжээс ярилцлага авагч нарын цуглуулсан мэдээлэл ҮСХ-ны серверт нэгтгэгдэж, багийн ахлагч тухай бүрд хянаж, шаардлагатай тодруулгыг хийсний дараа багийн ахлагч ҮСХ-ны төв серверт нэгтгэсэн мэдээллийг дамжуулсан. Программд шинэчлэл хийсэн тохиолдолд мэдээлэл цуглуулагч, багийн ахлагч ҮСХ-ны төв серверт мэдээлэл дамжуулах үед мэдээлэл цуглуулах программ шинэчлэгдэхээр зохион байгуулсан. Судалгааны үр дүнгийн үзүүлэлтүүдийг тооцож, хүснэгтлэн боловсруулахдаа Нийгмийн шинжлэх ухаанд өргөн ашигладаг статистикийн багц программ SPSS 26.0-ийг ашигласан.

## Судалгааны төлөвлөлт, зохион байгуулалт

Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн түүвэр судалгааны ерөнхий зохион байгуулалт, бэлтгэл ажил 2021 оны 5 дугаар сараас эхэлсэн.



## ЗУРАГ 2. СУДАЛГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Судалгааг зохион байгуулахад дараах үндсэн ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Бэлтгэл ажлын хүрээнд:
  - Судалгааны арга зүй, аргачлал, үзэл баримтлал боловсруулах;
  - Судалгааны асуулга, нөхөх зааврыг боловсруулах;
  - Түүврийн зохиомж боловсруулах, түүвэрлэлт хийх;
  - Судалгааны мэдээллийг оруулах, шалгах, засварлах, үр дүнгийн хүснэгт гаргах программын бодлогын даалгаврыг боловсруулах;
  - Туршилтын судалгаа явуулах;
  - Туршилтын судалгааны үр дүнд суурилан судалгааны асуулга, нөхөх заавар, оролтын программыг эцэслэн боловсруулах;
  - Судалгааны мэдээлэл цуглуулах судлаач, багийн ахлагч нарт зориулсан сургалт зохион байгуулах;
2. Мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд:
  - Мэдээлэл цуглуулах явцад хяналт тавьж, зөвлөгөө өгөх;
3. Боловсруулалт, тайлан бичих ажлын хүрээнд:
  - Судалгааны мэдээллийг шалгаж, засварлах, кодлох;
  - Үр дүнгийн хүснэгтүүдийг боловсруулах;
4. Үр дүнг түгээх, хэвлэн нийтлэх ажлын хүрээнд:
  - Нэгдсэн тайлан боловсруулж хэвлэх;
  - Анхдагч мэдээллийн нууцлалыг хангаж, хэрэглэгчдэд нээлттэй тархаах;
  - Судалгааны үр дүнг олон нийтэд таниулах.

# ҮЗҮҮЛЭЛТ, ТҮҮНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

Үзүүлэлт	Тодорхой
Суурин телефон тоо	Суурин телефон цэг гэж цахилгаан холбооны нийтийн сүлжээнд суурин технологи ашиглан хэрэглэгчийн холбогдож буй төгсгөлийн төхөөрөмж юм.
Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо	Үүрэн телефон хэрэглэгч гэж хөдөлгөөнт технологийг ашиглан цахилгаан холбооны нийтийн сүлжээнд сүүлийн 3 сард холбогдсон хэрэглэгчдийн нийт тоо байна.
Суурин интернэт хэрэглэгчдийн тоо	Суурин (утсан) интернэт хэрэглэгчид гэж суурин (утсан)-өргөн зурвасын холболт болон суурин телефон (Dial-Up) шугам ашиглан интернэтэд холбогдож буй хэрэглэгчдийн нийт тоо байна.
Хөдөлгөөнт өргөн зурвасын идэвхтэй хэрэглэгчийн тоо	Хөдөлгөөнт интернэтийн хэрэглэгчид гэж үүрэн холбооны сүлжээнд 2G, 3G, 4G/LTE эсвэл WiMAX технологийг ашиглан интернэтэд холбогдож буй хэрэглэгчдийн тоогоор тодорхойлогдоно.
Радио ашигладаг өрхийн эзлэх хувь	Энэ үзүүлэлт нь радио ашигладаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь юм. Радио гэж FM, AM, LW ба SW зэрэг радио долгион ашиглан радио нэвтрүүлгийг хүлээн авах боломжтой хэрэгсэл юм. Радио хүлээн авагч нь дангаараа төхөөрөмж, мөн бусад төхөөрөмжтэй нэгдсэн байж болно. Жишээ нь: Сэрүүлэгтэй цаг, хөгжим тоглуулагч, гар утас, компьютер.
Телевизортой өрхийн эзлэх хувь	Энэ үзүүлэлт нь телевизор ашигладаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь юм. Телевизор гэж агаар, кабель, интернэтийн сүлжээ болон хиймэл дагуул зэрэг түгээмэл хандалтын хэрэгслийг ашиглан телевизийн өргөн нэвтрүүлгийн дохиог хүлээн авах чадвартай бие даасан төхөөрөмж юм. Телевизор нь ихэвчлэн дангаараа төхөөрөмж байх бөгөөд бусад төхөөрөмжтэй нэгдсэн байж болно. Жишээ нь: компьютер, гар утас гэх мэт.
Утастай өрхийн эзлэх хувь	Энэ үзүүлэлт нь утастай өрхийн нийт өрхөд эзлэх хувь юм. <ul style="list-style-type: none"> <li>• Суурин утасны цэг гэж цахилгаан холбооны нийтийн сүлжээнд суурин технологи ашиглан хэрэглэгчийн холбогдож буй төгсгөлийн төхөөрөмж юм.</li> <li>• Үүрэн утас хэрэглэгч гэж цахилгаан холбооны нийтийн сүлжээнд хөдөлгөөнт технологийг ашиглан холбогдох боломж бүхий хэрэглэгчид юм.</li> <li>• Ухаалаг утас (эсвэл ухаалаг гар утас) гэж интернэтэд суурилсан үйлчилгээнүүдийг багтаасан ухаалаг чадвартай, компьютерын олон үүргийг гүйцэтгэдэг, программ татаж авах боломжтой үйлдлийн системтэй төхөөрөмж юм.</li> </ul>
Компьютертой өрхийн эзлэх хувь	Энэ үзүүлэлт нь компьютертой (ухаалаг төхөөрөмж) өрхийн нийт өрхөд эзлэх хувь юм. Компьютерыг ширээний (зөөврийн бус), зөөврийн, таблет гэж ангилна. Ширээний компьютер нь зөөврийн бус, тогтмол нэг газар байрлуулж хэрэглэхэд зориулсан компьютер юм. Зөөврийн компьютер нь ширээний компьютертой адил үүрэгтэй боловч, хэмжээгээр бага, авч явахад авсаархан төхөөрөмж юм. Таблет нь хавтгай, мэдрэгч дэлгэцтэй компьютер юм.
Сүүлийн 3 сард компьютер ашигласан хүн амын эзлэх хувь	Энэ үзүүлэлт нь сүүлийн гурван сард компьютер ашигласан хүн амын нийт хүн амд эзлэх хувь юм. Компьютерт ширээний (зөөврийн бус), зөөврийн, таблет багтаана. Ширээний компьютер нь зөөврийн бус, тогтмол нэг газар байрлуулж хэрэглэхэд зориулсан компьютер юм. Зөөврийн компьютер нь ширээний компьютертой адил үүрэгтэй боловч, хэмжээгээр бага, авч явахад авсаархан төхөөрөмж юм. Таблет нь хавтгай, мэдрэгч дэлгэцтэй компьютер байна.
Интернэттэй өрхийн эзлэх хувь	Энэ нь гэртээ интернэттэй өрхийн нийт өрхөд эзлэх хувь юм. Интернэт гэртээ хэрэглэгч гэж өөрийн гэрт интернэтийн үйлчилгээг авдаг хэрэглэгч юм. Интернэт хэрэглэхдээ компьютер, гар утас, таблет, тоглоом тоглогч машин, ухаалаг телевизор зэргийн ашиглаж болно.
Сүүлийн 3 сард интернэт ашигласан хүн амын эзлэх хувь	Энэ үзүүлэлт нь сүүлийн гурван сард интернэт ашигласан хүн амын нийт хүн амд эзлэх хувь юм. Интернэт хэрэглэгч гэж сүүлийн 3 сарын хугацаанд аль нэгэн газраас интернэт ашигласан хүн амыг ойлгоно. Интернэт хэрэглэхдээ компьютер, гар утас, таблет, тоглоом тоглогч машин, ухаалаг телевизор зэргийн ашиглаж болно.
Сүүлийн 3 сард интернэт ашигласан хүн амын эзлэх хувь, байршлын төрлөөр	Энэ үзүүлэлт нь сүүлийн гурван сарын хугацаанд тодорхой байршлаас интернэт ашигласан хүн амын нийт интернэт ашигласан хүн амд эзлэх хувь юм. Интернэт ашигласан хүний байршил гэж гэртээ, ажлын байранд, боловсролын байгууллагад, бусдын гэрт, нийтийн интернэттэй газар, төлбөртэй интернэт үйлчилгээний газраас ашиглаж болно.

Үзүүлэлт	Тодорхой
Сүүлийн 3 сард иргэдийн интернэтээр явуулсан үйл ажиллагааны эзлэх хувь, үйл ажиллагааны төрлөөр	Энэ үзүүлэлт нь сүүлийн гурван сарын хугацаанд хувийн (ажлын бус) зорилгоор интернэтийн орчинд үйл ажиллагаа явуулсан хүн амын интернэт ашигласан нийт хүн амд эзлэх хувь юм.
Сүүлийн 3 сард гар утас хэрэглэсэн 6 наснаас дээш хүн амын эзлэх хувь	Энэ үзүүлэлт нь сүүлийн гурван сард гар утас хэрэглэсэн хүн амын нийт хүн амд эзлэх хувь юм. Гар утасны хэрэглээтэй хүн гэж өөрийн болон найз нөхөд, гэр бүлийнхээ хэн нэгний гар утсыг хэрэглэх боломжтой хүн амыг ойлгоно. Ухаалаг утас (эсвэл ухаалаг гар утас) гэж интернэтэд суурилсан үйлчилгээнүүдийг багтаасан ухаалаг чадвартай, компьютерын олон үүргийг гүйцэтгэдэг, программ татаж авах боломжтой үйлдлийн системтэй төхөөрөмж юм.
Интернэт хэрэглэдэг өрхийн эзлэх хувь, сүлжээний төрлөөр	Энэ үзүүлэлт нь тодорхой төрлийн сүлжээг ашиглан интернэт ашиглаж байгаа өрхийн интернэт хэрэглэдэг нийт өрхөд эзлэх хувь юм. Энэ нь World Wide Web зэрэг олон тооны харилцаа холбооны үйлчилгээнд нэвтрэх боломжийг олгодог бөгөөд ашигласан төхөөрөмжөөс үл хамааран и-мэйл, мэдээ, зугаа цэнгэл, мэдээллийн файлуудыг зөөвөрлөнө.
Интернэт хэрэглэж буй хүн амын эзлэх хувь, давтамжийн төрлөөр	Энэ үзүүлэлт нь сүүлийн гурван сарын хугацаанд тодорхой давтамжтайгаар интернэт хэрэглэсэн хүн амын интернэт хэрэглэсэн нийт хүн амд эзлэх хувь юм. Интернэт бол дэлхийн нийтийн компьютерын сүлжээ юм. Энэ нь World Wide Web зэрэг олон тооны харилцаа холбооны үйлчилгээнд нэвтрэх боломжийг олгодог бөгөөд ашигласан төхөөрөмжөөс үл хамааран и-мэйл, мэдээ, зугаа цэнгэл, мэдээллийн файлуудыг зөөвөрлөнө.
Телевизийн олон сувгийн үйлчилгээг хүлээн авдаг өрхийн эзлэх хувь, төрлөөр	Энэ үзүүлэлт нь тодорхой төрлийн телевизийн олон сувгийн үйлчилгээг хүлээн авдаг өрхийн телевизийн олон сувгийн үйлчилгээг хүлээн авдаг нийт өрхөд эзлэх хувь юм. Телевизийн олон сувгийн үйлчилгээ нь дараах төрлүүдтэй байна: <ul style="list-style-type: none"> <li>- Эфирийн тоон телевиз (DTT) –Газрын (terrestrial) тоон телевизийн сүлжээгээр, өргөн нэвтрүүлгийн телевизийг төлбөргүй хүлээн авах үйлчилгээ.</li> <li>- Кабелийн телевиз (CaTV) –утастай, утасгүй сүлжээгээр телевизийн олон сувгийг хүлээн авах үйлчилгээ.</li> <li>- Интернэт протоколд суурилсан телевиз (IPTV) -телевиз, видео, интернэт, яриа зэрэг үйлчилгээг интернэт протоколд суурилсан сүлжээгээр хүлээн авах үйлчилгээ.</li> <li>- Хиймэл дагуулын телевиз (DTH) – Хиймэл дагуулын таваг, хүлээн авагч ашиглан телевизийн олон сувгийг хүлээн авах үйлчилгээ</li> </ul>
Өрхийн интернэтэд холбогдоогүй шалтгаан	Энэ үзүүлэлт нь тодорхой төрлийн шалтгааны улмаас интернэтэд холбогдоогүй өрхийн интернэтэд холбогдоогүй нийт өрхөд эзлэх хувь юм.
Сүүлийн 3 сард компьютер хэрэглэх чадвартай хүн ам, хувиар, ур чадварын төрлөөр	Энэ үзүүлэлт нь компьютерын тодорхой төрлийн хэрэглээний чадвартай хүн амын нийт хүн амд эзлэх хувь юм. Компьютер хэрэглэх чадвартай эсэхийг тодорхойлоход: <ul style="list-style-type: none"> <li>- Өгөгдөл, контент, файл, хавтсыг хуулах, зөөх, мэдээллийг баримт бичиг рүү хуулах (copy, paste),</li> <li>- Цахим шуудангаар файл хавсаргаж явуулах (файл, зураг, бичлэг гэх мэт),</li> <li>- Эксел хүснэгттэй ажиллахдаа арифметикийн үндсэн томъёог хэрэглэх,</li> <li>- Утастай эсвэл утасгүй технологи ашиглан шинэ төхөөрөмжүүдийг холбох, суурилуулах (модем, камер, принтер гэх мэт),</li> <li>- Программ хангамжийг хайх, татаж авах, суулгах, программ ашиглан танилцуулга (presentation) бэлтгэх (текст, зураг, дуу, видео, график гэх мэт),</li> <li>- Компьютер болон бусад төхөөрөмжийн хооронд файл шилжүүлэх, мэргэжлийн программын хэлийг ашиглан программ бичих, кодлох, хөгжүүлэх, хувийн мэдээллээ интернэт орчинд хамгаалахын тулд аюулгүй байдлаа хангах зэрэг үйл ажиллагаа орно.</li> </ul>
Өрхийн нийт зардалд МХХТ-ийн зардлын эзлэх хувь, зардлын төрлөөр	Энэ үзүүлэлт нь өрхийн нийт зардалд МХХТ-ийн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь юм. Өрхийн МХХТ-д зарцуулсан зардалд харилцаа холбооны тоног төхөөрөмж, хэрэгсэл худалдан авсан зардал, программ хангамж худалдан авсан зардал, үзвэр үйлчилгээ, контентын зардлыг оруулна.
Сүүлийн 3 сард интернэт хэрэглэж буй хүн амын эзлэх хувь, зөөврийн төхөөрөмж, сүлжээний төрлөөр	Энэ үзүүлэлт нь интернэтэд холбогдохдоо тодорхой төрлийн сүлжээ, зөөврийн төхөөрөмж ашигласан хүн амын интернэт хэрэглэсэн нийт хүн амд эзлэх хувь юм.

Үзүүлэлт	Тодорхой
Сүүлийн 3 сарын хугацаанд гар утас эзэмшиж байгаа хүн ам, хувиар	Энэ үзүүлэлт нь гар утас эзэмшиж байгаа хүн амын нийт хүн амд эзлэх хувь юм. Үүнд ажил олгогчоос нийлүүлсэн хувийн хэрэгцээнд ашиглах боломжтой (хувийн дуудлага хийх, интернэтэд холбогдох гэх мэт) болон өөрийн нэрээр бүртгэлгүй хувийн хэрэгцээний ухаалаг утастай хүн ам багтана.
Интернэт ашигладаггүй хүн амын тухайн нийт хүн амд эзлэх хувь, шалтгаанаар	Энэ үзүүлэлт нь тодорхой төрлийн шалтгааны улмаас интернэт ашигладаггүй хүн амын интернэт ашигладаггүй нийт хүн амд эзлэх хувь юм. Үүнд хүн амын интернэт ашиглахад тулгарч буй саад бэрхшээлийг ойлгоно.
Сүүлийн 3 сард интернэтээр бараа, үйлчилгээ худалдаж авсан хүн амын тухайн нийт хүн амд эзлэх хувь, бараа, үйлчилгээний төрлөөр	Энэ үзүүлэлт нь интернэтээр тодорхой бараа, үйлчилгээг сүүлийн 3 сард ядаж нэг удаа худалдаж авсан хүн амын интернэтээр худалдаа хийсэн нийт хүн амд эзлэх хувь юм.
Сүүлийн 3 сард интернэтээр бараа, үйлчилгээ худалдаж авсан хүн амын эзлэх тухайн нийт хүн амд хувь, төлбөрийн төрлөөр	Энэ үзүүлэлт нь интернэтээр бараа, үйлчилгээг сүүлийн 3 сард ядаж нэг удаа худалдаж авсан нийт хүн амд тодорхой төлбөрийн төрлөөр бараа, үйлчилгээ худалдаж авсан хүн амын эзлэх хувь юм.
Сүүлийн 3 сард интернэтээр бараа, үйлчилгээ худалдаж авсан хүн амын тухайн нийт хүн амд эзлэх хувь, хүргэлтийн төрлөөр	Энэ үзүүлэлт нь интернэтээр бараа, үйлчилгээг сүүлийн 3 сард ядаж нэг удаа худалдаж авсан нийт хүн амд тодорхой хүргэлтийн төрлөөр бараа, үйлчилгээ хүлээн авсан хүн амын эзлэх хувь юм.
Сүүлийн 3 сард интернэтээр бараа, үйлчилгээ худалдаж аваагүй хүн амын тухайн нийт хүн амд эзлэх хувь, шалтгааны төрлөөр	Энэ үзүүлэлт нь тодорхой төрлийн шалтгааны улмаас интернэтээр бараа, үйлчилгээ худалдаж аваагүй хүн амын интернэтээр бараа, үйлчилгээ худалдаж аваагүй нийт хүн амд эзлэх хувь юм.

Эх үүсвэр: ҮСХ-ны баталж гаргасан МХХТ-ийн үзүүлэлтийг тооцох аргачлал

# 1. СУДАЛГААНЫ ХАМРАЛТ, СУДАЛГААНД ХАМРАГДАГЧДЫН ШИНЖ БАЙДАЛ

## Судалгааны хамралт

Судалгаанд хамрагдалтын түвшнийг Хүснэгт 1-т харуулав. МХХТ-ийн асуулгыг нэгж тус бүрээс санамсаргүйгээр сонгосон 20 өрхөөс авсан. Улсын хэмжээнд 325 түүврийн нэгжийн 6500 өрхөөс 5297 нь судалгаанд бүрэн хамрагдаж, хамрагдалтын түвшин 81.5 хувь байна. Судалгаанд хамрагдсан өрхөөс 15, түүнээс дээш насны 9144 хүнээс хүн амын МХХТ-ийн асуулгыг бүрэн авсан бөгөөд нийт судалгаанд хамрагдсан хүмүүсийн 47.5 хувь нь эрэгтэй, 52.5 хувь нь эмэгтэй байна.

ХҮСНЭГТ 1. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ӨРХ, ХҮН АМЫН ТОО, хүйс, бүс, хот, хөдөөгөөр

	Өрх			Хувь хүн		
	Хот, хөдөө			Хүйс		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>Нийт</b>	5297	2660	2637	9144	4343	4801
<b>Бүс</b>						
Баруун	1081	395	686	1960	961	999
Хангай	1087	465	622	1869	877	992
Төв	1074	484	590	1831	869	962
Зүүн	1138	399	739	1948	910	1038
Улаанбаатар	917	917	-	1536	726	810
<b>Байршил</b>						
Улаанбаатар	917	917	-	1536	726	810
Аймгийн төв	1743	1743	-	2981	1376	1605
Сумын төв	948	-	948	1628	753	875
Хөдөө	1689	-	1689	2999	1488	1511

## Өрхийн шинж байдал

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн бүтцийг бүс, байршил, ам бүлийн тоо, өрхийн тэргүүлэгчийн нас, хүйс, боловсрол зэрэг сонгосон үзүүлэлтээр Хүснэгт 2-т харуулав. Уг мэдээлэл нь тайланд тусгагдсан бусад үр дүнг тайлбарлахад чухал ач холбогдолтой бөгөөд судалгааны түүврийн төлөөлөлтэй холбогдох суурь мэдээлэл болно. Уг хүснэгтэд харуулсан шинж байдлын үзүүлэлтүүдийг энэхүү тайлангийн дараагийн хүснэгтүүдэд ашигласан.

ХҮСНЭГТ 2. ӨРХИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, хот, хөдөөгөөр, сонгосон үзүүлэлтээр

	Нийт	Хот	Хөдөө
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>50.2</b>	<b>49.8</b>
<b>Бүс</b>			
Баруун	100.0	36.5	63.5
Хангай	100.0	42.8	57.2
Төв	100.0	45.1	54.9
Зүүн	100.0	35.1	64.9

	Нийт	Хот	Хөдөө
Улаанбаатар	100.0	100.0	-
<b>Өрхийн тэргүүлэгчийн хүйс</b>			
Эрэгтэй	100.0	47.7	52.3
Эмэгтэй	100.0	59.6	40.4
<b>Өрхийн тэргүүлэгчийн насны бүлэг</b>			
35 хүртэлх	100.0	46.6	53.4
35-59	100.0	49.8	50.2
60+	100.0	55.2	44.8
<b>Өрхийн ам бүлийн тоо</b>			
1-2	100.0	50.6	49.4
3-4	100.0	51.4	48.6
5-6	100.0	48.0	52.0
7+	100.0	49.5	50.5

Судалгаанд хамрагдсан өрхийн тэргүүлэгчийн нас, хүйсийг Хүснэгт 3-т үзүүлэв. Судалгаанд хамрагдсан өрхийн, тэргүүлэгчийн 18.7 хувь нь 35 хүртэлх, 60.5 хувь нь 35-59 нас, 20.1 хувь нь 60 ба түүнээс дээш насных байна.

**ХҮСНЭГТ 3. ӨРХИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ**, өрхийн тэргүүлэгчийн нас, хүйс, сонгосон үзүүлэлтээр

	Хүйс			Нас			
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	35 хүртэлх	35-59	60+
<b>Нийт</b>	<b>100.0</b>	79.0	21.0	<b>100.0</b>	18.7	60.5	20.1
<b>Бүс</b>							
Баруун	100.0	84.1	15.9	100.0	18.2	62.0	19.6
Хангай	100.0	79.4	20.6	100.0	19.0	59.2	20.7
Төв	100.0	78.8	21.2	100.0	20.1	61.4	17.9
Зүүн	100.0	77.3	22.7	100.0	18.5	60.5	20.0
Улаанбаатар	100.0	75.1	24.9	100.0	17.4	59.1	22.9
<b>Байршил</b>							
Улаанбаатар	100.0	217.9	72.2	100.0	17.4	59.1	22.9
Аймгийн төв	100.0	125.6	25.7	100.0	17.3	60.4	21.7
Сумын төв	100.0	72.7	24.1	100.0	19.5	59.6	20.1
Хөдөө	100.0	77.5	25.7	100.0	20.3	61.8	17.0
<b>Өрхийн тэргүүлэгчийн хүйс</b>							
Эрэгтэй	100.0	17.7	4.9	100.0	20.8	62.0	16.4
Эмэгтэй	100.0	130.4	21.8	100.0	10.8	54.6	34.2
<b>Өрхийн тэргүүлэгчийн насны бүлэг</b>							
35 хүртэлх	100.0	87.9	12.1	100.0	-	-	-
35-59	100.0	81.1	18.9	100.0	-	-	-
60+	100.0	64.4	35.6	100.0	-	-	-
<b>Өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин</b>							
Боловсролгүй	100.0	79.5	20.5	100.0	13.6	63.6	22.7
Бага	100.0	76.6	23.4	100.0	8.8	54.4	36.0
Суурь	100.0	81.4	18.6	100.0	9.4	63.3	27.3
Бүрэн дунд	100.0	81.1	18.9	100.0	17.5	65.7	16.1

		Хүйс		Нас			Хүйс
Техник, мэргэжлийн	100.0	69.8	30.2	100.0	12.2	55.8	31.0
Дээд	100.0	78.0	22.0	100.0	32.1	52.0	14.7
<b>Өрхийн гишүүний тоо</b>							
1-2	100.0	64.6	35.4	100.0	10.2	46.7	41.9
3-4	100.0	82.5	17.5	100.0	25.2	61.3	12.9
5-6	100.0	90.7	9.3	100.0	20.4	73.8	5.3
7+	100.0	87.9	12.1	100.0	9.5	80.0	10.5

Судалгаанд хамрагдсан өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшинг Хүснэгт 4-т үзүүлэв. Судалгаанд хамрагдсан өрхийн тэргүүлэгчийн 1.7 хувь нь боловсролгүй, 47.0 хувь нь бүрэн дунд, 22.8 хувь нь дээд боловсролтой байна.

ХҮСНЭГТ 4. ӨРХИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, тэргүүлэгчийн боловсролын түвшин, сонгосон үзүүлэлтээр

	Бүгд	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техник, мэргэжлийн	Дээд
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>1.7</b>	<b>7.9</b>	<b>11.7</b>	<b>47.0</b>	<b>9.0</b>	<b>22.8</b>
<b>Бүс</b>							
Баруун	100.0	4.2	9.9	13.0	47.5	6.6	18.8
Хангай	100.0	1.7	9.3	12.9	49.4	7.7	19.0
Төв	100.0	0.4	6.5	11.6	47.0	11.2	23.3
Зүүн	100.0	1.4	10.8	15.3	48.8	8.7	15.0
Улаанбаатар	100.0	0.4	2.0	4.1	41.1	11.2	41.1
<b>Байршил</b>							
Улаанбаатар	100.0	0.4	2.0	4.1	41.1	11.2	41.1
Аймгийн төв	100.0	1.1	5.2	8.8	46.9	10.4	27.5
Сумын төв	100.0	0.6	6.1	12.7	48.1	10.5	21.9
Хөдөө	100.0	3.4	14.9	18.2	49.6	5.5	8.4
<b>Өрхийн тэргүүлэгчийн хүйс</b>							
Эрэгтэй	100.0	1.7	7.7	12.0	48.2	8.0	22.5
Эмэгтэй	100.0	1.6	8.8	10.4	42.3	13.0	24.0
<b>Өрхийн тэргүүлэгчийн насны бүлэг</b>							
35 хүртэлх	100.0	1.2	3.7	5.9	44.1	5.9	39.2
35-59	100.0	1.7	7.1	12.2	51.0	8.3	19.6
60+	100.0	1.9	14.2	15.8	37.6	13.9	16.7
<b>Өрхийн гишүүний тоо</b>							
1-2	100.0	1.6	9.9	12.3	42.8	11.6	21.7
3-4	100.0	1.1	4.6	11.4	49.4	8.9	24.5
5-6	100.0	2.0	9.8	10.6	48.3	6.3	22.9
7+	100.0	5.8	13.2	16.3	47.4	5.3	12.1

Судалгаанд хамрагдсан өрхөд 1-2 гишүүнтэй өрх 31.8 хувь, 3-4 гишүүнтэй өрх 39.5 хувь, 5-6 гишүүнтэй өрх 25.1 хувь, 7 ба түүнээс дээш гишүүдтэй өрх 3.6 хувийг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 5. ӨРХИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, өрхийн гишүүдийн тоо, сонгогдсон үзүүлэлтээр

		1-2	3-4	5-6	7+
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>31.8</b>	<b>39.5</b>	<b>25.1</b>	<b>3.6</b>
<b>Бүс</b>					
Баруун	100.0	25.8	39.0	29.1	6.0
Хангай	100.0	32.6	40.7	24.4	2.4
Төв	100.0	32.9	41.0	23.0	3.2
Зүүн	100.0	35.9	37.2	23.6	3.3
Улаанбаатар	100.0	31.4	39.9	25.6	3.1
<b>Байршил</b>					
Улаанбаатар	100.0	31.4	39.9	25.6	3.1
Аймгийн төв	100.0	32.4	40.7	23.2	3.8
Сумын төв	100.0	34.1	39.1	23.3	3.5
Хөдөө	100.0	30.1	38.3	27.9	3.7
<b>Өрхийн тэргүүлэгчийн хүйс</b>					
Эрэгтэй	100.0	26.0	41.2	28.8	4.0
Эмэгтэй	100.0	53.7	33.1	11.2	2.1
<b>Өрхийн тэргүүлэгчийн насны бүлэг</b>					
35 хүртэлх	100.0	17.3	53.4	27.5	1.8
35-59	100.0	24.5	40.1	30.7	4.7
60+	100.0	66.1	25.4	6.7	1.9
<b>Өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин</b>					
Боловсролгүй	100.0	30.7	26.1	30.7	12.5
Бага	100.0	39.6	23.2	31.3	6.0
Суурь	100.0	33.5	38.7	22.8	5.0
Бүрэн дунд	100.0	29.0	41.6	25.8	3.6
Техник, мэргэжлийн	100.0	41.1	39.2	17.6	2.1
Дээд	100.0	30.3	42.5	25.3	1.9

### Хүн амын шинж байдал

Монгол Улсын 15 ба түүнээс дээш насны хүмүүсийн талаарх ерөнхий мэдээлэл (оршин суугаа бүс, байршил, нас, хүйс, боловсрол)-ийг сонгосон үзүүлэлтээр Хүснэгт 6-д харуулав. Уг мэдээлэл нь тайланд тусгагдсан бусад үр дүнг тайлбарлах чухал ач холбогдолтой бөгөөд судалгааны түүврийн төлөөлөлтэй холбогдох суурь мэдээлэл болно. Уг хүснэгтэд харуулсан шинж байдлын үзүүлэлтүүдийг энэхүү тайлангийн дараагийн хүснэгтүүдэд ашигласан.

ХҮСНЭГТ 6. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ИРГЭД ЭЗЛЭХ ХУВЬ, хот, хөдөө, сонгогдсон үзүүлэлтээр

	Нийт	Хот	Хөдөө
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>73.2</b>	<b>26.8</b>
<b>Бүс</b>			
Баруун	100.0	47.3	52.7
Хангай	100.0	56.7	43.3
Төв	100.0	53.0	47.0
Зүүн	100.0	47.9	52.1
Улаанбаатар	100.0	100.0	0.0



	Нийт	Хот	Хөдөө
<b>Байршил</b>			
Улаанбаатар	100.0	100.0	-
Аймгийн төв	100.0	100.0	-
Сумын төв	100.0	-	100.0
Хөдөө	100.0	-	100.0
<b>Хүйс</b>			
Эрэгтэй	100.0	73.5	26.5
Эмэгтэй	100.0	72.9	27.1
<b>Насны бүлэг</b>			
35 хүртэлх	100.0	71.7	28.3
35-59	100.0	73.3	26.7
60+	100.0	78.3	21.7
<b>Боловсролын түвшин</b>			
Боловсролгүй	100.0	39.5	60.5
Бага	100.0	43.7	56.3
Суурь	100.0	56.5	43.5
Бүрэн дунд	100.0	69.2	30.8
Техник, мэргэжлийн	100.0	76.2	23.8
Дээд	100.0	85.1	14.9

Монгол Улсын 15 ба түүнээс дээш насны иргэдийн хүйсийг Хүснэгт 7-д үзүүлэв. Нийт иргэдийн 48.4 хувь нь эрэгтэй, 51.6 хувь нь эмэгтэй байна.

ХҮСНЭГТ 7. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ХҮН АМЫН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, хүйс, сонгогдсон үзүүлэлтээр

	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>48.4</b>	<b>51.6</b>
<b>Бүс</b>			
Баруун	100.0	46.5	53.5
Хангай	100.0	48.2	51.8
Төв	100.0	47.7	52.3
Зүүн	100.0	46.1	53.9
Улаанбаатар	100.0	49.6	50.4
<b>Хот, хөдөө</b>			
Хот	100.0	48.6	51.4
Хөдөө	100.0	47.8	52.2
<b>Байршил</b>			
Улаанбаатар	100.0	49.6	50.4
Аймгийн төв	100.0	47.0	53.0
Сумын төв	100.0	44.8	55.2
Хөдөө	100.0	49.5	50.5
<b>Насны бүлэг</b>			
35 хүртэлх	100.0	48.6	51.4
35-59	100.0	49.1	50.9
60+	100.0	44.6	55.4

	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
<b>Боловсролын түвшин</b>			
Боловсролгүй	100.0	56.0	44.0
Бага	100.0	59.4	40.6
Суурь	100.0	56.6	43.4
Бүрэн дунд	100.0	50.1	49.9
Техник, мэргэжлийн	100.0	47.3	52.7
Дээд	100.0	43.2	56.8

Монгол Улсын 15 ба түүнээс дээш насны иргэдийн насыг Хүснэгт 8-т үзүүлэв. Судалгаанд хамрагдсан иргэдийн 44.5 хувь нь 35 хүртэлх, 44.2 хувь нь 35-59 нас, 11.3 хувь нь 60 ба түүнээс дээш насных байна.

**ХҮСНЭГТ 8. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ХҮН АМЫН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ**, насны бүлгээр, сонгогдсон үзүүлэлтээр

	Нийт	35 хүртэлх	35-59	60+
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>44.5</b>	<b>44.2</b>	<b>11.3</b>
<b>Бүс</b>				
Баруун	100.0	44.0	45.5	10.5
Хангай	100.0	44.7	44.5	10.8
Төв	100.0	43.0	45.9	11.1
Зүүн	100.0	52.1	38.7	9.2
Улаанбаатар	100.0	43.6	44.1	12.3
<b>Хот, хөдөө</b>				
Хот	100.0	43.6	44.3	12.1
Хөдөө	100.0	46.9	44.0	9.2
<b>Байршил</b>				
Улаанбаатар	100.0	43.6	44.1	12.3
Аймгийн төв	100.0	43.5	44.6	11.9
Сумын төв	100.0	44.4	43.8	11.9
Хөдөө	100.0	48.3	44.1	7.6
<b>Хүйс</b>				
Эрэгтэй	100.0	44.7	44.9	10.4
Эмэгтэй	100.0	44.3	43.6	12.2
<b>Боловсролын түвшин</b>				
Боловсролгүй	100.0	26.9	53.7	19.3
Бага	100.0	13.6	57.3	29.1
Суурь	100.0	42.8	43.8	13.4
Бүрэн дунд	100.0	44.9	44.7	10.5
Техник, мэргэжлийн	100.0	29.9	48.1	22.0
Дээд	100.0	50.6	41.5	7.9

Монгол Улсын 15 ба түүнээс дээш насны иргэдийн боловсролын түвшнийг Хүснэгт 9-т үзүүлэв. Судалгаанд хамрагдсан иргэдийн 0.8 хувь нь боловсролгүй, 45.4 хувь нь бүрэн дунд, 35.1 хувь нь дээд боловсролтой байна.

ХҮСНЭГТ 9. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ХҮН АМЫН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, боловсролын түвшин, сонгогдсон үзүүлэлтээр

	Нийт	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техник, мэргэжлийн	Дээд
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>0.8</b>	<b>3.2</b>	<b>8.1</b>	<b>45.4</b>	<b>7.3</b>	<b>35.1</b>
<b>Бүс</b>							
Баруун	100.0	2.9	6.1	12.8	46.0	6.5	25.8
Хангай	100.0	1.5	4.9	10.4	53.0	6.0	24.2
Төв	100.0	0.2	2.9	8.8	47.1	8.2	32.8
Зүүн	100.0	0.7	5.3	13.2	50.8	6.7	23.3
Улаанбаатар	100.0	0.2	1.4	4.5	40.1	7.9	45.8
<b>Хот, хөдөө</b>							
Хот	100.0	0.5	1.9	6.3	42.9	7.6	40.9
Хөдөө	100.0	1.9	6.8	13.2	52.2	6.5	19.5
<b>Байршил</b>							
Улаанбаатар	100.0	0.2	1.4	4.5	40.1	7.9	45.8
Аймгийн төв	100.0	0.8	2.7	8.8	47.0	7.1	33.5
Сумын төв	100.0	0.5	2.6	10.0	49.6	8.9	28.5
Хөдөө	100.0	2.7	9.2	15.0	53.7	5.1	14.3
<b>Насны бүлэг</b>							
35 хүртэлх	100.0	0.5	1.0	7.8	45.8	4.9	40.0
35-59	100.0	1.0	4.2	8.0	45.9	8.0	33.0
60+	100.0	1.4	8.3	9.6	41.9	14.2	24.7
<b>Хүйс</b>							
Эрэгтэй	100.0	1.0	4.0	9.5	47.0	7.1	31.4
Эмэгтэй	100.0	0.7	2.5	6.8	43.8	7.5	38.6

## 2. МХХТ-ИЙН ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭ, ХҮРТЭЭМЖ

Энэ бүлэгт өрхөд мэдээлэл, харилцаа холбооны технологийн тоног төхөөрөмж (радио, телевиз, суурин утас, гар утас, компьютер) байгаа эсэх, мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн үйлчилгээ (телевизийн олон сувгийн, үүрэн болон суурин телефон, интернэт) авч байгаа байдал, түүнчлэн өрхийн хэрэглээнд зарцуулсан зардлын мэдээллийг харуулав.

### 2.1 Радиотой өрх


Мэдээлэл, харилцаа, холбоо технологийн хэрэглээ, хүртээмжийн 2021 оны түүвэр судалгааны үр дүнгээр Монгол Улсын нийт өрхийн 8.1 хувь нь радиотой гэж хариулсан байна.

Радиотой өрхөөс хотод амьдардаг нийт өрхийн 7.4 хувь, хөдөө амьдардаг нийт өрхийн 10.1 хувь нь радиотой байна. Харин Улаанбаатарын өрхийн 7.6 хувь, аймгийн төвийн өрхийн 7.2 хувь, сумын төвийн өрхийн 6.2 хувь, хөдөөгийн багийн өрхийн 12.5 хувь нь радиотой байна.

Радиотой өрх хөдөөгийн багийн өрхөд өндөр хувь эзэлж байгаа нь төв, суурин газраас хол, цахилгаан, эрчим хүчний эх үүсвэр хязгаарлагдмал, өрхийн орлогын түвшин зэргээс хамааралтай байх боломжтой юм.

Радиотой өрхөөс баруун бүсийн нийт өрхийн 14.4 хувь, Хангайн бүсийн 7.5 хувь, Зүүн бүсийн 7.1 хувь, Төвийн бүсийн 6.2 хувь нь тус тус радио ашиглаж байна.


ЗУРАГ 3. РАДИОТОЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, хот, хөдөө, бүс, суурьшлаар



Радиотой өрхөөс 1-2 гишүүнтэй нийт өрхийн 9.5 хувь, 3-4 гишүүнтэй өрхийн 7.5 хувь, 5-6 гишүүнтэй өрхийн 7.0 хувь, 7 ба түүнээс дээш гишүүнтэй өрхийн 12.1 хувь нь тус тус радио ашиглаж байна.

Мөн радиотой өрхөөс 35 хүртэлх насны өрхийн тэргүүлэгчтэй нийт өрхийн 7.4 хувь, 35-59 насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн 7.1 хувь, 60 ба түүнээс дээш насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн 11.9 хувь нь радио ашиглаж байна.

ЗУРАГ 4. РАДИОТОЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, өрхийн тэргүүлэгчийн насны бүлгээр



Радиотой өрхөөс боловсролгүй гэж хариулсан 16.5 хувь, бага боловсролтойнх 7.5 хувь, суурь боловсролтойнх 7.7 хувь, бүрэн дунд боловсролтойнх 6.7 хувь, техник, мэргэжлийн боловсролтойнх 7.9 хувь, дээд боловсролтой гэж хариулсан өрхийн тэрүүний 10.1 хувь нь тус тус радиотой байна.


## 2.2 Телевизортой өрх

Монгол Улсын нийт өрхийн 97.3 хувийг телевизортой өрх эзэлж байна. Телевизортой өрхөөс хотод амьдардаг нийт өрхийн 98.2 хувь, хөдөө амьдардаг нийт өрхийн 94.9 хувь нь телевизортой байна.

Улаанбаатарын өрхийн 98.5 хувь, аймгийн төвийн өрхийн 97.7 хувь, сумын төвийн өрхийн 97.9 хувь, хөдөөгийн багийн өрхийн 93.0 хувь нь телевизортой байна.

Харин баруун бүсийн нийт өрхийн 95.4 хувь, Хангайн бүсийн 96.2 хувь, Төвийн бүсийн 97.0 хувь, Зүүн бүсийн 97.1 хувь нь тус тус телевизор ашиглаж байна.


ЗУРАГ 5. ТЕЛЕВИЗОРТОЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, хот, хөдөө, бүс, суурьшлаар



Телевизортой өрхөөс 1-2 гишүүнтэй нийт өрхийн 96.4 хувь, 3-4 гишүүнтэй өрхийн 97.1 хувь, 5-6 гишүүнтэй өрхийн 98.6 хувь, 7 ба түүнээс дээш гишүүнтэй өрхийн 98.5 хувь нь телевизор ашиглаж байна.

Мөн 35 хүртэлх насны өрхийн тэргүүлэгчтэй нийт өрхийн 97.0 хувь, 35-59 насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн 97.3 хувь, 60 ба түүнээс дээш насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн 97.6 хувь нь телевизор ашиглаж байна.

ЗУРАГ 6. ТЕЛЕВИЗОРТОЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшнээр




Телевизортой өрхөөс боловсролгүй гэж хариулсан өрхийн 77.5 хувь, бага боловсролтойнх 93.1 хувь, суурь боловсролтойнх 95.9 хувь, бүрэн дунд боловсролтойнх 97.4 хувь, техник, мэргэжлийн боловсролтойнх 98.8 хувь, дээд боловсролтойнх 98.6 хувь нь тус тус телевизортой байна.

### 2.3 Телевизийн олон сувгийн үйлчилгээ хэрэглэдэг өрх, үйлчилгээний төрлөөр

Монгол Улсын нийт өрхийн 97.2 хувийг телевизийн олон сувгийн үйлчилгээ хэрэглэдэг өрх эзэлж байна. Телевизийн олон сувгийн үйлчилгээтэй өрхийн 3.8 хувь нь эфирийн тоон телевиз (DTT), 21.1 хувийг кабелийн телевиз (CATV), 27.8 хувийг интернэт протоколд суурилсан телевиз (IPTV), 47.4 хувийг хиймэл дагуулын телевиз (DTH)-ийн үйлчилгээтэй байна.

ЗУРАГ 7. ОЛОН СУВГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХЭРЭГЛЭДЭГ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР



Телевизийн олон сувгийн үйлчилгээг хотод амьдардаг нийт өрхийн 97.5 хувь, хөдөө амьдардаг нийт өрхийн 96.4 хувь нь хэрэглэж байна.

Хотын өрхийн 3.9 хувь нь эфирийн тоон телевиз, 24.4 хувь нь кабелийн телевиз, 35.7 хувь нь интернэт протоколд суурилсан телевиз, 36.1 хувь нь хиймэл дагуулын телевизийн үйлчилгээ эзэлж байгаа бол хөдөөгийн өрхийн 3.6 хувь нь эфирийн тоон телевиз, 5.5 хувь нь интернэт протоколд суурилсан телевиз, 11.6 хувь нь кабелийн телевиз, 79.3 хувь нь хиймэл дагуулын телевизийн үйлчилгээтэй байна.

ХҮСНЭГТ 10. ТЕЛЕВИЗИЙН ОЛОН СУВГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХЭРЭГЛЭДЭГ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР

	Улс	Кабелийн телевиз	Хиймэл дагуулын телевиз	Интернэт протоколд суурилсан телевиз	Эфирийн тоон телевиз
Хот	97.5	24.4	36.1	35.7	3.9
Хөдөө	96.4	11.6	79.3	5.5	3.6

Телевизийн олон сувгийн үйлчилгээ хэрэглэдэг өрхөөс Улаанбаатарын өрхийн 99.1 хувь, аймгийн төвийн өрхийн 95.3 хувь, сумын төвийн өрхийн 95.5 хувь, хөдөөгийн багийн өрхийн 97.1 хувь нь олон сувгийн үйлчилгээ хэрэглэж байна. Улаанбаатарын өрхийн хувьд 44.7 хувь нь интернэт протоколд суурилсан телевизийн үйлчилгээ, 29.4 хувь нь хиймэл

дагуулын телевизийн үйлчилгээ, 23.3 хувь нь кабелийн телевизийн үйлчилгээ хүлээн авч байгаа бол хөдөөгийн багийн өрхүүдийн 85.5 хувь нь хиймэл дагуулын телевизийн үйлчилгээг хүлээн авч байна.

**ХҮСНЭГТ 11. ТЕЛЕВИЗИЙН ОЛОН СУВГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХЭРЭГЛЭДЭГ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, үйлчилгээний төрөл, суурьшлаар**

Сууршил	Улс	Кабелийн телевиз	Хиймэл дагуулын телевиз	Интернэт протоколд суурилсан телевиз	Эфирийн тоон телевиз
Улаанбаатар	99.1	23.3	29.4	44.7	2.7
Аймгийн төв	95.3	26.1	46.3	22.0	5.6
Сумын төв	95.5	18.1	69.3	9.8	2.8
Хөдөөгийн баг	97.1	7.6	85.5	2.8	4.1

Харин баруун бүсийн нийт өрхийн 97.9 хувь, Хангайн бүсийн 94.8 хувь, Зүүн бүсийн 95.1 хувь, Төвийн бүсийн 95.9 хувь нь тус тус олон сувгийн үйлчилгээг хэрэглэж байна.

**ХҮСНЭГТ 12. ОЛОН СУВГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХЭРЭГЛЭДЭГ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, үйлчилгээний төрөл, бүсээр**

Бүс	Улс	Кабелийн телевиз	Хиймэл дагуулын телевиз	Интернэт протоколд суурилсан телевиз	Эфирийн тоон телевиз
Баруун	97.9	23.1	60.9	6.6	9.3
Хангай	94.8	18.9	60.8	16.2	4.2
Төв	95.9	19.4	58.5	19.8	2.3
Зүүн	95.1	13.7	73.2	9.3	3.8
Улаанбаатар	99.1	23.3	29.4	44.7	2.7

Олон сувгийн үйлчилгээ хэрэглэдэг өрхөөс 1-2 гишүүнтэй нийт өрхийн 95.1 хувь, 3-4 гишүүнтэй өрхийн 98.1 хувь, 5-6 гишүүнтэй өрхийн 98.2 хувь, 7 ба түүнээс дээш гишүүнтэй өрхийн 98.9 хувь нь олон сувгийн үйлчилгээг ашиглаж байна. Өрхийн ам бүл нь 3-4 гишүүнтэй өрхийн хувьд 31.4 хувь нь интернэт протоколд суурилсан телевиз, 44.1 хувь нь хиймэл дагуулын телевизийн үйлчилгээ авч байгаа бол 7 ба түүнээс дээш өрхийн гишүүдтэй өрхийн 11.0 хувь нь интернэт протоколд суурилсан телевиз, 57.8 хувь нь хиймэл дагуулын телевизийн үйлчилгээтэй байна.

**ХҮСНЭГТ 13. ОЛОН СУВГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХЭРЭГЛЭДЭГ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, өрхийн гишүүдийн тоо, үйлчилгээний төрлөөр**

Гишүүд	Улс	Кабелийн телевиз	Хиймэл дагуулын телевиз	Интернэт протоколд суурилсан телевиз	Эфирийн тоон телевиз
1-2	95.1	19.5	48.0	28.3	4.2
3-4	98.1	21.5	44.1	31.4	3.0
5-6	98.2	22.2	50.9	23.3	3.7
7+	98.9	20.3	57.8	11.0	10.9

Мөн олон сувгийн үйлчилгээ хэрэглэдэг өрхөөс 35 хүртэлх насны өрхийн тэргүүлэгчтэй нийт өрхийн 98.4 хувь, 35-59 насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн 97.5 хувь, 60 ба түүнээс дээш насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн 95.4 хувь нь олон сувгийн үйлчилгээ ашиглаж байна. 35 хүртэлх насны өрхийн тэргүүнтэй өрхийн 47.3 хувь нь хиймэл дагуулын телевиз, 32.2 хувь нь интернэт протоколд суурилсан телевиз, 17.9 хувь нь кабелийн телевизийн үйлчилгээ ашиглаж байгаа бол 60 ба түүнээс дээш насны өрхийн тэргүүнтэй өрхийн 44.4


хувь нь хиймэл дагуулын телевиз, 28.1 хувь нь интернэт протоколд суурилсан телевиз, 22.5 хувь нь кабелийн телевизийн үйлчилгээг ашиглаж байна.

#### ХҮСНЭГТ 14. ОЛОН СУВГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХЭРЭГЛЭДЭГ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, өрхийн тэргүүлэгчийн насны бүлэг, үйлчилгээний төрлөөр

Насны бүлэг	Улс	Кабелийн телевиз	Хиймэл дагуулын телевиз	Интернэт протоколд суурилсан телевиз	Эфирийн тоон телевиз
35 хүртэлх	98.4	17.9	47.3	32.3	2.5
35-59	97.5	21.6	48.6	26.0	3.8
60+	95.4	22.5	44.4	28.1	5.0

Олон сувгийн үйлчилгээ хэрэглэдэг өрхөөс боловсролгүй гэж хариулсан өрхийн 92.2 хувь, бага боловсролтойнх 94.6 хувь, суурь боловсролтойнх 97.5 хувь, бүрэн дунд боловсролтойнх 96.2 хувь, техник, мэргэжлийн боловсролтойнх 98.3 хувь, дээд боловсролтойнх 99.0 хувь нь тус тус олон сувгийн үйлчилгээг хүлээн авч байна.

#### ЗУРАГ 8. ОЛОН СУВГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХЭРЭГЛЭДЭГ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин, үйлчилгээний төрлөөр



## 2.4 Утастай өрх

Монгол Улсын нийт өрхийн 9.0 хувь нь суурин утастай, 97.9 хувь нь үүрэн утастай байна. Хотод амьдардаг нийт өрхийн 11.4 хувь нь суурин, 98.0 хувь нь үүрэн утастай бол хөдөө амьдардаг нийт өрхийн 2.4 хувь нь суурин, 97.8 хувь нь үүрэн утастай байна.

Үүрэн утастай өрхөөс хотын өрхийн 5.3 хувь нь энгийн, 78.4 хувь нь ухаалаг, 16.4 хувь нь хоёуланг нь ашигладаг бол хөдөөгийн өрхийн 16.5 хувь нь энгийн, 56.5 хувь нь ухаалаг, 26.9 хувь нь хоёуланг нь ашиглаж байна.

#### ХҮСНЭГТ 15. УТАСТАЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, төхөөрөмжийн төрөл, хот, хөдөөгөөр

	Суурин утас	Үүрэн утас	Энгийн гар утас	Ухаалаг гар утас	Аль аль нь байгаа
Хот	11.4	98.0	5.3	78.4	16.4
Хөдөө	2.4	97.8	16.5	56.5	26.9



Улаанбаатарын өрхийн 13.9 хувь нь суурин утас, 98.2 хувь нь үүрэн утас, аймгийн төвийн өрхийн 7.7 хувь нь суурин утас, 97.7 хувь нь үүрэн утас, сумын төвийн өрхийн 6.3 хувь нь суурин утас, 98.0 хувь нь үүрэн утас, харин хөдөөгийн багийн өрхөд суурин утас байхгүй ба 97.7 хувь нь үүрэн утастай байна. Улаанбаатарын өрхийн хувьд 81.4 хувь нь ухаалаг утас, 3.0 хувь нь энгийн үүрэн утастай бол хөдөөгийн багийн өрхийн 48.5 хувь нь ухаалаг утас, 19.7 хувь нь энгийн утас, 31.8 хувь нь хоёуланг нь ашиглаж байна.

#### ХҮСНЭГТ 16. УТАСТАЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, төхөөрөмжийн төрөл, суурьшлаар

Суурьшил	Суурин утас	Үүрэн утас	Энгийн гар утас	Ухаалаг гар утас	Аль аль нь байгаа
Улаанбаатар	13.9	98.2	3.0	81.4	15.6
Аймгийн төв	7.7	97.7	8.6	73.9	17.5
Сумын төв	6.3	98.0	11.3	69.8	18.9
Хөдөөгийн баг	-	97.7	19.7	48.5	31.8

Харин баруун бүсийн нийт өрхийн 5.7 хувь нь суурин утас, 98.6 хувь нь үүрэн утас, Хангайн бүсийн 5.7 хувь нь суурин утас, 97.3 хувь нь үүрэн утас, Зүүн бүсийн 3.8 хувь нь суурин утас, 96.7 хувь нь үүрэн утас, Төвийн бүсийн 4.8 хувь нь суурин утас, 98.1 хувь нь үүрэн утастай байна.

#### ХҮСНЭГТ 17. УТАСТАЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, төхөөрөмжийн төрөл, бүсээр

Бүс	Суурин утас	Үүрэн утас	Энгийн гар утас	Ухаалаг гар утас	Аль аль нь байгаа
Баруун	5,7	98.6	12.0	65.1	22.9
Хангай	5,7	97.3	16.2	58.0	25.8
Төв	4,8	98.1	8.1	76.3	15.6
Зүүн	3,8	96.7	12.7	62.5	24.8
Улаанбаатар	13.9	98.2	3.0	81.4	15.6

Утастай өрхөөс 1-2 гишүүнтэй нийт өрхийн 8.7 хувь нь суурин, 95.9 хувь нь үүрэн утас, 3-4 гишүүнтэй өрхийн 9.4 хувь нь суурин, 98.9 хувь нь үүрэн, 5-6 гишүүнтэй өрхийн 9.0 хувь нь суурин, 98.6 хувь нь үүрэн, 7 ба түүнээс гишүүнтэй өрхийн 4.9 хувь нь суурин, 99.0 хувь нь үүрэн утастай байна.

Харин 1-2 гишүүнтэй нийт өрхийн 15.7 хувь нь энгийн утастай, 3-4 гишүүнтэй өрхийн 76.0 хувь ухаалаг утастай, 7 ба түүнээс дээш гишүүнтэй өрхийн 40.5 хувь энгийн болон ухаалаг утастай байна.


#### ХҮСНЭГТ 18. УТАСТАЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, төхөөрөмжийн төрөл, өрхийн гишүүдийн тоогоор

Гишүүд	Суурин утас	Үүрэн утас	Энгийн гар утас	Ухаалаг гар утас	Аль аль нь байгаа
1-2	8.7	95.9	15.7	72.7	11.6
3-4	9.4	98.9	5.6	76.0	18.5
5-6	9.0	98.6	4.3	68.7	27.0
7+	4.9	99.0	5.8	53.7	40.5

Мөн утастай өрхийг өрхөөс 35 хүртэлх насны өрхийн тэргүүлэгчтэй нийт өрхийн 6.4 хувь нь суурин, 98.1 хувь нь үүрэн утас, 35-59 насны өрхийн тэргүүлэгчтэй нийт өрхийн 8.9 хувь нь суурин, 98.3 хувь нь үүрэн утас, 60 ба түүнээс дээш насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн

11.5 хувь нь суурин, 96.6 хувь нь үүрэн утастай байна. 35 хүртэлх насны өрхийн тэргүүлэгчтэй нийт өрхийн 84.7 хувь нь ухаалаг утастай байгаа бол 60 ба түүнээс дээш насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн 18.4 хувь нь энгийн утастай байна.

ЗУРАГ 9. ҮҮРЭН УТАСТАЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, өрхийн тэргүүлэгчийн насны бүлгээр, төрлөөр



Утастай өрхөөс боловсролгүй гэж хариулсан өрхийн 0.4 хувь нь суурин, 92.5 хувь нь үүрэн, бага боловсролтойнх 1.5 хувь нь суурин, 97.5 хувь нь үүрэн, суурь боловсролтойнх 4.0 хувь нь суурин, 98.2 хувь нь үүрэн, бүрэн дунд боловсролтойнх 6.7 хувь нь суурин, 97.0 хувь нь үүрэн, техник, мэргэжлийн боловсролтойнх 10.5 хувь нь суурин, 99.1 хувь нь үүрэн, дээд боловсролтойнх 14.6 хувь нь суурин, 99.1 хувь нь үүрэн утастай байна.

ХҮСНЭГТ 19. ҮҮРЭН УТАСТАЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, төхөөрөмжийн төрөл, өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшнээр

Боловсролын түвшин	Суурин утас	Үүрэн утас	Энгийн гар утас	Ухаалаг гар утас	Аль аль нь байгаа
Боловсролгүй	0.4	92.5	36.8	29.8	33.4
Бага	1.5	97.5	31.3	33.8	35.0
Суурь	4.0	98.2	14.1	52.8	33.1
Бүрэн дунд	6.7	97.0	8.5	70.0	21.5
Техник, мэргэжлийн	10.5	99.1	7.1	75.6	17.3
Дээд	14.6	99.1	2.1	87.9	10.0

## 2.5 Компьютертой өрх


ОУЦХБ-аас 2020 онд гаргасан цахим хөгжлийг хэмжих тайланд дэлхийн нийт өрхийн 47.0 хувь нь компьютертой байна. Компьютертой өрхөөс хотод амьдардаг нийт өрхийн 63.0 хувь, хөдөө амьдардаг нийт өрхийн 25.0 хувь нь компьютертой байна.

Манай улсын хувьд нийт өрхийн 33.3 хувийг компьютертой байна. Харин хотод амьдардаг нийт өрхийн 39.1 хувь, хөдөө амьдардаг нийт өрхийн 17.4 хувь нь компьютертой байгаа нь хотын өрхүүдийн хувьд хөдөөгийн өрхөөс 2 дахин их байна.

Улаанбаатарын өрхийн 44.7 хувь, аймгийн төвийн өрхийн 31.1 хувь, сумын төвийн өрхийн 26.8 хувь, хөдөөгийн багийн өрхийн 11.7 хувь нь тус тус компьютертой байна.

Компьютертой өрхөөс баруун бүсийн өрхийн 20.4 хувь, Хангайн бүсийн 24.1 хувь, Зүүн бүсийн 20.4 хувь, Төвийн бүсийн 30.2 хувь нь компьютертой байна.


ЗУРАГ 10. КОМПЬЮТЕРТОЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, хот, хөдөө, бүс, суурьшлаар



Харин 1-2 гишүүнтэй нийт өрхийн 25.8 хувь, 3-4 гишүүнтэй өрхийн 37.3 хувь, 5-6 гишүүнтэй өрхийн 36.9 хувь, 7 ба түүнээс дээш гишүүнтэй өрхийн 24.0 хувь нь компьютертой байна.

Компьютертой өрхөөс 35 хүртэлх насны өрхийн тэргүүлэгчтэй нийт өрхийн 36.5 хувь, 35-59 насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн 35.3 хувь, 60 ба түүнээс дээш насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн 24.1 хувь нь компьютертой байна.

ЗУРАГ 11. КОМПЬЮТЕРТОЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшнээр



Компьютертой өрхөөс боловсролгүй гэж хариулсан өрхийн 5.4 хувь, бага боловсролтойнх 8.7 хувь, суурь боловсролтойнх 18.2 хувь, бүрэн дунд боловсролтойнх 23.4 хувь, техник, мэргэжлийн боловсролтойнх 29.9 хувь, дээд боловсролтойнх 57.6 хувь нь компьютертой байна.

## 2.6 Интернеттэй өрх

ОУЦХБ-аас 2020 онд гаргасан цахим хөгжлийг хэмжих тайланд дэлхийн нийт өрхийн 57.0 хувь нь интернетэд холбогдсон байна. Интернетэд холбогдсон өрхөөс хотод амьдардаг нийт өрхийн 72.0 хувь, хөдөө амьдардаг нийт өрхийн 37.0 хувь нь интернетэд холбогдсон байна.

Монгол Улсын нийт өрхийн 80.0 хувийг интернеттэй өрх эзэлж байна. Интернеттэй өрхийн 57.3 хувь нь суурин интернет, 37.4 хувь нь хөдөлгөөнт өргөн зурвасын интернет (3G, 4G, USB, modem), 5.3 хувь нь газрын утасгүй өргөн зурвасын интернетийн үйлчилгээ тус тус хүлээн авч байна.

ЗУРАГ 12. ИНТЕРНЭТТЭЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, үйлчилгээний төрлөөр



Хотод амьдардаг нийт өрхийн 86.3 хувь, хөдөө амьдардаг нийт өрхийн 63.0 хувь нь интернэт хэрэглэж байна. Хотын өрхийн 29.6 хувь нь хөдөлгөөнт өргөн зурвасын интернэт (3G, 4G, USB, модем), 5.9 хувь нь газрын утасгүй өргөн зурвасын интернэт, 64.5 хувь нь суурин интернэтийн үйлчилгээ эзэлж байгаа бол хөдөөгийн өрхийн 66.4 хувь нь хөдөлгөөнт өргөн зурвасын интернэт (3G, 4G, USB, модем), 3.4 хувь нь газрын утасгүй өргөн зурвасын интернэт, 30.2 хувь нь суурин интернэтийн үйлчилгээтэй эзэлж байна.

ХҮСНЭГТ 20. ИНТЕРНЭТТЭЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, үйлчилгээний төрөл, хот, хөдөөгөөр

	Улс	Суурин интернэтийн сүлжээ	Газрын утасгүй өргөн зурвасын сүлжээ	Хөдөлгөөнт өргөн зурвасын сүлжээ (3G, 4G, USB, модем)
Хот	86.3	64.5	5.9	29.6
Хөдөө	63.0	30.2	3.4	66.4

Улаанбаатарын өрхийн 93.2 хувь, аймгийн төвийн өрхийн 76.2 хувь, сумын төвийн өрхийн 75.3 хувь, хөдөөгийн багийн өрхийн 55.5 хувь нь интернэттэй байна. Улаанбаатарын өрхийн хувьд 68.4 хувь нь суурин интернэтийн үйлчилгээ, 25.5 хувь нь хөдөлгөөнт өргөн зурвасын интернэт (3G, 4G, USB, модем), 6.1 хувь нь газрын утасгүй өргөн зурвасын сүлжээний интернэттэй байгаа бол хөдөөгийн багийн өрхүүдийн 73.1 хувь нь хөдөлгөөнт өргөн зурвасын интернэтийн үйлчилгээ авч байна.

ХҮСНЭГТ 21. ИНТЕРНЭТТЭЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, үйлчилгээний төрөл, суурьшлаар

Сууршил	Улс	Суурин интернэтийн сүлжээ	Газрын утасгүй өргөн зурвасын сүлжээ	Хөдөлгөөнт өргөн зурвасын сүлжээ (3G, 4G, USB, модем)
Улаанбаатар	93.2	68.4	6.1	25.5
Аймгийн төв	76.2	57.6	5.5	36.8
Сумын төв	75.3	37.0	4.7	58.4
Хөдөөгийн баг	55.5	24.6	2.3	73.1

Баруун бүсийн нийт өрхийн 69.6 хувь, Хангайн бүсийн 64.1 хувь, Зүүн бүсийн 68.1 хувь, Төвийн бүсийн 77.8 хувь нь тус тус интернэттэй байна.

ХҮСНЭГТ 22. ИНТЕРНЭТТЭЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, үйлчилгээний төрөл, бүсээр

Бүс	Улс	Суурин интернэтийн сүлжээ	Газрын утасгүй өргөн зурвасын сүлжээ	Хөдөлгөөнт өргөн зурвасын сүлжээ (3G, 4G, USB, модем)
Баруун	69.6	28.7	7.1	64.2
Хангай	64.1	48.8	4.5	46.7
Төв	77.8	56.3	3.7	40.0
Зүүн	68.1	41.2	2.9	55.9
Улаанбаатар	93.2	68.4	6.1	25.5

Интернэттэй өрхөөс 1-2 гишүүнтэй нийт өрхийн 68.8 хувь, 3-4 гишүүнтэй өрхийн 85.1 хувь, 5-6 гишүүнтэй өрхийн 85.3 хувь, 7 ба түүнээс дээш гишүүнтэй өрхийн 80.7 хувь нь интернэтийн үйлчилгээг ашиглаж байна. Өрхийн ам бүл нь 5-6 гишүүнтэй өрхийн хувьд 39.8 хувь нь хөдөлгөөнт өргөн зурвасын интернэт, 57.2 хувь нь суурин интернэтийн үйлчилгээ хүлээн авч байгаа бол 7 ба түүнээс дээш өрхийн гишүүдтэй өрхийн 60.2 хувь нь хөдөлгөөнт өргөн зурвасын интернэт, 33.4 хувь нь суурин интернэтийн үйлчилгээг хүлээн авч байна.

ХҮСНЭГТ 23. ИНТЕРНЭТТЭЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, үйлчилгээний төрөл, өрхийн гишүүдийн тоогоор

Гишүүд	Улс	Суурин интернэтийн сүлжээ	Газрын утасгүй өргөн зурвасын сүлжээ	Хөдөлгөөнт өргөн зурвасын сүлжээ (3G, 4G, USB, модем)
1-2	68.8	57.7	4.9	37.4
3-4	85.1	58.6	7.0	34.4
5-6	85.3	57.2	3.0	39.8
7+	80.7	33.4	6.5	60.2


Мөн интернэттэй өрхөөс 35 хүртэлх насны өрхийн тэргүүлэгчтэй нийт өрхийн 88.6 хувь, 35-59 насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн 81.7 хувь, 60 ба түүнээс дээш насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн 67.1 хувь нь интернэттэй байна. 35 хүртэлх насны өрхийн тэргүүнтэй өрхийн 39.0 хувь нь хөдөлгөөнт өргөн зурвасын интернэт, 55.0 хувь нь суурин интернэт, 6.0 хувь нь газрын утасгүй өргөн зурвасын интернэт ашиглаж байгаа бол 60 ба түүнээс дээш насны өрхийн тэргүүнтэй өрхийн 31.9 хувь нь суурин өргөн зурвасын интернэт, 67.1 хувь нь суурин интернэт, 3.9 хувь нь газрын утасгүй өргөн зурвасын интернэттэй байна.

ХҮСНЭГТ 24. ИНТЕРНЭТТЭЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, үйлчилгээний төрөл, өрхийн тэргүүлэгчийн насны бүлгээр

Насны бүлэг	Улс	Суурин интернэтийн сүлжээ	Газрын утасгүй өргөн зурвасын сүлжээ	Хөдөлгөөнт өргөн зурвасын сүлжээ (3G, 4G, USB, модем)
35 хүртэлх	88.6	55.0	6.0	39.0
35-59	81.7	55.8	5.6	38.6
60+	67.1	64.2	3.9	31.9

Интернэттэй өрхөөс боловсролгүй гэж хариулсан өрхийн 49.4 хувь, бага боловсролтойнх 44.7 хувь, суурь боловсролтойнх 64.2 хувь, бүрэн дунд боловсролтойнх 77.0 хувь, техник, мэргэжлийн боловсролтойнх 84.5 хувь, дээд боловсролтойнх 94.1 хувь нь тус тус интернэттэй байна.

ЗУРАГ 13. ИНТЕРНЭТТЭЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшнээр



## 2.7 Интернэтэд холбогдоогүй өрх


Монгол Улсын нийт өрхийн 20.0 хувь нь интернэтэд холбогдоогүй байна. Интернэтэд холбогдоогүй өрхөөс 49.9 хувь нь интернэт шаардлагагүй, 27.4 хувь нь интернэтийн үйлчилгээ авах боломжгүй газар амьдардаг, 7.2 хувь нь тоног төхөөрөмжийн өртөг өндөр, 7.0 хувь нь соёлын шалтгаан, 6.3 хувь нь өөр газарт интернэтэд холбогддог, 6.0 хувь нь үйлчилгээний өртөг өндөр гэж хариулсан байна.

ЗУРАГ 14. ИНТЕРНЭТЭД ХОЛБОГДООГҮЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, шалтгаанаар



Харин хотод амьдардаг нийт өрхийн 13.7 хувь, хөдөө амьдардаг нийт өрхийн 37.0 хувь нь интернэтэд холбогдоогүй байна. Хотын өрхийн 62.0 хувь нь интернэт шаардлагагүй, 8.9 хувь нь тоног төхөөрөмжийн өртөг өндөр, 8.8 хувь нь үйлчилгээний өртөг өндөр, 8.0 хувь нь интернэтийн үйлчилгээ авах боломжгүй газар амьдардаг, 7.0 хувь нь соёлын шалтгаантай байгаа бол хөдөөгийн өрхийн 46.8 хувь нь интернэтийн үйлчилгээ авах боломжгүй газар амьдардаг, 37.7 хувь нь интернэт шаардлагагүй, 7.1 хувь нь соёлын шалтгаантай, 6.0 хувь нь цахилгааны хангамжгүй гэж хариулсан байна.

ЗУРАГ 15. ИНТЕРНЭТЭД ХОЛБОГДООГҮЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, хот,хөдөөгөөр



Улаанбаатарын өрхийн 6.8 хувь, аймгийн төвийн өрхийн 23.8 хувь, сумын төвийн өрхийн 24.7 хувь, хөдөөгийн багийн өрхийн 44.5 хувь нь интернетэд холбогдоогүй байна. Улаанбаатарын өрхийн хувьд 61.0 хувь нь интернет шаардлагагүй, 11.1 хувь нь тоног, төхөөрөмжийн өртөг өндөр, 9.6 хувь нь үйлчилгээний өртөг өндөр гэж үзсэн бол хөдөөгийн багийн өрхүүдийн 55.5 хувь нь интернетийн үйлчилгээ авах боломжгүй газар амьдардаг, 29.2 хувь нь интернет шаардлагагүй гэж үзсэн байна.

ХҮСНЭГТ 25. ИНТЕРНЭТЭД ХОЛБОГДООГҮЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, суурьшлаар

Сууршил	Нийт	Интернет шаардлагагүй	Өөр газарт интернетэд холбогддог	Тоног төхөөрөмжийн өртөг өндөр	Үйлчилгээний өртөг өндөр	Үйлчилгээ авах боломжгүй газар амьдардаг	Соёлын шалтгаан
Улс	20.0	49.9	6.3	7.2	6.0	27.4	7.0
Улаанбаатар	6.8	61.0	4.8	11.1	9.6	4.5	3.9
Аймгийн төв	23.8	62.5	8.4	8.0	8.5	9.4	8.2
Сумын төв	24.7	62.7	4.9	4.9	5.8	20.9	6.4
Хөдөөгийн баг	44.5	29.2	5.4	5.6	2.4	55.5	7.3

Баруун бүсийн нийт өрхийн 30.4 хувь, Хангайн бүсийн 35.9 хувь, Зүүн бүсийн 31.9 хувь, Төвийн бүсийн 22.2 хувь нь интернетэд холбогдоогүй байна.

ХҮСНЭГТ 26. ИНТЕРНЭТЭД ХОЛБОГДООГҮЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, бүсээр

Бүс	Нийт	Интернет шаардлагагүй	Өөр газарт интернетэд холбогддог	Тоног төхөөрөмжийн өртөг өндөр	Үйлчилгээний өртөг өндөр	Үйлчилгээ авах боломжгүй газар амьдардаг	Соёлын шалтгаан
Баруун	30.4	51.7	3.3	7.1	3.1	33.9	7.5
Хангай	35.9	42.2	6.7	5.5	7.0	35.4	9.0
Төв	22.2	56.1	9.3	7.5	5.1	19.3	6.3
Зүүн	31.9	46.2	7.0	7.0	5.1	33.9	5.5
Улаанбаатар	6.8	61.0	4.8	11.1	9.6	4.5	3.9

Интернэтэд холбогдоогүй өрхөөс 1-2 гишүүнтэй нийт өрхийн 31.2 хувь, 3-4 гишүүнтэй өрхийн 14.9 хувь, 5-6 гишүүнтэй өрхийн 14.7 хувь, 7 ба түүнээс дээш гишүүнтэй өрхийн 19.3 хувь нь интернэтэд холбогдоогүй өрх байна. Өрхийн ам бүл нь 1-2 гишүүнтэй өрхийн 58.6 хувь нь интернэт шаардлагагүй, 19.5 хувь нь үйлчилгээ авах боломжгүй газарт амьдарч байгаа бол 7 ба түүнээс дээш өрхийн гишүүдтэй өрхийн 30.0 хувь нь интернэт шаардлагагүй, 28.6 хувь нь тоног, төхөөрөмжийн өртөг өндөр, 37.5 хувь нь үйлчилгээ авах боломжгүй газарт амьдардаг гэжээ.

**ХҮСНЭГТ 27. ИНТЕРНЭТЭД ХОЛБОГДООГҮЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, өрхийн гишүүдийн тоогоор**

Гишүүд	Нийт	Интернэт шаардлагагүй	Өөр газарт интернэтэд холбогддог	Тоног төхөөрөмжийн өртөг өндөр	Үйлчилгээний өртөг өндөр	Үйлчилгээ авах боломжгүй газар амьдардаг	Соёлын шалтгаан
1-2	31.2	58.6	5.5	4.8	6.1	19.5	10.7
3-4	14.9	46.8	7.5	5.8	7.1	29.2	4.0
5-6	14.7	35.1	6.4	12.3	2.6	43.7	2.2
7+	19.3	30.0	6.3	28.6	13.9	37.5	8.1


Мөн интернэтэд холбогдоогүй өрхөөс 35 хүртэлх насны өрхийн тэргүүлэгчтэй нийт өрхийн 11.4 хувь, 35-59 насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн 18.3 хувь, 60 ба түүнээс дээш насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн 32.9 хувь нь интернэтэд холбогдоогүй байна. 35 хүртэлх насны өрхийн тэргүүнтэй өрхийн 35.0 хувь нь интернэт шаардлагагүй, 40.3 хувь нь үйлчилгээ авах боломжгүй газарт амьдарч байгаа бол 60 ба түүнээс дээш насны өрхийн тэргүүнтэй өрхийн 62.5 хувь нь интернэт шаардлагагүй, 13.5 хувь нь үйлчилгээ авах боломжгүй газарт амьдарч байгаа, 5.2 хувь нь тоног, төхөөрөмжийн өртөг өндөр байна гэж хариулсан байна.

**ХҮСНЭГТ 28. ИНТЕРНЭТЭД ХОЛБОГДООГҮЙ ӨРХ, өрхийн тэргүүлэгчийн насны бүлгээр**

Насны бүлэг	Нийт	Интернэт шаардлагагүй	Өөр газарт интернэтэд холбогддог	Тоног төхөөрөмжийн өртөг өндөр	Үйлчилгээний өртөг өндөр	Үйлчилгээ авах боломжгүй газар амьдардаг	Соёлын шалтгаан
35 хүртэлх	11.4	35.0	8.3	7.5	3.5	40.3	0.3
35-59	18.3	44.7	7.4	8.3	7.9	33.7	4.4
60+	32.9	62.5	3.9	5.2	3.8	13.5	13.3

Интернэтэд холбогдоогүй өрхөөс боловсролгүй гэж хариулсан өрхийн 50.6 хувь, бага боловсролтойнх 55.3 хувь, суурь боловсролтойнх 35.8 хувь, бүрэн дунд боловсролтойнх 23.0 хувь, техник, мэргэжлийн боловсролтойнх 15.5 хувь, дээд боловсролтойнх 5.9 хувь нь интернэтэд холбогдоогүй байна.

**ЗУРАГ 16. ИНТЕРНЭТЭД ХОЛБОГДООГҮЙ ӨРХ, өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшнээр**






## 2.8 Өрхийн МХХТ-ийн үйлчилгээнд зарцуулсан зардлын дундаж хэмжээ

Монгол Улсын нэг өрх МХХТ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авахад зарцуулсан зардлын дундаж хэмжээ сүүлийн 3 сард 246.1 мянган төгрөг байна. Өрхийн МХХТ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зардлын 69.9 хувийг харилцаа холбооны үйлчилгээний, 29.0 хувийг тоног төхөөрөмжийн, 0.5 хувийг программ хангамжийн зардал тус тус эзэлж байна.

ЗУРАГ 17. ӨРХИЙН МХХТ-ИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ, сүүлийн 3 сард, дүнд эзлэх хувиар



Өрхийн МХХТ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зардлын дундаж хэмжээ хотод амьдардаг өрхийнх сүүлийн 3 сард 262.7 мянга, хөдөө амьдардаг өрхийнх 201.3 мянган төгрөг байна. Хотын өрхийн дундаж зардлын 70.5 хувийг харилцаа холбооны үйлчилгээний зардал, 28.3 хувь нь тоног төхөөрөмж, хэрэгслийн зардал эзэлж байгаа бол хөдөөгийн өрхийн дундаж зардлын 31.4 хувь нь тоног төхөөрөмж, хэрэгслийн зардал байна.

ХҮСНЭГТ 29. ӨРХИЙН МХХТ-ИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ, сүүлийн 3 сард, хот, хөдөөгөөр

	Нийт зардал, мянган төгрөг	Тоног төхөөрөмж, хэрэгслийн зардал	Программ хангамжийн зардал	Харилцаа холбооны үйлчилгээний зардал	Видео тоглоомын программ хангамжийн зардал	Контентийн үйлчилгээний зардал
Хот	262.7	28.3	0.5	70.5	0.1	0.6
Хөдөө	201.3	31.4	0.4	67.8	0.1	0.3

Өрхийн МХХТ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зардлын дундаж хэмжээ Улаанбаатарын өрхийн хувьд сүүлийн 3 сард 295.9 мянга, аймгийн төвийн өрхийнх 214.5 мянга, сумын төвийн өрхийнх 226.7 мянга, хөдөөгийн багийн өрхийнх 185.9 мянган төгрөг байна. Улаанбаатар хотод амьдардаг өрхийн МХХТ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зардлын 70.9 хувь нь харилцаа холбооны үйлчилгээний зардал, 27.8 хувь нь тоног төхөөрөмж, хэрэгслийн зардал, 0.7 хувь нь контент, программ хангамжийн зардал байна.

ХҮСНЭГТ 30. ӨРХИЙН МХХТ-ИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ, сүүлийн 3 сард, төрөл, суурьшлаар

Сууршил	Нийт зардал, мянган төгрөг	Тоног төхөөрөмж, хэрэгслийн зардал	Программ хангамжийн зардал	Харилцаа холбооны үйлчилгээний зардал	Видео тоглоомын программ хангамжийн зардал	Контентын үйлчилгээний зардал
Улс	246.1	29.0	0.5	69.9	0.1	0.5
Улаанбаатар	295.9	27.8	0.7	70.9	0.1	0.6
Аймгийн төв	214.5	29.4	0.2	69.7	0.1	0.6
Сумын төв	226.7	30.4	0.3	68.7	0.0	0.5
Хөдөөгийн баг	185.9	32.1	0.4	67.2	0.1	0.2

Сүүлийн 3 сард өрхийн МХХТ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд зарцуулсан зардлын дундаж хэмжээг бүсээр задлан харвал, Төвийн бүсийн өрх 228.8 мянга, Баруун бүсийн өрх 201.2 мянга, Зүүн бүсийн өрх 205.4 мянга, Хангайн бүсийн өрх 196.2 мянган төгрөгийг МХХТ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээ авахад зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 31. ӨРХИЙН МХХТ-ИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ, сүүлийн 3 сард, бүсээр

Бүс	Нийт зардал, мянган төгрөг	Тоног төхөөрөмж, хэрэгслийн зардал	Программ хангамжийн зардал	Харилцаа холбооны үйлчилгээний зардал	Видео тоглоомын программ хангамжийн зардал	Контентын үйлчилгээний зардал
Баруун	201.2	26.2	0.1	73.7	0.0	0.1
Хангай	196.2	31.1	0.3	67.7	0.1	0.8
Төв	228.8	32.0	0.3	67.1	0.1	0.5
Зүүн	205.4	30.9	0.2	68.5	0.1	0.4
Улаанбаатар	295.9	27.8	0.7	70.9	0.1	0.6

МХХТ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд зарцуулсан зардлын дундаж хэмжээ 1-2 гишүүнтэй өрхийнх 179.3 мянга, 3-4 гишүүнтэй өрхийнх 272.2 мянга, 5-6 гишүүнтэй өрхийнх 281.3 мянга, 7 ба түүнээс дээш гишүүнтэй өрхийнх 278.4 мянган төгрөг байна. Өрхийн ам бүл нь 5-6 гишүүнтэй өрхийн хувьд харилцаа холбооны үйлчилгээний зардалд нийт зардлынхаа 72.1 хувийг зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 32. ӨХИЙН МХХТ-ИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ, сүүлийн 3 сард, өрхийн гишүүдийн тоогоор

Гишүүд	Нийт зардал, мянган төгрөг	Тоног төхөөрөмж, хэрэгслийн зардал	Программ хангамжийн зардал	Харилцаа холбооны үйлчилгээний зардал	Видео тоглоомын программ хангамжийн зардал	Контентын үйлчилгээний зардал
1-2	179.3	28.2	0.6	70.5	0.1	0.5
3-4	272.2	30.3	0.5	68.6	0.0	0.5
5-6	281.3	26.8	0.4	72.1	0.1	0.6
7+	278.4	34.0	0.5	65.3	-	0.3

Мөн өрхийн МХХТ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зардлын дундаж хэмжээ 35 хүртэлх насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийнх 283.2 мянга, 35-59 насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийнх 262.9 мянга, 60 ба түүнээс дээш насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийнх 160.4 мянган төгрөг байна. Харин 35 хүртэлх насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн МХХТ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээг авахад зарцуулж байгаа зардлын хэмжээ 60 ба түүнээс дээш насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн зардлаас 76.6 хувиар илүү байна. Мөн залуу өрхийн


хувьд программ хангамж, контентын үйлчилгээ, видео тоглоомын зардал нь нийт зардлын дүндээ бусад насны бүлгээс өндөр байна.

ХҮСНЭГТ 33. МХХТ-ИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ, сүүлийн 3 сард, өрхийн тэргүүлэгчийн насны бүлгээр

Насны бүлэг	Нийт зардал, мянган төгрөг	Тоног төхөөрөмж, хэрэгслийн зардал	Программ хангамжийн зардал	Харилцаа холбооны үйлчилгээний зардал	Видео тоглоомын программ хангамжийн зардал	Контентын үйлчилгээний зардал
35 хүртэлх	283.2	31.4	0.6	67.3	0.1	0.7
35-59	262.9	30.1	0.5	68.8	0.1	0.5
60+	160.4	19.9	0.5	79.0	0.1	0.5

Өрхийн МХХТ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зардлын дундаж хэмжээ боловсролгүй гэж хариулсан өрхийнх 128.9 мянга, бага боловсролтойнх 160.1 мянга, суурь боловсролтойнх 151.3 мянга, бүрэн дунд боловсролтойнх 225.3 мянга, техник, мэргэжлийн боловсролтойнх 235.0 мянга, дээд боловсролтойнх 322.4 мянган төгрөг байна. МХХТ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд зарцуулсан зардлын хэмжээ боловсролын түвшинтэй шууд хамааралтай байгаа нь доорх зургаас харагдаж байна.

ЗУРАГ 18. ӨРХИЙН МХХТ-ИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНД ЗАРЦУУЛСАН ЗАРДЛЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ, сүүлийн 3 сард, өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшнээр, мянган төгрөгөөр



### 3. ХҮН АМЫН МХХТ-ИЙН ХЭРЭГЛЭЭ, ХҮРТЭЭМЖ

Энэ бүлэгт Монгол Улсын 15 ба түүнээс дээш насны хүн амын компьютер, гар утас, интернэт, цахим худалдааны сүүлийн 3 сарын хэрэглээ болон МХХТ-ийн ур чадварын талаарх мэдээллийг багтаасан болно.

#### 3.1 Компьютерын хэрэглээ


Өрх болон хүн амын мэдээлэл, харилцаа, холбоо технологийн хэрэглээний түүвэр судалгааны дүнгээр, Монгол Улсын 15 ба түүнээс дээш насны нийт иргэдийн 31.5 хувь нь сүүлийн 3 сард компьютер хэрэглэсэн байна.

Компьютер хэрэглэсэн иргэдээс хотод амьдардаг иргэдийн 36.1 хувь, хөдөө амьдардаг иргэдийн 19.1 хувь нь компьютер хэрэглэсэн байна.

Улаанбаатар хотын иргэдийн 39.0 хувь, аймгийн төвийн иргэдийн 31.7 хувь, сумын төвийн иргэдийн 25.7 хувь, хөдөөгийн багийн иргэдийн 15.3 хувь нь тус тус компьютер хэрэглэсэн байна.

Төвийн бүсийн нийт иргэдийн 28.4 хувь, Хангайн бүсийн 26.5 хувь, Зүүн бүсийн 26.0 хувь, Баруун бүсийн 21.0 хувь нь компьютер хэрэглэсэн байна.


ЗУРАГ 19. КОМПЬЮТЕР ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, бүс, суурьшлаар



Компьютер хэрэглэсэн иргэдээс эрэгтэйчүүдийн 31.2 хувь, эмэгтэйчүүдийн 31.9 хувь нь сүүлийн 3 сард компьютер хэрэглэсэн байна.


Мөн 35 хүртэлх насныхны 40.3 хувь, 35-59 насныхны 28.3 хувь, 60 буюу түүнээс дээш насныхны 9.7 хувь нь тус тус компьютер хэрэглэсэн байна.

ЗУРАГ 20. КОМПЬЮТЕР ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, хүйс, насны бүлгээр



Компьютер хэрэглэсэн иргэдээс боловсролгүй гэж хариулсан иргэдийн 2.4 хувь, бага боловсролтойнх 2.8 хувь, суурь боловсролтойнх 9.7 хувь, бүрэн дунд боловсролтойнх 19.9 хувь, техник, мэргэжлийн боловсролтойнх 20.4 хувь, дээд боловсролтойнх 57.2 хувь нь тус тус компьютер хэрэглэсэн байна.

ЗУРАГ 21. КОМПЬЮТЕР ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард боловсролын



### 3.2 Интернэтийн хэрэглээ

ОУЦХБ-аас 2020 онд гаргасан цахим хөгжлийг хэмжих тайланд дэлхийн хүн амын 51.0 хувь нь интернэт хэрэглэж, үүнээс 69.0 хувь нь 15-24 насны залуучууд байна. Гэсэн хэдий ч дэлхий дахинд 3.7 тэрбум хүн, үүнээс 369 сая залуучууд интернэт хэрэглээгүй байна.

Интернэтийн хэрэглээ улс орны хөгжлийн нөхцөл байдлаас шалтгаалж харилцан адилгүй байна. Өндөр хөгжилтэй орнуудын хүн амын 87.0 хувь нь интернэт хэрэглэж байгаа бол хөгжиж буй орнуудын хүн амын 44.0 хувь интернэт хэрэглэж байна.


Манай улсын хувьд хүн амын дийлэнх буюу 84.3 хувь нь сүүлийн 3 сард интернэт хэрэглэсэн байна.

Интернэт хэрэглэсэн иргэдээс хотод амьдардаг иргэдийн 88.6 хувь, хөдөө амьдардаг иргэдийн 72.6 хувь нь интернэт хэрэглэсэн байна.

Улаанбаатар хотын иргэдийн 92.4 хувь, аймгийн төвийн иргэдийн 83.1 хувь, сумын төвийн иргэдийн 82.5 хувь, хөдөөгийн багийн иргэдийн 66.8 хувь нь тус тус интернэт хэрэглэсэн байна.

Харин төвийн бүсийн нийт иргэдийн 84.2 хувь, Зүүн бүсийн 79.9 хувь, Баруун бүсийн 72.3 хувь, Хангайн бүсийн 76.1 хувь нь интернэт хэрэглэсэн байна.

ЗУРАГ 22. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, хот, хөдөө, бүс, суурьшлаар




Дэлхийн хэмжээнд интернэт хэрэглэдэг хүмүүсийн дунд хүйсийн ялгаа их байна. Ялангуяа хөгжиж буй орнуудад энэ үзэгдэл түгээмэл байна. ОУЦХБ-аас 2020 онд гаргасан цахим хөгжлийг хэмжих тайланд дэлхийн нийт эрэгтэй хүмүүсийн 55 хувь, эмэгтэйчүүдийн 48.0 хувь нь интернэт хэрэглэдэг үүнээс Ази-Номхон далайн орнуудын эрэгтэй хүмүүсийн 49.0 хувь, эмэгтэйчүүдийн 40.0 хувь нь интернэт хэрэглэдэг дүн гарсан байна.

Монгол Улсын хувьд эрэгтэйчүүдийн 85.1 хувь, эмэгтэйчүүдийн 83.6 хувь нь сүүлийн 3 сард интернэт хэрэглэсэн байна. Судалгааны дүнгээс харахад интернэт хэрэглэсэн хүмүүсийн дунд хүйсийн ялгаа байхгүй байна.


Мөн 35 хүртэлх насныхны 92.8 хувь, 35-59 насныхны 83.4 хувь, 60 буюу түүнээс дээш насныхны 54.7 хувь нь интернэт хэрэглэсэн байна.

ЗУРАГ 23. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, хүйс, насны бүлгээр



Интернэт хэрэглэсэн иргэдээс боловсролгүй гэж хариулсан иргэдийн 38.9 хувь, бага боловсролтойнх 40.3 хувь, суурь боловсролтойнх 66.7 хувь, бүрэн дунд боловсролтойнх 82.7 хувь, техник, мэргэжлийн боловсролтойнх 84.5 хувь, дээд боловсролтойнх 95.6 хувь нь тус тус интернэт хэрэглэсэн байна.


ЗУРАГ 24. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, хүйс, насны бүлгээр



### 3.2.1 Интернэт хэрэглээ, зорилгоор

Монгол Улсын 15 ба түүнээс дээш насны иргэдээс 95.0 хувь нь мэдээлэл авах, 53.2 хувь нь харилцаа холбоо, хамтын ажиллагааг хөгжүүлэх, 42.9 хувь нь цахим худалдаа хийх, 33.3 хувь нь үзвэр үйлчилгээ хүлээн авах, 28.0 хувь нь мэдлэг, боловсролоо дээшлүүлэх, 6.0 хувь нь дижитал контент үүсгэх зорилгоор хэрэглэсэн байна.

ЗУРАГ 25. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, хэрэглэсэн зорилгоор



Хотод амьдардаг иргэдийн 95.4 хувь нь мэдээлэл авах, 56.0 хувь нь харилцаа холбоо, хамтын ажиллагааг хөгжүүлэх, 46.0 хувь нь цахим худалдаа хийх, 34.0 хувь нь үзвэр үйлчилгээ хүлээн авах зорилготой хэрэглэсэн бол хөдөө амьдардаг иргэдийн 94.0 хувь нь мэдээлэл авах, 43.9 хувь нь харилцаа холбоо, хамтын ажиллагааг хөгжүүлэх, 32.6 хувь нь цахим худалдаа хийх зорилгоор хэрэглэсэн байна.

ХҮСНЭГТ 34. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, хот, хөдөөгөөр

	Улс	Мэдээлэл авах	Харилцаа холбоо, хамтын ажиллагаа	Цахим худалдаа	Боловсрол	Үзвэр үйлчилгээ	Дижитал контент үүсгэх	Бусад
Хот	88.6	95.4	56.0	46.0	29.1	34.0	6.5	4.3
Хөдөө	72.6	94.0	43.9	32.6	24.3	30.7	4.5	4.0

Улаанбаатар хотын интернэт хэрэглэсэн иргэдээс 97.6 хувь нь мэдээлэл авах, 61.3 хувь нь харилцаа холбоо, хамтын ажиллагааг хөгжүүлэх, 51.4 хувь нь цахим худалдаа хийх, аймгийн төвийн иргэдийн 91.8 хувь нь мэдээлэл авах, 47.1 хувь нь харилцаа холбоо, хамтын ажиллагааг хөгжүүлэх, 32.6 хувь нь цахим худалдаа хийх, сумын төвийн иргэдийн 96.6 хувь нь мэдээлэл авах, 50.8 хувь нь харилцаа холбоо, хамтын ажиллагааг хөгжүүлэх, 37.7 хувь нь цахим худалдаа хийх, хөдөөгийн багийн иргэдийн 92.1 хувь нь мэдээлэл авах, 39.0 хувь нь харилцаа холбоо, хамтын ажиллагааг хөгжүүлэх, 29.0 хувь нь цахим худалдаа хийх зорилгоор интернэт хэрэглэсэн байна.

ХҮСНЭГТ 35. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, суурьшлаар

Суурьшил	Улс	Мэдээлэл авах	Харилцаа холбоо, хамтын ажиллагаа	Цахим худалдаа	Боловсрол	Үзвэр үйлчилгээ	Дижитал контент үүсгэх	Бусад
Улаанбаатар	92.4	97.6	61.3	51.4	28.3	36.1	7.8	5.0
Аймгийн төв	83.1	91.8	47.1	37.0	30.5	30.6	4.2	3.2
Сумын төв	82.5	96.6	50.8	37.7	27.6	26.0	4.4	1.8
Хөдөөгийн баг	66.8	92.1	39.0	29.0	21.9	34.1	4.6	5.5


Хангайн бүсийн нийт иргэдийн 90.6 хувь нь мэдээлэл авах, 41.6 хувь нь харилцаа холбоо, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Төвийн бүсийн 95.3 хувь нь мэдээлэл авах, 49.9 хувь нь харилцаа холбоо, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Зүүн бүсийн 93.5 хувь нь мэдээлэл авах, 48.9 хувь нь харилцаа холбоо, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Баруун бүсийн 92.0 хувь нь мэдээлэл авах, 44.1 хувь нь харилцаа холбоо, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх зорилгоор интернэт хэрэглэсэн байна.

ХҮСНЭГТ 36. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, бүсээр

Бүс	Улс	Мэдээлэл авах	Харилцаа холбоо, хамтын ажиллагаа	Цахим худалдаа	Боловсрол	Үзвэр үйлчилгээ	Дижитал контент үүсгэх	Бусад
Баруун	72.3	92.0	44.1	22.6	21.8	26.2	5.5	2.6
Хангай	76.1	90.6	41.6	32.2	27.4	26.4	2.5	3.4
Төв	84.2	95.3	49.9	44.8	28.6	37.6	5.2	4.1
Зүүн	79.9	93.5	48.9	39.3	35.3	32.8	5.3	4.2
Улаанбаатар	92.4	97.6	61.3	51.4	28.3	36.1	7.8	5.0

Монгол Улсын 15 ба түүнээс дээш насны нийт эрэгтэйчүүдийн 94.8 хувь нь мэдээлэл авах, 36.2 хувь нь үзвэр үйлчилгээ, эмэгтэйчүүдийн 95.3 хувь нь мэдээлэл авах, 43.3 хувь нь интернэт худалдаа хийх зорилгоор интернэт хэрэглэсэн байна.

ЗУРАГ 26. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, хүйсээр



Мөн 35 хүртэлх насныхны 46.4 хувь нь цахим худалдаа хийх, 41.7 хувь нь үзвэр үйлчилгээ хүлээн авах, 36.7 хувь нь мэдлэг, боловсролоо дээшлүүлэх, 35-59 насныхны 42.3 хувь нь цахим худалдаа хийх, 26.3 хувь нь үзвэр үйлчилгээ хүлээн авах, 21.7 хувь нь мэдлэг, боловсролоо дээшлүүлэх, 60 ба түүнээс дээш насныхны 22.9 хувь нь цахим худалдаа хийх, 18.5 хувь нь үзвэр үйлчилгээ хүлээн авах, 7.6 хувь нь боловсролоо дээшлүүлэх зорилгоор интернэт хэрэглэсэн байна.

ХҮСНЭГТ 37. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, насны бүлгээр

Насны бүлэг	Улс	Мэдээлэл авах	Харилцаа холбоо, хамтын ажиллагаа	Цахим худалдаа	Боловсрол	Үзвэр үйлчилгээ	Дижитал контент үүсгэх	Бусад
35 хүртэлх	92.8	94.1	53.9	46.4	36.7	41.7	8.7	5.1
35-59	83.4	96.4	53.1	42.3	21.7	26.3	3.8	3.7
60+	54.7	93.7	49.0	22.9	7.6	18.5	1.2	1.9



Интернэт хэрэглэсэн иргэдээс боловсролгүй гэж хариулсан иргэдийн 70.3 хувь нь мэдээлэл авах, 16.6 хувь нь мэдлэг, боловсролоо дээшлүүлэх, бүрэн дунд боловсролтой иргэдийн 94.4 хувь нь мэдээлэл авах, 26.7 хувь нь мэдлэг, боловсролоо дээшлүүлэх, дээд боловсролтой иргэдийн 96.9 хувь нь мэдээлэл авах, 31.2 хувь нь цахим худалдаа хийх зорилгоор хэрэглэсэн байна.


ХҮСНЭГТ 38. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, боловсролын түвшнээр

Боловсролын түвшин	Улс	Мэдээлэл авах	Харилцаа холбоо, хамтын ажиллагаа	Цахим худалдаа	Боловсрол	Үзвэр үйлчилгээ	Дижитал контент үүсгэх	Бусад
Боловсролгүй	38.9	70.3	49.3	5.8	16.6	21.5	-	-
Бага	40.3	91.8	51.2	37.9	10.5	22.8	0.3	1.6
Суурь	66.7	90.6	47.1	20.9	37.1	31.3	2.1	2.4
Бүрэн дунд	82.7	94.4	45.6	36.2	26.7	33.3	4.6	4.5
Техник, мэргэжил	84.5	94.8	49.0	35.6	14.4	31.3	5.8	2.7
Дээд	95.6	96.9	63.6	55.7	31.2	34.5	8.6	4.6

### 3.2.2 Интернет хэрэглээ, байршлаар

Манай улсын 15 ба түүнээс дээш насны нийт амын 95.6 хувь нь гэртээ, 37.5 хувь нь ажлын байранд, 8.9 хувь нь боловсролын байгууллагад, 8.0 хувь нь бусдын гэрт, 13.7 хувь нь өөр газарт тус тус интернэт хэрэглэсэн байна.

ЗУРАГ 27. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, байршлаар



Хотод амьдардаг иргэдийн 97.6 хувь нь гэртээ, 41.3 хувь нь ажлын байранд, 8.6 хувь нь боловсролын байгууллагад, 7.1 хувь нь бусдын гэрт, хөдөө амьдардаг иргэдийн 89.1 хувь нь гэртээ, 24.8 хувь нь ажлын байранд, 11.1 хувь нь бусдын гэрт, 9.6 хувь нь боловсролын байгууллагад интернэт хэрэглэсэн байна.

ХҮСНЭГТ 39. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард хот, хөдөөгөөр

	Улс	Гэртээ	Ажлын байранд	Боловсролын байгууллагад	Бусдын гэрт	Төлбөртэй интернэттэй газар	Бусад
Хот	88.6	97.6	41.3	8.6	7.1	0.6	12.8
Хөдөө	72.6	89.1	24.8	9.6	11.1	0.4	17.0

Улаанбаатар хотын иргэдийн 98.5 хувь нь гэртээ, 45.1 хувь нь ажлын байранд, 8.1 хувь нь бусдын гэрт, 7.7 хувь нь боловсролын байгууллагад, аймгийн төвийн иргэдийн 96.1 хувь нь гэртээ, 35.0 хувь нь ажлын байранд, 10.1 хувь нь боловсролын байгууллагад, 5.3 хувь нь бусдын гэрт, сумын төвийн иргэдийн 95.8 хувь нь гэртээ, 33.7 хувь нь ажлын байранд, хөдөөгийн багийн иргэдийн 84.3 хувь нь гэртээ, 18.4 хувь нь ажлын байранд, 13.2 хувь нь бусдын гэрт интернэт хэрэглэсэн байна.

ХҮСНЭГТ 40. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, суурьшлаар

Суурьшил	Улс	Гэртээ	Ажлын байранд	Боловсролын байгууллагад	Бусдын гэрт	Төлбөртэй интернэттэй газар	Бусад
Улаанбаатар	92.4	98.5	45.1	7.7	8.1	0.5	15.6
Аймгийн төв	83.1	96.1	35.0	10.1	5.3	0.7	8.1
Сумын төв	82.5	95.8	33.7	9.4	8.1	0.2	13.1
Хөдөөгийн баг	66.8	84.3	18.4	9.8	13.2	0.6	19.7


Төвийн бүсийн нийт иргэдийн 96.3 хувь нь гэртээ, 38.6 хувь нь ажлын байранд, Зүүн бүсийн 90.7 хувь нь гэртээ, 29.8 хувь нь ажлын байранд, Баруун бүсийн 93.3 хувь нь гэртээ, 24.4 хувь нь ажлын байранд, Хангайн бүсийн 90.9 хувь нь гэртээ, 27.4 хувь нь ажлын байрандаа интернэт хэрэглэсэн байна.

ХҮСНЭГТ 41. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, бүсээр

Бүс	Улс	Гэртээ	Ажлын байранд	Боловсролын байгууллагад	Бусдын гэрт	Төлбөртэй интернэттэй газар	Бусад
Баруун	72.3	93.3	24.4	9.8	2.9	0.3	8.2
Хангай	76.1	90.9	27.4	10.2	8.3	0.8	12.1
Төв	84.2	96.3	38.6	8.3	9.7	0.7	12.8
Зүүн	79.9	90.7	29.8	12.8	10.0	0.2	15.8
Улаанбаатар	92.4	98.5	45.1	7.7	8.1	0.5	15.6

Интернэт хэрэглэсэн иргэдээс эрэгтэйчүүдийн 95.3 хувь нь гэртээ, 40.0 хувь нь ажлын байранд, эмэгтэйчүүдийн 96.0 хувь нь гэртээ, 35.1 хувь нь ажлын байранд интернэт хэрэглэсэн байна.

ЗУРАГ 28. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, хүйсээр



Мөн 35 хүртэлх насныхны 95.3 хувь нь гэртээ, 38.3 хувь нь ажлын байранд, 14.6 хувь нь боловсролын байгууллагад, 35-59 насныхны 95.5 хувь нь гэртээ, 41.2 хувь нь ажлын

байранд, 7.1 хувь нь бусдын гэрт, 60 буюу түүнээс дээш насныхны 98.1 хувь нь гэртээ, 10.2 хувь нь ажлын байранд, 2.9 бусдын гэрт интернэт хэрэглэсэн байна.

ХҮСНЭГТ 42. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, насны бүлгээр

Насны бүлэг	Улс	Гэртээ	Ажлын байранд	Боловсролын байгууллагад	Бусдын гэрт	Төлбөртэй интернэттэй газар	Бусад
35 хүртэлх	92.8	95.3	38.3	14.6	9.5	0.6	18.2
35-59	83.4	95.5	41.2	3.9	7.1	0.5	10.5
60+	54.7	98.1	10.2	0.6	2.9	0.2	2.8

15 ба түүнээс дээш насны иргэдээс боловсролгүй гэж хариулсан иргэдийн 95.2 хувь нь гэртээ, 6.3 хувь нь ажлын байранд, бүрэн дунд боловсролтой иргэдийн 94.7 хувь нь гэртээ, 25.9 хувь нь ажлын байранд, дээд боловсролтой иргэдийн 97.6 хувь нь гэртээ, 56.6 хувь нь ажлын байрандаа интернэт хэрэглэсэн байна.


ХҮСНЭГТ 43. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, боловсролын түвшнээр

Боловсролын түвшин	Улс	Гэртээ	Ажлын байранд	Боловсролын байгууллагад	Бусдын гэрт	Төлбөртэй интернэттэй газар	Бусад
Боловсролгүй	38.9	95.2	6.3	7.8	1.9	-	5.1
Бага	40.3	85.7	12.8	-	8.6	-	12.4
Суурь	66.7	91.2	8.7	13.2	5.6	0.4	15.2
Бүрэн дунд	82.7	94.7	25.9	12.0	9.3	0.7	15.2
Техник, мэргэжил	84.5	96.5	36.3	4.8	6.8	0.1	14.3
Дээд	95.6	97.6	56.6	5.8	7.2	0.5	11.9

### 3.2.3 Интернэт хэрэглээ, давтамжаар

Интернэт хэрэглэсэн иргэдээс 84.5 хувь нь өдөр бүр, 12.2 хувь нь долоо хоногт наад зах нь нэг удаа, 3.3 хувь нь сард наад зах нь нэг удаагийн давтамжтайгаар интернэт хэрэглэсэн гэж хариулсан байна.

ЗУРАГ 29. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, давтамжаар



Хотод амьдардаг иргэдийн 88.7 хувь нь өдөр бүр, 9.7 хувь нь долоо хоногт наад зах нь 1 удаа, 1.6 хувь нь сард наад зах нь 1 удаа интернэт хэрэглэсэн бол хөдөө амьдардаг иргэдийн 70.6 хувь нь өдөр бүр, 20.4 хувь нь долоо хоногт наад зах нь 1 удаа, 9.0 хувь нь сард наад зах нь 1 удаа интернэт хэрэглэсэн байна.

ХҮСНЭГТ 44. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, хот, хөдөөгөөр

	Улс	Өдөр бүр	Долоо хоногт наад зах нь 1 удаа	Сард наад зах нь 1 удаа
Хот	88.6	88.7	9.7	1.6
Хөдөө	72.6	70.6	20.4	9.0

Улаанбаатарын иргэдийн 91.0 хувь нь өдөр бүр, 7.6 хувь нь долоо хоногт наад зах нь 1 удаа, 1.4 хувь нь сард наад зах нь 1 удаа, аймгийн төвийн иргэдийн 84.9 хувь нь өдөр бүр, 13.2 хувь нь долоо хоногт наад зах нь нэг удаа, 1.9 хувь нь сард наад зах нь 1 удаа, сумын төвийн иргэдийн 82.0 хувь нь өдөр бүр, 14.9 хувь нь долоо хоногт наад зах нь 1 удаа, хөдөөгийн багийн иргэдийн 62.5 хувь нь өдөр бүр, 24.3 хувь нь долоо хоногт наад зах нь нэг удаа интернэт хэрэглэсэн байна.

ХҮСНЭГТ 45. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, суурьшлаар

Суурьшил	Улс	Өдөр бүр	Долоо хоногт наад зах нь 1 удаа	Сард наад зах нь 1 удаа
Улаанбаатар	92.4	91.0	7.6	1.4
Аймгийн төв	83.1	84.9	13.2	1.9
Сумын төв	82.5	82.0	14.9	3.1
Хөдөөгийн баг	66.8	62.5	24.3	13.2


Төвийн бүсийн нийт иргэдийн 84.3 хувь нь өдөр бүр, 11.8 хувь нь долоо хоногт наад зах нь 1 удаа, Зүүн бүсийн 78.8 хувь нь өдөр бүр, 16.5 хувь нь долоо хоногт наад зах нь 1 удаа, Хангайн бүсийн 76.4 хувь нь өдөр бүр, 16.8 хувь нь долоо хоногт наад зах нь 1 удаа, Баруун бүсийн 73.6 хувь нь өдөр бүр, 22.2 хувь нь долоо хоногт наад зах нь 1 удаа интернэт хэрэглэсэн байна.

ХҮСНЭГТ 46. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, бүсээр

Бүс	Улс	Өдөр бүр	Долоо хоногт наад зах нь 1 удаа	Сард наад зах нь 1 удаа
Баруун	72.3	73.6	22.2	4.2
Хангай	76.1	76.4	16.8	6.8
Төв	84.2	84.3	11.8	3.9
Зүүн	79.9	78.8	16.5	4.7
Улаанбаатар	92.4	91.0	7.6	1.4

Мөн эрэгтэйчүүдийн 83.7 хувь нь өдөр бүр, 12.9 хувь нь долоо хоногт наад зах нь 1 удаа, эмэгтэйчүүдийн 85.2 хувь нь өдөр бүр, 11.5 хувь нь долоо хоногт наад зах нь 1 удаа интернэт хэрэглэсэн байна.

ЗУРАГ 30. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, хүйсээр



Мөн 35 хүртэлх насныхны 90.8 хувь нь өдөр бүр, 6.8 хувь нь долоо хоногт наад зах нь 1 удаа, 35-59 насныхны 79.4 хувь нь өдөр бүр, 16.4 хувь нь долоо хоногт наад зах нь 1 удаа, 60 буюу түүнээс дээш насныхны 73.5 хувь нь өдөр бүр, 22.7 хувь нь долоо хоногт наад зах нь 1 удаа интернэт хэрэглэсэн байна.

ХҮСНЭГТ 47. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, насны бүлгээр

Насны бүлэг	Улс	Өдөр бүр	Долоо хоногт наад зах нь 1 удаа	Сард наад зах нь 1 удаа
35 хүртэлх	92.8	90.8	6.8	2.4
35-59	83.4	79.4	16.4	4.3
60+	54.7	73.5	22.7	3.8

15 ба түүнээс дээш насны нийт иргэдээс боловсролгүй гэж хариулсан иргэдийн 36.6 хувь нь өдөр бүр, 55.4 хувь нь долоо хоногт наад зах нь 1 удаа, бүрэн дунд боловсролтой иргэдийн 79.8 хувь нь өдөр бүр, 15.8 хувь нь долоо хоногт наад зах нь 1 удаа, дээд боловсролтой иргэдийн 94.1 хувь нь өдөр бүр, 5.0 хувь нь долоо хоног наад зах нь 1 удаа интернэт хэрэглэсэн байна.


ХҮСНЭГТ 48. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, боловсролын түвшнээр

Боловсролын түвшин	Улс	Өдөр бүр	Долоо хоногт наад зах нь 1 удаа	Сард наад зах нь 1 удаа
Боловсролгүй	38.9	36.6	55.4	8.0
Бага	40.3	56.4	25.4	18.3
Суурь	66.7	73.6	18.1	8.3
Бүрэн дунд	82.7	79.8	15.8	4.4
Техник, мэргэжил	84.5	79.0	18.7	2.2
Дээд	95.6	94.1	5.0	0.9

### 3.2.4 Интернэт хэрэглээ, холбогдсон төхөөрөмж

Монгол Улсын 15 ба түүнээс дээш насны нийт иргэдийн 99.2 хувь нь гар утас, 17.4 хувь нь зөөврийн компьютер, 11.5 хувь нь суурин компьютер, 1.1 хувь нь таблет/ай пад, 0.2 хувь нь бусад зөөврийн төхөөрөмж хэрэглэж интернэтэд холбогдсон байна.

ЗУРАГ 31. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард



Хотод амьдардаг иргэдийн 99.0 хувь нь гар утас, 19.2 хувь нь зөөврийн компьютер, 12.9 хувь нь суурин компьютер, хөдөө амьдардаг иргэдийн 99.6 хувь нь гар утас, 11.4 хувь нь зөөврийн компьютер, 6.8 хувь нь суурин компьютер хэрэглэж интернэтэд холбогдсон байна.

ХҮСНЭГТ 49. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, хот, хөдөөгөөр

	Улс	Гар утас	Таблет	Зөөврийн компьютер	Суурин компьютер	Бусад зөөврийн төхөөрөмжүүд
Хот	88.6	99.0	1.4	19.2	12.9	0.2
Хөдөө	72.6	99.6	0.2	11.4	6.8	0.0

Улаанбаатар хотын иргэдийн 99.3 хувь нь гар утас, 20.7 хувь нь зөөврийн компьютер, 14.6 хувь нь суурин компьютер, аймгийн төвийн иргэдийн 98.6 хувь нь гар утас, 16.7 хувь нь зөөврийн компьютер, 10.1 хувь нь суурин компьютер, сумын төвийн иргэдийн 99.6 хувь нь гар утас, 12.0 хувь нь зөөврийн компьютер, 11.2 хувь нь суурин компьютер, хөдөөгийн багийн иргэдийн 99.6 хувь нь гар утас, 11.0 хувь нь зөөврийн компьютер, 3.7 хувь нь суурин компьютер хэрэглэж интернэтэд холбогдсон байна.

ХҮСНЭГТ 50. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, суурьшлаар

Суурьшил	Улс	Гар утас	Таблет	Зөөврийн компьютер	Суурин компьютер	Бусад зөөврийн төхөөрөмжүүд
Улаанбаатар	92.4	99.3	1.9	20.7	14.6	0.3
Аймгийн төв	83.1	98.6	0.6	16.7	10.1	0.2
Сумын төв	82.5	99.6	0.3	12.0	11.2	0.1
Хөдөөгийн баг	66.8	99.6	0.2	11.0	3.7	0.0


Баруун бүсийн нийт иргэдийн 99.8 хувь нь гар утас, 12.2 хувь нь зөөврийн компьютер, Төвийн бүсийн 99.3 хувь нь гар утас, 15.5 хувь нь зөөврийн компьютер, Зүүн бүсийн 98.3 хувь нь гар утас, 15.9 хувь нь зөөврийн компьютер, Хангайн бүсийн 98.8 хувь нь гар утас, 14.0 хувь нь зөөврийн компьютер хэрэглэж интернэтэд холбогдсон байна.

ХҮСНЭГТ 51. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, бүсээр

Бүс	Улс	Гар утас	Таблет	Зөөврийн компьютер	Суурин компьютер	Бусад зөөврийн төхөөрөмжүүд
Баруун	72.3	99.8	0.3	12.2	3.9	0.1
Хангай	76.1	98.8	0.1	14.0	8.9	-
Төв	84.2	99.3	0.5	15.5	11.3	0.2
Зүүн	79.9	98.3	1.1	15.9	9.5	0.2
Улаанбаатар	92.4	99.3	1.9	20.7	14.6	0.3

Эрэгтэйчүүдийн 99.3 хувь нь гар утас, 16.3 хувь нь зөөврийн компьютер, эмэгтэйчүүдийн 99.0 хувь нь гар утас, 18.4 хувь нь зөөврийн компьютер хэрэглэж интернэтэд холбогдсон байна.

ЗУРАГ 32. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, хүйсээр



Мөн 35 хүртэлх насныхны 99.4 хувь нь гар утас, 21.4 хувь нь зөөврийн компьютер, 35-59 насныхны 99.0 хувь нь гар утас, 14.9 хувь нь зөөврийн компьютер, 60 буюу түүнээс дээш насныхны 98.7 хувь нь гар утас, 5.7 хувь нь зөөврийн компьютер хэрэглэж интернэтэд холбогдсон байна.

ХҮСНЭГТ 52. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, насны бүлгээр

Насны бүлэг	Улс	Гар утас	Таблет	Зөөврийн компьютер	Суурин компьютер	Бусад зөөврийн төхөөрөмжүүд
35 хүртэлх	92.8	99.4	0.8	21.4	11.1	0.2
35-59	83.4	99.0	1.5	14.9	12.8	0.2
60+	54.7	98.7	0.7	5.7	6.7	-

Интернэт хэрэглэсэн иргэдээс боловсролгүй гэж хариулсан иргэдийн 100.0 хувь нь гар утас, бүрэн дунд боловсролтой иргэдийн 99.2 хувь нь гар утас, 10.2 хувь нь зөөврийн компьютер, дээд боловсролтой иргэдийн 99.1 хувь нь гар утас, 29.9 хувь нь зөөврийн компьютер хэрэглэж интернэтэд холбогдсон байна.

ХҮСНЭГТ 53. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, боловсролын түвшнээр

Боловсролын түвшин	Улс	Гар утас	Таблет	Зөөврийн компьютер	Суурин компьютер	Бусад зөөврийн төхөөрөмжүүд
Боловсролгүй	38.9	100.0	-	-	-	-
Бага	40.3	100.0	-	1.2	3.9	0.2
Суурь	66.7	99.3	-	6.7	1.9	-
Бүрэн дунд	82.7	99.2	0.9	10.2	4.9	0.1
Техник, мэргэжил	84.5	99.0	-	7.1	8.8	0.1
Дээд	95.6	99.1	1.8	29.9	21.3	0.4

### 3.2.5 Интернет хэрэглээгүй иргэд


Монгол Улсын 15 ба түүнээс дээш насны нийт иргэдийн 15.7 хувь нь интернэт хэрэглээгүй байна. Интернет хэрэглээгүй иргэдийн 45.9 хувь нь интернэтийг хэрхэн ашиглахаа мэддэггүй, 37.2 хувь нь интернэт шаардлагагүй, 22.1 хувь нь интернэтийн үйлчилгээ авах боломжгүй газар амьдардаг, 6.9 хувь нь интернэт ашиглах зардал өндөр, 4.6 хувь нь интернэт гэж юу болохыг мэдэхгүй гэж хариулсан байна.

### ЗУРАГ 33. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭЭГҮЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ



Хотод амьдардаг иргэдийн 11.4 хувь, хөдөө амьдардаг иргэдийн 27.4 хувь нь интернэт хэрэглээгүй байна. Хотод амьдардаг иргэдийн 52.0 хувь нь интернэтийг хэрхэн ашиглахаа мэддэггүй, 46.4 хувь нь интернэт шаардлагагүй, 7.3 хувь нь интернэт ашиглах зардал өндөр зэрэг шалтгаантай байгаа бол хөдөөгийн өрхийн 42.8 хувь нь интернэтийн үйлчилгээ авах боломжгүй газар амьдардаг, 38.9 хувь нь интернэтийг хэрхэн ашиглахаа мэддэггүй, 26.9 хувь нь интернэт шаардлагагүй, 6.3 хувь нь интернэт ашиглах зардал өндөр гэж хариулсан байна.

### ЗУРАГ 34. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭЭГҮЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, хот, хөдөөгөөр



Улаанбаатар хотын иргэдийн 7.6 хувь, аймгийн төвийн иргэдийн 16.9 хувь, сумын төвийн иргэдийн 17.5 хувь, хөдөөгийн багийн иргэдийн 33.2 хувь нь интернэтэд хэрэглээгүй байна. Улаанбаатар хотын хувьд 53.5 хувь нь интернэт хэрхэн ашиглахаа мэддэггүй, 42.0 хувь нь интернэт шаардлагагүй гэж үзсэн бол хөдөөгийн багийн өрхүүдийн 49.8 хувь нь интернэтийн үйлчилгээ авах боломжгүй газар амьдардаг, 37.0 хувь нь интернэт хэрхэн ашиглахаа мэддэггүй, 21.3 хувь нь интернэт шаардлагагүй гэж үзсэн байна.

### ХҮСНЭГТ 54. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭЭГҮЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, суурьшлаар

Суурьшил	Улс	Интернэт шаардлаг агүй	Хэрхэн ашиглахаа мэддэггүй	Ашиглах зардал өндөр	Нууцлал, аюулгүй байдлын асуудал	Үйлчилгээ авах боломжгүй газар амьдардаг	Соёлын шалтгаан	Интернэт гэж юу болохыг мэдэхгүй	Интернэт ашиглахыг хориглодог
Улаанбаатар	7.6	42.0	53.5	5.8	-	2.5	4.4	2.6	4.4
Аймгийн төв	16.9	49.4	51.0	8.3	0.1	4.6	1.8	7.9	0.6
Сумын төв	17.5	45.4	45.2	9.2	0.4	19.5	2.5	5.6	-
Хөдөөгийн баг	33.2	21.3	37.0	5.5	-	49.8	1.5	2.6	0.2



Хангайн бүсийн иргэдийн 23.9 хувь, Баруун бүсийн иргэдийн 27.7 хувь, Зүүн бүсийн иргэдийн 20.1 хувь, Төвийн бүсийн иргэдийн 15.8 хувь нь интернэт хэрэглээгүй байна. Төвийн бүсийн 51.3 хувь нь интернэтийг хэрхэн ашиглахаа мэдэхгүй, 53.0 хувь нь интернэт шаардлагагүй, Хангайн бүсийн 42.6 хувь нь интернэт хэрхэн ашиглахаа мэдэхгүй, 28.0 хувь нь интернэт шаардлагагүй, Зүүн бүсийн 37.2 хувь нь интернэтийг хэрхэн ашиглахаа мэддэггүй, 37.3 хувь нь интернэт шаардлагагүй гэж үзсэн байна.

#### ХҮСНЭГТ 55. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭЭГҮЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, бүсээр

Бүс	Улс	Интернэт шаардлагагүй	Хэрхэн ашиглахаа мэддэггүй	Ашиглах зардал өндөр	Нууцлал, аюулгүй байдлын асуудал	Үйлчилгээ авах боломжгүй газар амьдардаг	Соёлын шалтгаан	Интернэт гэж юу болохыг мэдэхгүй	Интернэт ашиглахыг хориглодог
Баруун	27.7	34.1	43.1	9.6	-	28.5	1.0	1.4	0.9
Хангай	23.9	28.0	42.6	5.8	0.2	33.8	2.2	7.1	0.1
Төв	15.8	53.0	51.3	7.2	0.2	13.2	2.5	7.0	0.2
Зүүн	20.1	37.3	37.2	5.3	-	27.8	0.9	5.0	-
Улаанбаатар	7.6	42.0	53.5	5.8	-	2.5	4.4	2.6	4.4

Нийт 15 ба түүнээс дээш настай эрэгтэйчүүдийн 14.9 хувь, эмэгтэйчүүдийн 16.4 хувь нь интернэт хэрэглээгүй байна. Интернэт хэрэглээгүй эрэгтэй хүмүүсийн 44.6 хувь, эмэгтэй хүмүүсийн 46.9 хувь нь интернэтийг хэрхэн ашиглахыг мэддэггүй гэж хариулжээ.

#### ЗУРАГ 35. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭЭГҮЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, хүйсээр



Мөн 35 хүртэлх насныхны 7.2 хувь, 35-59 насныхны 16.6 хувь, 60 буюу түүнээс дээш насныхны 45.3 хувь нь интернэт хэрэглээгүй байна. 35 хүртэлх насны интернэт хэрэглээгүй иргэдийн 35.6 хувь нь интернэтийн үйлчилгээ авах боломжгүй газар амьдардаг, 35-59 насныхны 40.0 хувь, 60 буюу түүнээс дээш насныхны 60.5 хувь нь интернэтийг хэрхэн ашиглахаа мэддэггүй гэж тус тус хариулжээ.

#### ХҮСНЭГТ 56. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭЭГҮЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, насны бүлгээр

Насны бүлэг	Улс	Интернэт шаардлагагүй	Хэрхэн ашиглахаа мэддэггүй	Ашиглах зардал өндөр	Нууцлал, аюулгүй байдлын асуудал	Үйлчилгээ авах боломжгүй газар амьдардаг	Соёлын шалтгаан	Интернэт гэж юу болохыг мэдэхгүй
35хүртэлх	7.2	29.7	35.3	8.7	-	35.6	3.1	3.9
35-59	16.6	37.0	40.2	8.8	0.2	27.5	2.0	3.5
60+	45.3	42.4	60.5	3.0	-	5.9	2.3	6.6

Интернэт хэрэглээгүй иргэдээс боловсролгүй гэж хариулсан иргэдийн 61.1 хувь, бүрэн дунд боловсролтой иргэдийн 17.3 хувь, дээд боловсролтой иргэдийн 4.4 хувь нь интернэт хэрэглээгүй байна. Боловсролгүй иргэдийн 58.8 хувь нь интернэтийг хэрхэн ашиглахыг мэддэггүй, бүрэн дунд боловсролтой иргэдийн 43.5 хувь нь интернэт шаардлагагүй, дээд боловсролтой иргэдийн 12.1 хувь нь интернэтийн үйлчилгээ авах боломжгүй газар амьдардаг гэж хариулсан байна.

#### ХҮСНЭГТ 57. ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭЭГҮЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, боловсролын түвшнээр


Боловсролын түвшин	Улс	Интернэт шаардлагагүй	Хэрхэн ашиглахаа мэддэггүй	Ашиглах зардал өндөр	Нууцлал, аюулгүй байдлын асуудал	Үйлчилгээ авах боломжгүй газар амьдардаг	Соёлын шалтгаан	Интернэт гэж юу болохыг мэдэхгүй
Боловсролгүй	61.1	22.1	58.8	12.3	-	36.1	-	6.4
Бага	59.7	23.2	52.1	4.9	0.3	31.9	0.8	4.8
Суурь	33.3	25.5	45.3	6.1	-	24.3	6.1	5.2
Бүрэн дунд	17.3	43.5	39.1	9.2	0.0	21.1	1.9	5.3
Техник, мэргэжил	15.5	27.9	66.0	2.1	0.3	14.3	1.1	2.1
Дээд	4.4	55.4	54.4	0.5	-	12.1	1.0	0.9

### 3.3 Үүрэн утасны хэрэглээ

ОУЦХБ-аас 2020 онд гаргасан цахим хөгжлийг хэмжих тайланд дэлхийн хэмжээнд 100 хүнд ногдох үүрэн утас 105 байна.

Монгол Улсын 15 ба түүнээс дээш насны нийт хүн амын 98.0 хувь нь үүрэн утас, үүнээс 90.4 хувь нь ухаалаг утас сүүлийн 3 сард хэрэглэсэн байна. Үүрэн утас болон ухаалаг утас хэрэглэдэг иргэдээс хотод амьдардаг нийт иргэдийн 98.8 хувь нь үүрэн утас, үүнээс 93.1 хувь нь ухаалаг утастай бол хөдөө амьдардаг нийт иргэдийн 95.8 хувь нь үүрэн утас, үүнээс 82.7 хувь нь ухаалаг утас хэрэглэдэг байна.

ЗУРАГ 36. ҮҮРЭН БОЛОН УХААЛАГ УТАСТАЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, хот, хөдөөгөөр




Үүрэн ба ухаалаг утас хэрэглэдэг иргэдээс Улаанбаатарын иргэдийн 99.2 хувь нь үүрэн утас, үүнээс 94.7 хувь нь ухаалаг утас, аймгийн төвийн иргэдийн 98.3 хувь нь үүрэн утас, 90.8 хувь нь ухаалаг утас, сумын төвийн иргэдийн 97.2 хувь нь үүрэн утас, 91.7 хувь нь ухаалаг утас, хөдөөгийн багийн иргэдийн 95.0 хувь нь үүрэн утас, 77.5 хувь нь ухаалаг утас хэрэглэдэг байна.

ЗУРАГ 37. ҮҮРЭН УТАСТАЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, суурьшлаар




Төвийн бүсийн иргэдийн 97.2 хувь нь үүрэн утас, үүнээс 92.8 хувь нь ухаалаг утас, Хангайн бүсийн 98.2 хувь нь үүрэн утас, үүнээс 83.5 хувь нь ухаалаг утас, Зүүн бүсийн 97.2 хувь нь үүрэн утас, үүнээс 87.8 хувь нь ухаалаг утас, Баруун бүсийн 95.4 хувь нь үүрэн утас, үүнээс 84.9 хувь нь ухаалаг утас хэрэглэж байна.

ЗУРАГ 38. ҮҮРЭН БОЛОН УХААЛАГ УТАСТАЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, бүсээр



35 хүртэлх насны иргэдийн 98.4 хувь нь үүрэн утас, үүнээс 95.8 хувь нь ухаалаг утас, 35-59 насны иргэдийн 98.4 хувь нь үүрэн утас, үүнээс 89.8 хувь нь ухаалаг утас, 60 ба түүнээс дээш насны иргэдийн 95.1 хувь нь үүрэн утас, үүнээс 71.0 хувь нь ухаалаг утастай байна.

ЗУРАГ 39. ҮҮРЭН БОЛОН УХААЛАГ УТАСТАЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, насны бүлгээр



Үүрэн ба ухаалаг утас хэрэглэдэг иргэдээс боловсролгүй гэж хариулсан иргэдийн 79.5 хувь нь үүрэн утас, 54.8 хувь нь ухаалаг утас, бага боловсролтойнх 91.9 хувь нь үүрэн утас, 60.4 хувь нь ухаалаг утас, суурь боловсролтойнх 94.8 хувь нь үүрэн утас, 79.7 хувь нь ухаалаг утас, бүрэн дунд боловсролтойнх 98.5 хувь нь үүрэн утас, 89.3 хувь нь ухаалаг утас, техник, мэргэжлийн боловсролтойнх 98.8 хувь нь үүрэн утас, 88.6 хувь нь ухаалаг утас, дээд боловсролтойнх 99.0 хувь нь үүрэн утас, 97.8 хувь нь тус тус ухаалаг утас хэрэглэж байна.


ХҮСНЭГТ 58. ҮҮРЭН БОЛОН УХААЛАГ УТАСТАЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, боловсролын түвшнээр

Боловсролын түвшин	Үүрэн утас	Ухаалаг утас
Боловсролгүй	79.5	54.8
Бага	91.9	60.4
Суурь	94.8	79.7
Бүрэн дунд	98.5	89.3
Техник, мэргэжлийн	98.8	88.6
Дээд	99.0	97.8

### 3.3.1 Өөрийн өмчийн үүрэн утасны хэрэглээ

Монгол Улсын үүрэн утастай 15 ба түүнээс дээш насны хүн амын 94.3 хувь нь өөрийн өмчийн үүрэн утас, 89.7 хувь нь өөрийн өмчийн ухаалаг үүрэн утастай байна. Өөрийн өмчийн үүрэн ба ухаалаг утастай иргэдээс Улаанбаатар хотын иргэдийн 93.1 хувь нь үүрэн утас, 93.8 хувь нь ухаалаг утас, аймгийн төвийн иргэдийн 94.9 хувь нь үүрэн утас, 90.7 хувь нь ухаалаг утас, сумын төвийн иргэдийн 93.2 хувь нь үүрэн утас, 90.8 хувь нь ухаалаг утас, хөдөөгийн багийн иргэдийн 97.4 хувь нь үүрэн утас, 75.9 хувь нь ухаалаг утас хэрэглэдэг байна.

ЗУРАГ 40. ӨӨРИЙН ӨМЧИЙН ҮҮРЭН БОЛОН УХААЛАГ УТАСТАЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, суурьшлаар




Өөрийн өмчийн үүрэн ба ухаалаг утас хэрэглэдэг иргэдээс 35 хүртэлх насны иргэдийн 95.0 хувь нь үүрэн утас, 95.3 хувь нь ухаалаг утас, 35-59 насны иргэдийн 94.1 хувь нь үүрэн утас, 88.3 хувь нь ухаалаг утас, 60 ба түүнээс дээш насны иргэдийн 92.5 хувь нь үүрэн утас, 72.3 хувь нь ухаалаг утастай байна.

ХҮСНЭГТ 59. ӨӨРИЙН ӨМЧИЙН ҮҮРЭН БОЛОН УХААЛАГ УТАСТАЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, насны бүлгээр

Насны бүлэг	Өөрийн өмчийн үүрэн утас	Өөрийн өмчийн ухаалаг утас
35 хүртэлх	95.0	95.3
35-59	94.1	88.3
60+	92.5	72.3

Өөрийн өмчийн үүрэн ба ухаалаг утас хэрэглэдэг иргэдээс эрэгтэйчүүдийн 94.9 хувь нь үүрэн утас, 89.9 хувь нь ухаалаг утас, эмэгтэйчүүдийн 93.8 хувь нь үүрэн утас, 89.5 хувь нь ухаалаг утас хэрэглэдэг байна. Хэдийгээр эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс үүрэн утас бага эзэмшиж байгаа ч ухаалаг утсыг ижил хэмжээд эзэмшиж байна.

ЗУРАГ 41. ӨӨРИЙН ӨМЧИЙН ҮҮРЭН БОЛОН УХААЛАГ УТАСТАЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, хүйсээр



Өөрийн өмчийн үүрэн ба ухаалаг утас хэрэглэдэг иргэдээс боловсролгүй гэж хариулсан иргэдийн 96.3 хувь нь үүрэн утас, 53.1 хувь нь ухаалаг утас, бага боловсролтой 91.1 хувь нь үүрэн утас, 59.2 хувь нь ухаалаг утас, суурь боловсролтой 95.4 хувь нь үүрэн утас, 78.6 хувь нь ухаалаг утас, бүрэн дунд боловсролтой 96.0 хувь нь үүрэн утас, 88.4 хувь нь ухаалаг утас, техник, мэргэжлийн боловсролтой 97.0 хувь нь үүрэн утас, 88.6 хувь нь ухаалаг утас, дээд боловсролтой 91.6 хувь нь үүрэн утас, 97.3 хувь нь ухаалаг утас хэрэглэж байна.

ХҮСНЭГТ 60. ӨӨРИЙН ӨМЧИЙН ҮҮРЭН БОЛОН УХААЛАГ УТАСТАЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, боловсролын түвшнээр

Боловсролын түвшин	Үүрэн утас	Ухаалаг утас
Боловсролгүй	96.3	53.1
Бага	91.1	59.2
Суурь	95.4	78.6
Бүрэн дунд	96.0	88.4
Техник, мэргэжлийн	97.0	88.6
Дээд	91.6	97.3

### 3.4 Цахим худалдаа


Интернэт хэрэглээ нь бизнес эрхлэгчид болон иргэд хоорондын харилцаа, худалдааны хэлбэр, хандлагыг мэдэгдэхүйц өөрчилж байна. “UNCTAD” НҮБ-ын Худалдаа, Хөгжлийн Бага Хурлаас 2020 онд гаргасан мэдээллээр дэлхийн цахим худалдааны (e-commerce) борлуулалт 26.7 их наяд америк долларт хүрч, үүнээс 9.5 их наяд нь АНУ, 3.4 их наяд нь Япон Улс, 2.6 их наяд нь БНХАУ, 1.3 их наяд америк доллар нь БНСУ-д ногдож байна.

Цахим худалдаа гэдэг нь интернэтээр дамжуулан бараа бүтээгдэхүүн худалдан авах, үйлчилгээ авах, өөрийн барааг худалдах өгөгдөл дамжуулах үйл явц юм. Үүнийг цахим худалдаа, интернэт худалдаа, e-commerce гэж нэрлэж байна.

Өрхөд суурилсан өрх, хүн амын мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээний судалгаанд цахим худалдааны асуулгыг нэлээд оруулсан бөгөөд 15 ба түүнээс дээш насны хүн амын 29.9 хувь нь цахимаар бараа, үйлчилгээ худалдан авсан байна.


Цахим худалдаа хийсэн иргэдээс 55.7 хувь нь хувцас, гутал, спортын бараа, 46.2 хувь нь гэр ахуйн бараа, тавилга, 28.2 хувь нь гоо сайхны бүтээгдэхүүн, үйлчилгээ, 13.9 хувь нь хүнсний бүтээгдэхүүн, хоол захиалга, 10.9 хувь нь техник технологийн бараа, үйлчилгээ байна.

ЗУРАГ 42. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, худалдан авсан бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөр




Цахим худалдаа нь хүмүүсийн цаг хугацааг хэмнэж, ая тухтай байдлыг бий болгож өгдгөөрөө давуу талтай юм. Цахимаар бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авсан иргэдийн 75.3 хувь нь хувь хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж, 28.8 хувь нь шуудангаар, 7.8 хувь нь дэлгүүрт нь очиж, 5.2 хувь нь цахим хэлбэрээр бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хүлээн авсан байна.

ЗУРАГ 43. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, бүтээгдэхүүн, үйлчилгээ хүлээн авсан төрлөөр




Цахимаар бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авсан иргэдийн төлбөрийн гол хэлбэр нь дебет картын гүйлгээ, гар утасны дансны гүйлгээ, онлайн төлбөрийн үйлчилгээ байна.

ЗУРАГ 44. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ



Монгол Улсын нийт иргэдийн цахимаар бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авсан зардалд 50.0 мянгаас 100.0 мянган төгрөгийн худалдан авалт 29.1 хувь, 100.0 мянгаас 200.0 мянган төгрөгийн худалдан авалт 24.8 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 45. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, мянган төгрөг, зарцуулсан зардлын хэмжээгээр




Цахимаар бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авсан иргэдээс хотод амьдардаг иргэдийн 33.7 хувь, хөдөө амьдардаг иргэдийн 16.3 хувь нь цахимаар худалдан авалт хийсэн байна.

Улаанбаатарын иргэдийн 37.7 хувь, аймгийн төвийн иргэдийн 27.7 хувь, сумын төвийн иргэдийн 25.4 хувь, хөдөөгийн багийн иргэдийн 16.3 хувь нь цахимаар худалдан авалт хийсэн байна.

Төвийн бүсийн нийт иргэдийн 28.4 хувь, Зүүн бүсийн 25.1 хувь, Хангайн бүсийн 23.1 хувь, Баруун бүсийн 18.6 хувь нь цахимаар худалдан авалт хийсэн байна.


ЗУРАГ 46. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, хот, хөдөө, бүс, суурьшлаар



15 ба түүнээс дээш насны эрэгтэйчүүдийн 26.4 хувь, эмэгтэйчүүдийн 33.2 хувь цахимаар худалдан авалт хийсэн байна.

Мөн 35 хүртэлх насныхны 35.4 хувь, 35-59 насныхны 28.5 хувь, 60 буюу түүнээс дээш насныхны 13.8 хувь нь тус тус цахимаар худалдан авалт хийсэн байна.

ЗУРАГ 47. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, хүйс, насны бүлгээр




Цахимаар бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авсан иргэдээс боловсролгүй гэж хариулсан иргэдийн 7.9 хувь, бага боловсролтойнх 7.0 хувь, суурь боловсролтойнх 15.7 хувь, бүрэн дунд боловсролтойнх 24.0 хувь, техник, мэргэжлийн боловсролтойнх 25.3 хувь, дээд боловсролтойнх 44.4 хувь нь цахимаар худалдан авалт хийсэн байна.

### 3.4.1 Цахим худалдаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөр

Цахим худалдаа хийсэн иргэдээс 55.7 хувь нь хувцас, гутал, спортын бараа, 46.2 хувь нь гэр ахуйн бараа, тавилга, 28.2 хувь нь гоо сайхны бараа, үйлчилгээ, 13.9 хувь нь хүнсний бүтээгдэхүүн, хоол, 10.9 хувь нь техник технологийн бараа үйлчилгээ худалдан авсан байна.

ЗУРАГ 48. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, худалдан авсан бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөр



Хотод амьдардаг иргэдийн 54.5 хувь нь хувцас, гутал, спортын бараа, 47.4 хувь нь гэр ахуйн бараа, тавилга, 28.4 хувь нь гоо сайхны бүтээгдэхүүн үйлчилгээ, 15.1 хувь нь хүнсний бүтээгдэхүүн, хоол захиалсан бол хөдөө амьдардаг иргэдийн 61.7 хувь нь хувцас, гутал, спортын бараа, 40.4 хувь нь гэр ахуйн бараа, тавилга, 27.5 хувь нь гоо сайхны бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авсан байна.



ХҮСНЭГТ 61. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, хот, хөдөөгөөр

	Улс	Хүнсний бүтээгдэхүүн, хоол	Гэр ахуйн бараа, тавилга	Хувцас, гутал, спортын бараа	Техник технолог - ийн бараа	Гоо сайхны бүтээгдэхүүн	Ном, бичиг хэргийн бараа
Хот	33.7	15.1	47.4	54.5	11.1	28.4	7.6
Хөдөө	19.6	7.9	40.4	61.7	9.8	27.5	5.1

Цахим худалдаа хийсэн иргэдээс Улаанбаатарын иргэдийн 53.3 хувь нь гэр ахуйн бараа, тавилга, 52.5 хувь нь хувцас, гутал, спортын бараа, 26.1 хувь нь гоо сайхны бүтээгдэхүүн, үйлчилгээ, аймгийн төвийн иргэдийн 58.4 хувь нь хувцас, гутал, спортын бараа, 35.4 хувь нь гэр ахуйн бараа, тавилга, 32.9 хувь нь гоо сайхны бүтээгдэхүүн, үйлчилгээ, сумын төвийн иргэдийн 65.7 хувь нь хувцас, гутал, спортын бараа, 39.1 хувь нь гэр ахуйн бараа, тавилга, 25.1 хувь нь гоо сайхны бүтээгдэхүүн, үйлчилгээ, хөдөөгийн багийн иргэдийн 58.0 хувь нь хувцас, гутал, спортын бараа, 41.6 хувь нь гэр ахуйн бараа, тавилга, 29.7 хувь нь тус тус гоо сайхны бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авсан байна.

ХҮСНЭГТ 62. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, суурьшлаар

	Улс	Хүнсний бүтээгдэхүүн, хоол	Гэр ахуйн бараа, тавилга	Хувцас, гутал, спортын бараа	Техник технолог - ийн бараа	Гоо сайхны бүтээгдэхүүн	Ном, бичиг хэргийн бараа
Улаанбаатар	37.7	16.0	53.3	52.5	11.4	26.1	8.6
Аймгийн төв	27.7	13.5	35.4	58.4	10.6	32.9	5.7
Сумын төв	25.4	6.8	39.1	65.7	8.8	25.1	3.4
Хөдөө баг	16.3	8.9	41.6	58.0	10.7	29.7	6.6


Хангайн бүсийн нийт иргэдийн 56.6 хувь нь хувцас, гутал, спортын бараа, 29.4 хувь нь гоо сайхны бүтээгдэхүүн, үйлчилгээ, Төвийн бүсийн 61.4 хувь нь хувцас, гутал, спортын бараа, 2.7 хувь нь үзвэр, үйлчилгээ түүний тасалбар, Зүүн бүсийн 54.8 хувь нь хувцас, гутал, спортын бараа, 7.3 хувь нь ном, бичиг хэргийн бараа, Баруун бүсийн 66.6 хувь нь гутал, хувцас, спортын бараа, 12.9 хувь нь технологийн бараа, үйлчилгээ худалдан авсан байна.

ХҮСНЭГТ 63. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, бүсээр

	Улс	Хүнсний бүтээгдэхүүн, хоол	Гэр ахуйн бараа, тавилга	Хувцас, гутал, спортын бараа	Техник технолог - ийн бараа	Гоо сайхны бүтээгдэхүүн,	Ном, бичиг хэргийн бараа
Баруун	18.6	6.1	26.0	66.6	12.9	26.0	4.8
Хангай	23.1	11.9	40.8	56.6	12.1	29.4	5.4
Төв	28.4	12.1	41.1	61.4	7.9	28.2	5.1
Зүүн	25.1	14.3	35.0	54.8	8.2	45.3	7.3
Улаанбаатар	37.7	16.0	53.3	52.5	11.4	26.1	8.6

Цахим худалдаа хийсэн иргэдээс эрэгтэйчүүдийн 54.9 хувь нь хувцас, гутал, спортын бараа, 17.1 хувь нь техник, технологийн бараа, эмэгтэйчүүдийн 56.4 хувь нь хувцас, гутал, спортын бараа, 35.4 хувь нь гоо сайхны бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авсан байна.

ЗУРАГ 49. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, хүйсээр



Мөн 35 хүртэлх насныхан 60.2 хувь нь хувцас, гутал, спортын бараа, 37.8 хувь нь гэр ахуйн бараа, тавилга, 29.8 хувь нь гоо сайхны бүтээгдэхүүн үйлчилгээ, 35-59 насныхан 53.3 хувь нь хувцас, гутал, спортын бараа, 55.1 хувь нь гэр ахуйн бараа, тавилга, 27.0 хувь нь гоо сайхны бүтээгдэхүүн, үйлчилгээ, 60 буюу түүнээс дээш насныхан 58.3 хувь нь гэр ахуйн бараа, тавилга, 31.0 хувь нь хувцас, гутал, спортын бараа, 22.6 хувь нь гоо сайхны бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авсан байна.

ХҮСНЭГТ 64. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, насны бүлгээр

	Улс	Хүнсний бүтээгдэхүүн, хоол	Гэр ахуйн бараа, тавилга	Хувцас, гутал, спортын бараа	Техник технологийн бараа	Гоо сайхны бүтээгдэхүүн	Ном, бичиг хэргийн бараа
35хүртэл	35.4	14.2	37.8	60.2	11.2	29.8	7.7
35-59	28.5	13.2	55.1	53.3	10.5	27.0	7.1
60+	13.8	16.2	58.3	31.0	11.2	22.6	2.6

Цахим худалдаа хийсэн иргэдээс боловсролгүй гэж хариулсан иргэдийн 69.3 хувь нь гоо сайхны бүтээгдэхүүн, үйлчилгээ, 41.2 хувь нь гэр ахуйн бараа, тавилга, бүрэн дунд боловсролтой иргэдийн 55.1 хувь нь хувцас, гутал, спортын бараа, 39.6 хувь нь гоо сайхны бараа, үйлчилгээ, дээд боловсролтой иргэдийн 56.1 хувь нь хувцас, гутал, спортын бараа, 52.2 хувь нь гэр ахуйн бараа, тавилга худалдан авсан байна.


ХҮСНЭГТ 65. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, боловсролын түвшнээр

	Улс	Хүнсний бүтээгдэхүүн, хоол	Гэр ахуйн бараа, тавилга	Хувцас, гутал, спортын бараа	Техник технологийн бараа	Гоо сайхны бүтээгдэхүүн	Ном, бичиг хэргийн бараа
Боловсролгүй	7.9	10.5	41.2	10.5	-	69.3	-
Бага	7.0	5.7	42.2	68.7	17.5	19.4	6.1
Суурь	15.7	2.2	25.5	58.0	9.7	30.9	13.7
Бүрэн дунд	24.0	12.0	39.6	55.1	9.2	24.5	5.5
Техник, мэргэжлийн	25.3	9.0	48.7	54.1	7.9	27.2	2.7
Дээд	44.4	16.8	52.2	56.1	12.5	30.7	8.4

### 3.4.2 Цахим худалдаа, бүтээгдэхүүн, үйлчилгээ хүлээн авсан төрлөөр

. Цахимаар бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авсан иргэдийн 75.3 хувь нь хувь хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж, 28.8 хувь нь шуудангаар, 7.8 хувь нь дэлгүүрт нь очиж, 5.2 хувь нь цахим хэлбэрээр бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хүлээн авсан байна.

ЗУРАГ 50. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ,



Цахим худалдаа хийсэн иргэдээс хотод амьдардаг иргэдийн 77.6 хувь нь хувь-хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж, 26.5 хувь нь шуудангаар, 8.2 хувь нь дэлгүүрт нь очиж, 5.6 хувь нь цахим хэлбэрээр, хөдөө амьдардаг иргэдийн 64.2 хувь нь хувь-хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж, 39.8 хувь нь шуудангаар, 6.1 хувь нь дэлгүүрт нь очиж, 3.3 хувь нь цахим хэлбэрээр хүлээн авсан байна.

ХҮСНЭГТ 66. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, хот, хөдөөгөөр

	Улс	Шуудангаар хүргүүлж авсан	Дэлгүүрт нь очиж авсан	Цахим хэлбэрээр хүлээн авсан	Хувь хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж авсан	Бусад
Хот	33.7	26.5	8.2	5.6	77.6	1.6
Хөдөө	19.6	39.8	6.1	3.3	64.2	5.9

Цахим худалдаа хийсэн иргэдээс Улаанбаатарын иргэдийн 83.3 хувь нь хувь-хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж, 20.4 хувь нь шуудангаар, аймгийн төвийн иргэдийн 66.1 хувь нь хувь-хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж, 38.7 хувь нь шуудангаар, сумын төвийн иргэдийн 69.5 хувь нь хувь-хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж, 40.8 хувь нь шуудангаар, хөдөөгийн багийн иргэдийн 59.5 хувь нь хувь-хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж, 38.9 хувь нь шуудангаар хүлээн авсан байна.

ХҮСНЭГТ 67. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, суурьшлаар

	Улс	Шуудангаар хүргүүлж авсан	Дэлгүүрт нь очиж авсан	Цахим хэлбэрээр хүлээн авсан	Хувь хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж авсан	Бусад
Улаанбаатар	37.7	20.4	9.0	6.9	83.3	0.5
Аймгийн төв	27.7	38.7	6.4	3.0	66.1	4.0
Сумын төв	25.4	40.8	4.5	2.0	69.5	5.6
Хөдөөгийн баг	16.3	38.9	7.5	4.6	59.5	6.1


Төвийн бүсийн нийт иргэдийн 70.5 хувь нь хувь-хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж, 34.1 хувь нь шуудангаар, Зүүн бүсийн 65.7 хувь нь хувь-хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж, 41.2 хувь нь шуудангаар, Баруун бүсийн 67.4 хувь нь хувь-хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж, 40.4 хувь нь шуудангаар, Хангайн бүсийн 59.1 хувь нь хувь-хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж, 42.5 хувь нь шуудангаар хүлээн авсан байна.

**ХҮСНЭГТ 68. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, бүсээр**

	Улс	Шуудангаар хүргүүлж авсан	Дэлгүүрт нь очиж авсан	Цахим хэлбэрээр хүлээн авсан	Хувь хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж авсан	Бусад
Баруун	18.6	40.4	5.9	2.5	67.4	3.7
Хангай	23.1	42.5	5.9	1.6	59.1	4.1
Төв	28.4	34.1	4.6	3.7	70.5	5.7
Зүүн	25.1	41.2	11.7	6.0	65.7	4.9
Улаанбаатар	37.7	20.4	9.0	6.9	83.3	0.5

Цахим худалдаа хийсэн иргэдээс эрэгтэйчүүдийн 77.5 хувь нь хувь-хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж, 24.1 хувь нь шуудангаар, эмэгтэйчүүдийн 73.6 хувь нь хувь-хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж, 32.3 хувь нь шуудангаар хүлээн авсан байна.

**ЗУРАГ 51. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, хүйсээр**



Мөн 35 хүртэлх насныхны 70.9 хувь нь хувь-хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж, 32.2 хувь нь шуудангаар, 35-59 насныхны 80.2 хувь нь хувь-хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж, 25.3 хувь нь шуудангаар, 60 буюу түүнээс дээш насныхны 79.4 хувь нь хувь-хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж, 23.0 хувь нь шуудангаар бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хүлээн авсан байна.

**ХҮСНЭГТ 69. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, насны бүлгээр**

	Улс	Шуудангаар хүргүүлж авсан	Дэлгүүрт нь очиж авсан	Цахим хэлбэрээр хүлээн авсан	Хувь хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж авсан	Бусад
35 хүртэлх	35.4	32.2	9.2	8.1	70.9	1.9
35-59	28.5	25.3	6.2	1.9	80.2	3.0
60+	13.8	23.0	6.8	2.7	79.4	2.5

Цахим худалдаа хийсэн иргэдээс боловсролгүй гэж хариулсан иргэдийн 41.2 хувь нь хувь-хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж, 44.9 хувь нь шуудангаар, бүрэн дунд боловсролтой иргэдийн 76.0 хувь нь хувь-хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж, 27.5 хувь нь шуудангаар, дээд боловсролтой иргэдийн 74.3 хувь нь хувь-хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж, 30.4 хувь нь шуудангаар хүлээн авсан байна.


#### ХҮСНЭГТ 70. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР

	Улс	Шуудангаар хүргүүлж авсан	Дэлгүүрт нь очиж авсан	Цахим хэлбэрээр хүлээн авсан	Хувь хүргэлт буюу нийлүүлэгчээс шууд хүргүүлж авсан	Бусад
Боловсролгүй	7.9	44.9	24.4	-	41.2	-
Бага	7.0	31.3	31.5	-	46.6	4.9
Суурь	15.7	36.7	5.0	-	72.0	7.3
Бүрэн дунд	24.0	27.5	7.1	4.7	76.0	2.7
Техник, мэргэжлийн	25.3	16.6	5.2	0.2	86.0	5.0
Дээд	44.4	30.4	8.4	6.7	74.3	1.4

### 3.4.3 Цахим худалдаа, төлбөрийн хэлбэрээр

Цахимаар бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авсан иргэдийн төлбөрийн гол хэлбэр нь дебет карт болон цахим банкны шилжүүлэг, гар утасны дансны гүйлгээ, онлайн төлбөрийн үйлчилгээ байна.

#### ЗУРАГ 52. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ



Цахимаар бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авсан иргэдээс хотод амьдардаг иргэдийн 52.4 хувь нь дебет карт болон цахим банкны шилжүүлэг, 26.5 хувь нь гар утасны дансны шилжүүлэг, 19.5 хувь нь онлайн төлбөрийн шилжүүлэг, 8.7 хувь нь бэлэн мөнгө, хөдөө амьдардаг иргэдийн 59.0 хувь нь дебет карт болон цахим банкны шилжүүлэг, 22.4 хувь нь гар утасны дансны шилжүүлэг, 19.6 хувь нь онлайн төлбөрийн шилжүүлэг, 4.8 хувь нь бэлэн мөнгөөр тооцоо хийсэн байна.

ХҮСНЭГТ 71. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, хот, хөдөөгөөр

	Улс	Бэлэн мөнгө	Онлайн зээлийн карт	Дебет карт эсвэл цахим банкны шилжүүлэг	Гар утасны данс	Онлайн төлбөрийн үйлчилгээ	Урьдчилсан төлбөрт бэлгийн карт эсвэл онлайн ваучер
Хот	33.7	8.7	1.3	52.4	26.5	19.5	0.4
Хөдөө	19.6	4.8	1.0	59.0	22.4	19.6	0.8

Улаанбаатарын иргэдийн 52.6 хувь нь дебет карт болон цахим банкны шилжүүлэг, 26.3 хувь нь гар утасны дансны шилжүүлэг, аймгийн төвийн иргэдийн 52.2 хувь нь дебет карт болон цахим банкны шилжүүлэг, 27.0 хувь нь гар утасны дансны шилжүүлэг, сумын төвийн иргэдийн 71.9 хувь нь дебет карт болон цахим банкны шилжүүлэг, 18.1 хувь нь гар утасны дансны шилжүүлэг, хөдөөгийн багийн иргэдийн 47.3 хувь нь дебет карт болон цахим банкны шилжүүлэг, 26.3 хувь нь гар утасны дансны шилжүүлгээр тооцоо хийсэн байна.

ХҮСНЭГТ 72. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, суурьшлаар

	Улс	Бэлэн мөнгө	Онлайн зээлийн карт	Дебет карт эсвэл цахим банкны шилжүүлэг	Гар утасны данс	Онлайн төлбөрийн үйлчилгээ	Урьдчилсан төлбөрт бэлгийн карт эсвэл онлайн ваучер
Улаанбаатар	37.7	9.9	1.1	52.6	26.3	18.1	0.4
Аймгийн төв	27.7	6.4	1.5	52.2	27.0	22.4	0.4
Сумын төв	25.4	4.4	1.0	71.9	18.1	10.5	0.1
Хөдөөгийн баг	16.3	5.2	1.1	47.3	26.3	27.8	1.5


Төвийн бүсийн нийт иргэдийн 53.6 хувь нь дебет карт болон цахим банкны шилжүүлэг, 27.1 хувь нь онлайн төлбөрийн шилжүүлэг, Зүүн бүсийн 59.3 хувь нь дебет карт болон цахим банкны шилжүүлэг, 21.0 хувь нь гар утасны дансны шилжүүлэг, Баруун бүсийн 50.7 хувь нь дебет карт болон цахим банкны шилжүүлэг, 14.1 онлайн төлбөрийн шилжүүлэг, Хангайн бүсийн 56.2 хувь нь дебет карт болон цахим банкны шилжүүлэг, 27.5 хувь нь гар утасны дансны шилжүүлгээр тооцоо хийсэн байна.

ХҮСНЭГТ 73. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, бүсээр

	Улс	Бэлэн мөнгө	Онлайн зээлийн карт	Дебет карт эсвэл цахим банкны шилжүүлэг	Гар утасны данс	Онлайн төлбөрийн үйлчилгээ	Урьдчилсан төлбөрт бэлгийн карт эсвэл онлайн ваучер
Баруун	18.6	6.7	0.5	50.7	30.0	14.1	-
Хангай	23.1	4.0	1.5	56.2	27.5	19.9	0.5
Төв	28.4	5.4	1.2	53.6	22.0	27.1	1.0
Зүүн	25.1	9.8	2.2	59.3	21.0	20.1	0.3
Улаанбаатар	37.7	9.9	1.1	52.6	26.3	18.1	0.4

Цахим худалдаа хийсэн иргэдээс эрэгтэйчүүдийн 50.1 хувь нь дебет карт болон цахим банкны шилжүүлэг, 25.3 хувь нь гар утасны дансны шилжүүлэг, эмэгтэйчүүдийн 56.1 хувь нь дебет карт болон цахим банкны шилжүүлэг, 26.2 хувь нь гар утасны дансны шилжүүлгээр тооцоо хийсэн байна.

ЗУРАГ 53. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, хүйсээр



Мөн 35 хүртэлх насныхны 56.0 хувь нь дебет карт болон цахим банкны шилжүүлэг, 22.6 хувь нь гар утасны дансны шилжүүлэг, 35-59 насныхны 51.2 хувь нь дебет карт болон цахим банкны шилжүүлэг, 29.7 хувь нь гар утасны дансны шилжүүлэг, 60 буюу түүнээс дээш насныхны 48.5 хувь нь дебет карт болон цахим банкны шилжүүлэг, 26.8 хувь нь гар утасны дансны шилжүүлгээр тооцоо хийсэн байна.

ХҮСНЭГТ 74. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, насны бүлгээр

	Улс	Бэлэн мөнгө	Онлайн зээлийн карт	Дебет карт эсвэл цахим банкны шилжүүлэг	Гар утасны данс	Онлайн төлбөрийн үйлчилгээ	Урьдчилсан төлбөрт бэлгийн карт эсвэл онлайн ваучер
35 хүртэлх	35.4	6.2	1.6	56.0	22.6	20.9	0.4
35-59	28.5	8.5	0.8	51.2	29.7	18.9	0.4
60+	13.8	22.8	0.6	48.5	26.8	10.7	0.8

Цахим худалдаа хийсэн иргэдээс боловсролгүй гэж хариулсан иргэдийн 55.1 хувь нь бэлэн мөнгө, 34.8 хувь нь дебет карт болон цахим банкны шилжүүлэг, бүрэн дунд боловсролтой иргэдийн 54.0 хувь нь дебет карт болон цахим банкны шилжүүлэг, 20.5 хувь нь гар утасны дансны шилжүүлэг, дээд боловсролтой иргэдийн 53.6 хувь нь дебет карт болон цахим банкны шилжүүлэг, 20.3 хувь нь онлайн төлбөрийн үйлчилгээг ашиглан тооцоо хийсэн байна.


ХҮСНЭГТ 75. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, боловсролын түвшнээр

	Улс	Бэлэн мөнгө	Онлайн зээлийн карт	Дебет карт эсвэл цахим банкны шилжүүлэг	Гар утасны данс	Онлайн төлбөрийн үйлчилгээ	Урьдчилсан төлбөрт бэлгийн карт эсвэл онлайн ваучер
Боловсролгүй	7.9	55.1	-	34.8	34.4	-	-
Бага	7.0	4.8	2.3	53.2	27.5	12.0	0.6
Суурь	15.7	5.1	2.1	51.9	22.3	20.2	-
Бүрэн дунд	24.0	11.9	1.4	54.0	20.5	19.3	0.5
Техник, мэргэжлийн	25.3	13.6	-	52.8	23.7	14.8	-
Дээд	44.4	4.8	1.1	53.6	30.0	20.3	0.6

### 3.4.4 Цахим худалдааны зардал


Монгол Улсын 15 ба түүнээс дээш насны иргэдийн цахимаар бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах зардалд 50.0 мянгаас 100.0 мянган төгрөгийн худалдан авалт, 29.1 хувь, 100.0 мянгаас 200.0 мянган төгрөгийн худалдан авалт 24.8 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 54. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, мянган төгрөг, зардлын хэмжээгээр



Цахимаар бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авсан иргэдээс хотод амьдардаг иргэдийн 27.6 хувь нь 50.0 мянгаас 100.0 мянган төгрөг, 25.1 хувь нь 100.0 мянгаас 200.0 мянган төгрөг, хөдөө амьдардаг иргэдийн 36.5 хувь нь 50.0 мянгаас 100.0 мянган төгрөг, 23.5 хувь нь 200.0 мянгаас 500.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

ЗУРАГ 55. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ХУВЬ, зардлын хэмжээ, хот, хөдөөгөөр



Цахимаар бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авсан иргэдээс Улаанбаатарын иргэдийн 27.4 хувь нь 100.0 мянгаас 200.0 мянган төгрөг, 25.8 хувь нь 50.0 мянгаас 100.0 мянган төгрөг, аймгийн төвийн иргэдийн 20.4 хувь нь 100.0 мянгаас 200.0 мянган төгрөг, 31.3 хувь нь 50.0 мянгаас 100.0 мянган төгрөг, сумын төвийн иргэдийн 24.9 хувь нь 100.0 мянгаас 200.0 мянган төгрөг, 35.1 хувь нь 50.0 мянгаас 100.0 мянган төгрөг, хөдөөгийн багийн иргэдийн 22.2 хувь нь 100.0 мянгаас 200.0 мянган төгрөг, 37.8 хувь нь 50.0 мянгаас 100.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.



ХҮСНЭГТ 76. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ХУВЬ, мянган төгрөг, зардлын хэмжээ, суурьшлаар

	Улс	50.0 төгрөг хүртэл	50.0- 100.0	100.0- 200.0	200.0-500.0	500.0- 1 000.0	1 000.0 төгрөгөөс дээш
Улаанбаатар	37.7	14.5	25.8	27.4	18.0	5.6	8.7
Аймгийн төв	27.7	11.8	31.3	20.4	22.1	7.3	7.1
Сумын төв	25.4	9.7	35.1	24.9	18.8	6.6	5.0
Хөдөөгийн баг	16.3	13.8	37.8	22.2	16.4	7.2	2.6


Нийт иргэдээс Зүүн бүсийн нийт иргэдийн иргэдийн 41.2 хувь нь 50.0 мянгаас 100.0 мянган төгрөг, 23.7 хувь нь 100.0 мянгаас 200.0 мянган төгрөг, Төвийн бүсийн иргэдийн 37.9 хувь нь 50.0 мянгаас 100.0 мянган төгрөг, 22.5 хувь нь 100.0 мянгаас 200.0 мянган төгрөг, Хангайн бүсийн иргэдийн 28.4 хувь нь 50.0 мянгаас 100.0 мянган төгрөг, 25.5 хувь нь 200.0 мянгаас 500.0 мянган төгрөг, Баруун бүсийн иргэдийн 27.5 хувь нь 50.0 мянгаас 100.0 мянган төгрөг, 17.6 хувь нь 100.0 мянгаас 200.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 77. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, зардлын хэмжээ, бүсээр

	Улс	50.0 төгрөг хүртэл	50.0- 100.0	100.0- 200.0	200.0-500.0	500.0- 1 000.0	1 000.0 төгрөгөөс дээш
Баруун	18.6	13.5	27.5	17.6	23.2	11.4	6.8
Хангай	23.1	12.5	28.4	21.9	25.5	7.2	4.5
Төв	28.4	10.9	37.9	22.5	17.6	6.1	4.9
Зүүн	25.1	10.4	41.2	23.7	11.1	4.4	9.2
Улаанбаатар	37.7	14.5	25.8	27.4	18.0	5.6	8.7


Цахимаар бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авсан иргэдээс эрэгтэйчүүдийн 21.5 хувь нь 100.0 мянгаас 200.0 мянган төгрөг, 24.7 хувь нь 50.0 мянгаас 100.0 мянган төгрөг, эмэгтэйчүүдийн 32.4 хувь нь 50.0 мянгаас 100.0 мянган төгрөг, 27.3 хувь нь 100.0 мянгаас 200.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

ЗУРАГ 56. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, зардлын хэмжээ, хүйсээр



Мөн 35 хүртэлх насныхны 29.9 хувь нь 50.0 мянгаас 100.0 мянган төгрөг, 25.9 хувь нь 100.0 мянгаас 200.0 мянган төгрөг, 35-59 насныхны 26.8 хувь нь 50.0 мянгаас 100.0 мянган төгрөг, 24.4 хувь нь 100.0 мянгаас 200.0 мянган төгрөг, 60 буюу түүнээс дээш насныхны 39.7 хувь нь 50.0 мянгаас 100.0 мянган төгрөг, 16.8 хувь нь 100.0 мянгаас 200.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

ЗУРАГ 57. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, зардлын хэмжээ, насны бүлгээр



Цахимаар бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авсан иргэдээс боловсролгүй гэж хариулсан иргэдийн 65.6 хувь нь 50.0 мянган төгрөг хүртэл, 34.4 хувь нь 50.0 мянгаас 100.0 мянган төгрөг, бүрэн дунд боловсролтой иргэдийн 31.1 хувь нь 50.0 мянгаас 100.0 мянган төгрөг, 27.4 хувь нь 100.0 мянгаас 200.0 мянган төгрөг, дээд боловсролтой иргэдийн 26.4 хувь нь 50.0 мянгаас 100.0 мянган төгрөг, 23.2 хувь нь 100.0 мянгаас 200.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.


ХҮСНЭГТ 78. ЦАХИМААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВСАН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, зардлын хэмжээ, боловсролын түвшнээр

	Улс	50.0 төгрөг хүртэл	50.0-100.0	100.0-200.0	200.0-500.0	500.0-1 000.0	1 000.0 төгрөгөөс дээш
Боловсролгүй	7.9	65.6	34.4	-	-	-	-
Бага	7.0	28.9	20.1	15.9	25.9	2.3	7.0
Суурь	15.7	20.8	42.0	15.9	11.2	3.4	6.6
Бүрэн дунд	24.0	17.6	31.1	27.4	12.9	6.9	4.1
Техник, мэргэжлийн	25.3	13.6	32.7	32.0	14.2	4.3	3.2
Дээд	44.4	9.2	26.4	23.2	24.5	6.5	10.2

### 3.4.5 Цахим худалдаа, үйлчилгээг сонгоогүй иргэд, шалтгааны төрлөөр


Монгол Улсын 15 ба түүнээс дээш насны иргэдийн 70.1 хувь нь цахим худалдаа, үйлчилгээ сонгоогүй байна. Цахим худалдаа, үйлчилгээг сонгоогүй иргэдийн шалтгааны төрлийг бүлэглэн харвал, 70.5 хувь нь дэлгүүрээс худалдан авахыг илүүд үздэг, 21.6 хувь нь мэдлэг, чадвар дутмаг, 9.7 хувь нь итгэлцлийн асуудал, 7.3 хувь нь аюулгүй байдлын асуудал, 2.8 хувь нь техникийн асуудал, 2.0 хувь нь нууцлалын асуудал зэрэг шалтгаантай байна.

ЗУРАГ 58. ЦАХИМ ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ СОНГООГҮЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, шалтгааны төрлөөр



Хот, хөдөөгийн иргэдийн цахим худалдаа, үйлчилгээг сонгоогүй шалтгааны төрлийг авч үзвэл, хотод амьдардаг иргэдийн 66.3 хувь, хөдөө амьдардаг иргэдийн 80.4 хувь нь цахим худалдаа, үйлчилгээ сонгоогүй байна. Хотод амьдардаг иргэдийн 71.4 хувь нь дэлгүүрээс худалдан авахыг илүүд үздэг, 18.4 хувь нь мэдлэг чадвар дутмаг, 10.6 хувь нь итгэлцлийн асуудал тулгардаг зэрэг шалтгаантай байгаа бол хөдөөгийн өрхийн 68.6 хувь нь дэлгүүрээс худалдан авахыг илүүд үздэг, 28.8 хувь нь мэдлэг чадвар дутмаг, 7.7 хувь нь итгэлцлийн асуудал, 5.7 хувь нь аюулгүй байдлын асуудал тулгардаг зэрэг шалтгаанууд эзэлж байна.

ЗУРАГ 59. ЦАХИМ ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ СОНГООГҮЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, хот, хөдөөгөөр



Цахим худалдаа, үйлчилгээ сонгоогүй иргэдээс Улаанбаатарын өрхийн 62.3 хувь, аймгийн төвийн өрхийн 72.3 хувь, сумын төвийн өрхийн 74.6 хувь, хөдөөгийн багийн өрхийн 83.7 хувь нь цахим худалдаа, үйлчилгээ сонгоогүй байна. Улаанбаатарын өрхийн хувьд 71.6 хувь нь дэлгүүрээс худалдан авахыг илүүд үздэг, 10.4 хувь нь итгэлцлийн асуудал тулгардаг гэж үзсэн бол хөдөөгийн багийн өрхүүдийн 66.5 хувь нь дэлгүүрээс худалдан авахыг илүүд үздэг, 30.9 хувь нь мэдлэг чадвар дутмаг, 6.5 хувь нь техникийн хүндрэл тулгардаг гэж хариулсан байна.

ХҮСНЭГТ 79. ЦАХИМ ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ СОНГООГҮЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, суурьшлаар

	Улс	Дэлгүүрээс худалдан авахыг илүүд үздэг	Аюулгүй байдлын асуудал	Нууцлалын асуудал	Техникийн асуудал	Итгэлцлийн асуудал	Мэдлэг чадвар дутмаг
Улаанбаатар	62.3	71.6	8.5	2.7	2.2	10.4	16.7
Аймгийн төв	72.3	71.1	7.5	1.8	1.1	10.7	20.5
Сумын төв	74.6	72.7	8.3	2.0	2.7	10.9	24.5
Хөдөөгийн баг	83.7	66.5	4.3	0.9	6.5	6.1	30.9


Цахим худалдаа, үйлчилгээ сонгоогүй иргэдээс Баруун бүсийн иргэдийн 81.4 хувь, Хангайн бүсийн иргэдийн 76.9 хувь, Төвийн бүсийн иргэдийн 71.6 хувь, Зүүн бүсийн иргэдийн 74.9 хувь нь цахим худалдаа, үйлчилгээ сонгоогүй байна. Баруун бүсийн иргэдийн 66.8 хувь нь дэлгүүрээс худалдан авахыг илүүд үздэг, 28.5 хувь нь мэдлэг чадвар дутмаг, Хангайн бүсийн 68.7 хувь нь дэлгүүрээс худалдан авахыг илүүд үздэг, 24.8 хувь нь мэдлэг чадвар дутмаг, Зүүн бүсийн 68.6 хувь нь дэлгүүрээс худалдан авахыг илүүд үздэг, 25.6 хувь нь мэдлэг чадвар дутмаг гэж хариулсан байна.

ХҮСНЭГТ 80. ЦАХИМ ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ СОНГООГҮЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, бүсээр

	Улс	Дэлгүүрээс худалдан авахыг илүүд үздэг	Аюулгүй байдлын асуудал	Нууцлалын асуудал	Техникийн асуудал	Итгэлцлийн асуудал	Мэдлэг чадвар дутмаг
Баруун	81.4	66.8	3.0	0.3	3.2	7.5	28.5
Хангай	76.9	68.7	5.5	2.2	4.2	8.9	24.8
Төв	71.6	74.8	8.8	2.1	1.8	11.1	20.4
Зүүн	74.9	68.6	11.8	0.8	3.1	9.6	25.6
Улаанбаатар	62.3	71.6	8.5	2.7	2.2	10.4	16.7

Цахим худалдаа, үйлчилгээ сонгоогүй иргэдээс эрэгтэйчүүдийн 73.6 хувь, эмэгтэйчүүдийн 66.8 хувь нь цахим худалдаа, үйлчилгээг сонгоогүй байна. Цахим худалдаа, үйлчилгээг сонгоогүй эрэгтэй хүмүүсийн 71.0 хувь, эмэгтэй хүмүүсийн 70.1 хувь нь дэлгүүрээс худалдан авахыг илүүд үздэг гэжээ.

ЗУРАГ 60. ЦАХИМ ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ СОНГООГҮЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, төрөл, хүйсээр



Мөн 35 хүртэлх насныхны 64.6 хувь, 35-59 насныхны 71.5 хувь, 60 буюу түүнээс дээш насныхны 86.2 хувь нь цахим худалдаа, үйлчилгээ сонгоогүй байна. 35 хүртэлх насны

болон 35-59 насныхны цахим худалдаа, үйлчилгээ сонгоогүй иргэдийн 76.2 хувь болон 69.9 хувь нь дэлгүүрээс худалдан авахыг илүүд үздэг бол 60 буюу түүнээс дээш насныхны 49.9 хувь нь мэдлэг чадвар дутмаг шалтгааны улмаас интернэт худалдан авалтыг сонгоогүй байна.

ХҮСНЭГТ 81. ЦАХИМ ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ СОНГООГҮЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, насны бүлгээр

	Улс	Дэлгүүрээс худалдан авахыг илүүд үздэг	Аюулгүй байдлын асуудал	Нууцлалын асуудал	Техникийн асуудал	Итгэлцлийн асуудал	Мэдлэг чадвар дутмаг
35 хүртэлх	64.6	76.2	8.9	2.6	3.7	11.7	10.3
35-59	71.5	69.9	7.1	1.9	2.4	9.7	23.0
60+	86.2	55.8	3.3	0.6	1.3	3.6	49.9

Цахим худалдаа, үйлчилгээ сонгоогүй иргэдээс боловсролгүй гэж хариулсан иргэдийн 92.1 хувь, бүрэн дунд боловсролтой иргэдийн 76.0 хувь, дээд боловсролтой иргэдийн 55.6 хувь нь цахим худалдаа, үйлчилгээг сонгоогүй байна. Боловсролгүй иргэдийн 79.7 хувь нь мэдлэг чадвар дутмаг, бүрэн дунд боловсролтой иргэдийн 9.9 хувь нь итгэлцлийн асуудал, дээд боловсролтой иргэдийн 79.4 хувь нь дэлгүүрээс худалдан авахыг илүүд үздэг гэж хариулсан байна.

ХҮСНЭГТ 82. ЦАХИМ ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ СОНГООГҮЙ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, боловсролын түвшнээр

	Улс	Дэлгүүрээс худалдан авахыг илүүд үздэг	Аюулгүй байдлын асуудал	Нууцлалын асуудал	Техникийн асуудал	Итгэлцлийн асуудал	Мэдлэг чадвар дутмаг
Боловсролгүй	92.1	29.3	0.8	-	5.7	1.6	79.7
Бага	93.0	50.2	8.3	6.9	2.9	2.8	45.1
Суурь	84.3	55.7	4.7	2.4	3.1	7.5	39.0
Бүрэн дунд	76.0	70.4	8.0	1.4	3.6	9.9	21.2
Техник, мэргэжлийн	74.7	75.0	5.2	1.0	0.7	8.4	22.9
Дээд	55.6	79.4	7.7	2.4	1.7	11.8	9.8


### 3.5 Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн ур чадвар

Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн ур чадварыг мэдээллийн ур чадвар, харилцаа холбооны ур чадвар, асуудал шийдвэрлэх ур чадвар, программ хангамжийн ур чадвар, аюулгүй байдлын ур чадвар гэж 5 бүлэгт хувааж авч үздэг.

#### 3.5.1 Мэдээллийн ур чадвар

Монгол Улсын 15 ба түүнээс дээш насны хүн амын 52.6 хувь нь сүүлийн 3 сард мэдээллийн ур чадвартай холбоотой үйлдэл хийсэн байна. Мэдээллийн ур чадвартай холбоотой үйлдэл хийсэн иргэдийн 40.9 хувь нь бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл хайж олох, 29.0 хувь нь төрийн болон үйлчилгээний байгууллагуудын веб хуудаснаас мэдээлэл авах, 16.9 хувь нь дижитал орчин дахь өгөгдөл, мэдээлэл, агуулгыг хуулбарлах, шилжүүлэх хэрэгсэл ашиглах, 19.8 хувь нь интернэтийн орчинд файл хадгалах үйлдлийг хийсэн байна.

ЗУРАГ 61. МЭДЭЭЛЛИЙН УР ЧАДВАРТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДЭЛ ХИЙСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард,



Хотын иргэдийн 56.2 хувь, хөдөөгийн иргэдийн 42.4 хувь нь ур чадвартай холбоотой үйлдэл хийсэн байна. Мэдээллийн ур чадварын бүлгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл хайж олох үйлдлийг хотын иргэдийн 44.4 хувь, хөдөөгийн иргэдийн 31.1 хувь, төрийн болон үйлчилгээний байгууллагуудын веб хуудаснаас мэдээлэл авах үйлдлийг хотын иргэдийн 32.0 хувь, хөдөөгийн иргэдийн 20.4 хувь нь тус тус хийсэн байна.

ХҮСНЭГТ 83. МЭДЭЭЛЛИЙН УР ЧАДВАРТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДЭЛ ХИЙСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, хот, хөдөөгөөр

	Тийм	Бараа, үйлчилгээний талаарх мэдээлэл хайж олох	Дижитал орчин дахь өгөгдөл, мэдээлэл, агуулгыг хуулбарлах, шилжүүлэх хэрэгсэл ашиглах	Интернетийн орчинд файл хадгалах	Төрийн болон үйлчилгээний байгууллагуудын веб хуудаснаас мэдээлэл авах
Хот	56.2	44.4	18.4	23.0	32.0
Хөдөө	42.4	31.1	12.4	10.8	20.4

Мэдээллийн ур чадвартай холбоотой үйлдэл хийсэн иргэдээс бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл хайж олох үйлдлийг Улаанбаатарын иргэдийн 50.5 хувь, аймгийн төвийн иргэдийн 35.3 хувь, сумын төвийн иргэдийн 39.0 хувь, хөдөөгийн багийн иргэдийн 26.5 хувь нь хийсэн байна.

ХҮСНЭГТ 84. МЭДЭЭЛЛИЙН УР ЧАДВАРТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДЭЛ ХИЙСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, суурьшлаар

Суурьшил	Тийм	Бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл хайж олох	Дижитал орчин дахь өгөгдөл, мэдээлэл, агуулгыг хуулбарлах, шилжүүлэх хэрэгсэл ашиглах	Интернетийн орчинд файл хадгалах	Төрийн болон үйлчилгээний байгууллагуудын веб хуудаснаас мэдээлэл авах
Улаанбаатар	61.6	50.5	22.4	28.0	36.8
Аймгийн төв	48.0	35.3	12.5	15.6	24.8
Сумын төв	50.6	39.0	17.6	14.5	21.5
Хөдөөгийн баг	37.6	26.5	9.4	8.7	19.8


Мэдээллийн ур чадвартай холбоотой үйлдэл хийсэн иргэдээс интернетийн орчинд файл хадгалах үйлдлийг Баруун бүсийн иргэдийн 18.0 хувь, Хангайн бүсийн иргэдийн 8.4 хувь, Төвийн бүсийн иргэдийн 12.5 хувь, Зүүн бүсийн иргэдийн 13.9 хувь нь хийсэн байна.

ХҮСНЭГТ 85. МЭДЭЭЛЛИЙН УР ЧАДВАРТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДЭЛ ХИЙСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, бүсээр

Суурьшил	Тийм	Бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл хайж олох	Дижитал орчин дахь өгөгдөл, мэдээлэл, агуулгыг хуулбарлах, шилжүүлэх хэрэгсэл ашиглах	Интернэтийн орчинд файл хадгалах	Төрийн болон үйлчилгээний байгууллагуудын веб хуудаснаас мэдээлэл авах
Баруун	40.5	24.9	18.0	9.6	16.2
Хангай	42.0	28.4	8.4	11.9	21.1
Төв	52.8	43.8	12.5	18.2	30.5
Зүүн	46.7	38.0	13.9	13.0	21.7
Улаанбаатар	61.6	50.5	22.4	28.0	36.8

Мэдээллийн ур чадвартай холбоотой үйлдэл хийсэн иргэдээс эрэгтэйчүүдийн 28.0 хувь нь төрийн болон үйлчилгээний байгууллагуудын веб хуудаснаас мэдээлэл авах, 19.6 хувь нь интернэтийн орчинд файл хадгалах, эмэгтэйчүүдийн 42.8 хувь нь бараа, үйлчилгээний мэдээллийг хайж олох, 20.0 хувь нь интернэтийн орчинд файл хадгалах үйлдлийг хийсэн байна.

ЗУРАГ 62. МЭДЭЭЛЛИЙН УР ЧАДВАРТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДЭЛ ХИЙСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард хүйсээр



Мөн 35 хүртэлх насныхны 48.4 хувь нь бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээллийг хайж олох, 35.5 хувь нь төрийн болон үйлчилгээний байгууллагуудын веб хуудаснаас мэдээлэл авах үйлдэл, 35-59 насныхны 49.7 хувь нь бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээллийг хайж олох, 27.0 хувь нь төрийн болон үйлчилгээний байгууллагуудын веб хуудаснаас мэдээлэл авах үйлдэл, 60 буюу түүнээс дээш насныхны 25.1 хувь нь бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээллийг хайж олох, 10.2 хувь нь төрийн болон үйлчилгээний байгууллагуудын веб хуудаснаас мэдээлэл авах үйлдэл хийсэн байна.

ХҮСНЭГТ 86. МЭДЭЭЛЛИЙН УР ЧАДВАРТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДЭЛ ХИЙСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, насны бүлгээр

Суурьшил	Тийм	Бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл хайж олох	Дижитал орчин дахь өгөгдөл, мэдээлэл, агуулгыг хуулбарлах, шилжүүлэх хэрэгсэл ашиглах	Интернэтийн орчинд файл хадгалах	Төрийн болон үйлчилгээний байгууллагуудын веб хуудаснаас мэдээлэл авах
35 хүртэлх	62.2	48.4	21.6	25.8	35.5
35-59	49.7	38.7	14.6	17.7	27.0
60+	25.1	19.8	6.4	4.4	10.2

Мэдээллийн ур чадвартай холбоотой үйлдэл хийсэн иргэдээс боловсролгүй гэж хариулсан иргэдийн 2.6 хувь нь бараа, үйлчилгээний мэдээллийг хайж олох, бүрэн дунд боловсролтой иргэдийн 23.6 хувь нь төрийн болон үйлчилгээний байгууллагуудын веб хуудаснаас мэдээлэл авах, дээд боловсролтой иргэдийн 34.9 хувь нь интернэтийн орчинд файл хадгалах үйлдэл хийсэн байна.


ХҮСНЭГТ 87. МЭДЭЭЛЛИЙН УР ЧАДВАРТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДЭЛ ХИЙСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, боловсролын түвшнээр

Суурьшил	Тийм	Бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл хайж олох	Дижитал орчин дахь өгөгдөл, мэдээлэл, агуулгыг хуулбарлах, шилжүүлэх хэрэгсэл ашиглах	Интернэтийн орчинд файл хадгалах	Төрийн болон үйлчилгээний байгууллагуудын веб хуудаснаас мэдээлэл авах
Боловсролгүй	6.1	2.6	2.3	-	5.3
Бага	18.8	17.1	3.7	1.1	5.6
Суурь	32.4	24.0	10.6	7.6	10.8
Бүрэн дунд	46.1	36.7	11.9	13.1	23.6
Техник, мэргэжлийн	51.9	38.9	12.1	11.1	23.9
Дээд	69.2	53.3	27.0	34.9	43.3

### 3.5.2 Харилцаа холбооны ур чадвар

Уг судалгаанд зөвхөн компьютер ашиглан хийсэн үйлдлүүдийг авч үзсэн. Монгол Улсын иргэдийн 84.1 хувь нь сүүлийн 3 сард харилцаа холбооны ур чадвартай холбоотой үйлдэл хийсэн байна. Харилцаа холбооны ур чадвартай холбоотой үйлдэл хийсэн иргэдийн 74.4 хувь нь интернэтээр утсаар ярих, видео дуудлага хийх, 68.3 хувь нь олон нийтийн сүлжээнд оролцох, 47.1 хувь нь хавсаргасан файлуудтай мессеж илгээх, 12.8 хувь нь өөрөө бүтээсэн контентоо бусадтай хуваалцах, веб хуудсанд байршуулах үйлдлийг хийсэн байна.

ЗУРАГ 63. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ УР ЧАДВАРТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДЭЛ ХИЙСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард



Хотын иргэдийн 84.4 хувь, хөдөөгийн иргэдийн 82.6 хувь нь ур чадвартай холбоотой үйлдэл хийсэн байна. Харилцаа холбооны ур чадварын бүлгийн интернэтээр утсаар ярих, видео дуудлага хийх үйлдлийг хотын иргэдийн 75.8 хувь, хөдөөгийн иргэдийн 67.2 хувь, олон нийтийн сүлжээнд оролцох үйлдлийг хотын иргэдийн 70.0 хувь, хөдөөгийн иргэдийн 59.8 хувь нь хийсэн байна.



ХҮСНЭГТ 88. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ УР ЧАДВАРТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДЭЛ ХИЙСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, хот, хөдөөгөөр

	Тийм	Хавсаргасан файлуудтай мессеж илгээх	Олон нийтийн сүлжээнд оролцох	Интернэтээр утсаар ярих, видео дуудлага хийх	Өөрөө бүтээсэн контентоо бусадтай хуваалцах, веб хуудсанд байршуулах
Хот	84.4	47.7	70.0	75.8	13.4
Хөдөө	82.6	43.6	59.8	67.2	9.8

Харилцаа холбооны ур чадвартай холбоотой үйлдэл хийсэн иргэдээс интернэтээр утсаар ярих, видео дуудлага хийх үйлдлийг Улаанбаатарын иргэдийн 79.5 хувь, аймгийн төвийн иргэдийн 69.2 хувь, сумын төвийн иргэдийн 66.4 хувь, хөдөөгийн багийн иргэдийн 68.0 хувь нь хийсэн байна.

ХҮСНЭГТ 89. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ УР ЧАДВАРТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДЭЛ ХИЙСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, суурьшлаар

Суурьшил	Тийм	Хавсаргасан файлуудтай мессеж илгээх	Олон нийтийн сүлжээнд оролцох	Интернэтээр утсаар ярих, видео дуудлага хийх	Өөрөө бүтээсэн контентоо бусадтай хуваалцах, веб хуудсанд байршуулах
Улаанбаатар	86.9	53.3	71.3	79.5	15.8
Аймгийн төв	79.8	37.6	67.5	69.2	9.0
Сумын төв	84.7	46.4	64.7	66.4	10.7
Хөдөөгийн баг	80.5	41.0	55.0	68.0	9.0


Харилцаа холбооны ур чадвартай холбоотой үйлдэл хийсэн иргэдээс хавсаргасан файлуудтай мессеж илгээх үйлдлийг Төвийн бүсийн иргэдийн 45.7 хувь, Баруун бүсийн иргэдийн 49.7 хувь, Зүүн бүсийн иргэдийн 44.7 хувь, Хангайн бүсийн иргэдийн 27.6 хувь нь хийсэн байна.

ХҮСНЭГТ 90. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ УР ЧАДВАРТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДЭЛ ХИЙСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, бүсээр

Суурьшил	Тийм	Хавсаргасан файлуудтай мессеж илгээх	Олон нийтийн сүлжээнд оролцох	Интернэтээр утсаар ярих, видео дуудлага хийх	Өөрөө бүтээсэн контентоо бусадтай хуваалцах, веб хуудсанд байршуулах
Баруун	79.0	49.7	54.2	58.2	13.8
Хангай	79.8	27.6	64.4	71.1	6.0
Төв	84.7	45.7	71.7	76.2	10.0
Зүүн	77.1	44.7	64.5	58.7	10.0
Улаанбаатар	86.9	53.3	71.3	79.5	15.8

Харилцаа холбооны ур чадвартай холбоотой үйлдэл хийсэн иргэдээс эрэгтэйчүүдийн 73.0 хувь нь интернэтээр утсаар ярих, видео дуудлага хийх, 69.2 хувь нь олон нийтийн сүлжээнд оролцох, эмэгтэйчүүдийн 75.7 хувь нь интернэтээр утсаар ярих, видео дуудлага хийх, 67.6 хувь нь олон нийтийн сүлжээнд оролцох үйлдлийг хийсэн байна.

ЗУРАГ 64. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ УР ЧАДВАРТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДЭЛ ХИЙСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, хүйсээр



Мөн 35 хүртэлх насныхны 51.5 хувь нь хавсаргасан файлуудтай мессеж илгээх, 13.6 хувь нь өөрөө бүтээсэн контентоо бусадтай хуваалцах, веб хуудсанд байршуулах, 35-59 насныхны 41.6 хувь нь хавсаргасан файлуудтай мессеж илгээх, 12.0 хувь нь өөрөө бүтээсэн контентоо бусадтай хуваалцах, веб хуудсанд байршуулах, 60 буюу түүнээс дээш насныхны 37.2 хувь нь хавсаргасан файлуудтай мессеж илгээх, 9.3 хувь нь өөрөө бүтээсэн контентоо бусадтай хуваалцах, веб хуудсанд байршуулах үйлдэл хийсэн байна.

ХҮСНЭГТ 91. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ УР ЧАДВАРТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДЭЛ ХИЙСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, насны бүлгээр

Суурьшил	Тийм	Хавсаргасан файлуудтай мессеж илгээх	Олон нийтийн сүлжээнд оролцох	Интернэтээр утсаар ярих, видео дуудлага хийх	Өөрөө бүтээсэн контентоо бусадтай хуваалцах, веб хуудсанд байршуулах
35 хүртэлх	84.5	51.5	69.8	76.5	13.6
35-59	80.8	41.6	67.8	73.5	12.0
60+	61.0	37.2	50.3	52.5	9.3

Харилцаа холбооны ур чадвартай холбоотой үйлдэл хийсэн иргэдээс бүрэн дунд боловсролтой иргэдийн 65.3 хувь нь интернэтээр утсаар ярих, видео дуудлага хийх, дээд боловсролтой иргэдийн 56.2 хувь нь хавсаргасан файлуудтай мессеж илгээх үйлдэл хийсэн байна.

ХҮСНЭГТ 92. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ УР ЧАДВАРТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДЭЛ ХИЙСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, боловсролын түвшнээр


Суурьшил	Тийм	Хавсаргасан файлуудтай мессеж илгээх	Олон нийтийн сүлжээнд оролцох	Интернэтээр утсаар ярих, видео дуудлага хийх	Өөрөө бүтээсэн контентоо бусадтай хуваалцах, веб хуудсанд байршуулах
Бага	93.1	17.8	88.9	84.8	10.0
Суурь	72.2	40.4	61.5	63.5	36.3
Бүрэн дунд	76.5	30.0	58.8	65.3	7.1
Техник, мэргэжлийн	81.0	33.6	72.9	69.4	10.5
Дээд	88.2	56.2	72.5	79.4	14.7

### 3.5.3 Асуудал шийдвэрлэх ур чадвар

Уг судалгаанд зөвхөн компьютер ашиглан хийсэн үйлдлүүдийг авч үзсэн. Монгол Улсын 15 ба түүнээс дээш насны иргэдийн 77.1 хувь нь сүүлийн 3 сард асуудал шийдвэрлэх ур чадвартай холбоотой үйлдэл хийсэн байна. Асуудал шийдвэрлэх ур чадвартай холбоотой

үйлдэл хийсэн иргэдийн 56.7 хувь нь интернэт банк хэрэглэх, 33.8 хувь нь программ хайх, татаж авах, суулгах, тохируулах, 27.7 хувь нь цахим худалдаа хийх, 22.0 хувь нь цахим сургалтын материал ашиглах үйлдлийг хийсэн байна.

ЗУРАГ 65 АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭХ УР ЧАДВАРТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДЭЛ ХИЙСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард



Хотын иргэдийн 78.8 хувь, хөдөөгийн иргэдийн 68.2 хувь нь асуудал шийдвэрлэх ур чадвартай холбоотой үйлдэл хийсэн байна. Асуудал шийдвэрлэх ур чадварын бүлгийн программ хайх, татаж авах, суулгах, тохируулах үйлдлийг хотын иргэдийн 34.6 хувь, хөдөөгийн иргэдийн 29.4 хувь, цахим сургалтын материал ашиглах үйлдлийг хотын иргэдийн 21.6 хувь, хөдөөгийн иргэдийн 24.0 хувь нь хийсэн байна.

ХҮСНЭГТ 93. АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭХ УР ЧАДВАРТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДЭЛ ХИЙСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, хот, хөдөөгөөр

	Тийм	Төхөөрөмж хооронд файл, программ дамжуулах	Программ хайх, суулгах, тохируулах	Үйлдлийн систем, программын тохиргоог өөрчлөх	Цахимаар худалдан авалт хийх	Цахимаар борлуулалт хийх	Цахим сургалтын материал ашиглах	Интернет банк хэрэглэх
Хот	78.8	30.3	34.6	10.5	29.3	6.3	21.6	58.4
Хөдөө	68.2	22.2	29.4	5.7	19.2	3.3	24.0	47.6

Асуудал шийдвэрлэх ур чадвартай холбоотой үйлдэл хийсэн иргэдээс төхөөрөмжүүд хооронд файл эсвэл программ дамжуулах үйлдлийг Улаанбаатарын иргэдийн 33.8 хувь, аймгийн төвийн иргэдийн 24.0 хувь, сумын төвийн иргэдийн 27.3 хувь, хөдөөгийн багийн иргэдийн 17.2 хувь нь хийсэн байна.

ХҮСНЭГТ 94. АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭХ УР ЧАДВАРТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДЭЛ ХИЙСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, суурьшлаар

	Тийм	Төхөөрөмж хооронд файл, программ дамжуулах	Программ хайх, суулгах, тохируулах	Үйлдлийн систем, программын тохиргоог өөрчлөх	Цахимаар худалдан авалт хийх	Цахимаар борлуулалт хийх	Цахим сургалтын материал ашиглах	Интернет банк хэрэглэх
Улаанбаатар	81.6	33.8	36.1	11.5	30.8	6.6	21.7	63.1
Аймгийн төв	73.8	24.0	31.9	8.6	26.6	5.5	21.5	49.8
Сумын төв	75.8	27.3	31.5	6.4	22.8	3.5	23.7	48.1
Хөдөөгийн баг	60.8	17.2	27.3	5.1	15.7	3.0	24.3	47.1


Асуудал шийдвэрлэх үр чадвартай холбоотой үйлдэл хийсэн иргэдээс интернэт банк хэрэглэх үйлдлийг Төвийн бүсийн иргэдийн 57.4 хувь, Хангайн бүсийн иргэдийн 49.4 хувь, Баруун бүсийн иргэдийн 35.8 хувь, Зүүн бүсийн иргэдийн 47.2 хувь нь хийсэн байна.

**ХҮСНЭГТ 95. АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭХ ҮР ЧАДВАРТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДЭЛ ХИЙСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, бүсээр**

Тийм	Төхөөрөмж хооронд файл, программ дамжуулах	Программ хайх, суулгах, тохируулах	Үйлдлийн систем, программын тохиргоог өөрчлөх	Цахимаар худалдан авалт хийх	Цахимаар борлуулалт хийх	Цахим сургалтын материал ашиглах	Интернет банк хэрэглэх
Баруун	57.6	23.7	32.2	8.9	14.3	1.1	35.8
Хангай	74.4	20.3	31.0	4.1	27.6	5.5	49.4
Төв	76.2	22.8	31.2	10.8	27.7	3.8	57.4
Зүүн	74.1	31.8	29.2	7.5	19.3	9.3	47.2
Улаанбаатар	81.6	33.8	36.1	11.5	30.8	6.6	63.1

Асуудал шийдвэрлэх үр чадвартай холбоотой үйлдэл хийсэн иргэдээс эрэгтэйчүүдийн 59.2 хувь нь интернэт банк ашиглах, 35.7 хувь нь программ хайх, татаж авах, суулгах, тохируулах, эмэгтэйчүүдийн 54.3 хувь нь интернэт банк ашиглах, 32.1 хувь нь программ хайх, татаж авах, суулгах, тохируулах үйлдлийг хийсэн байна.

**ЗУРАГ 66. АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭХ ҮР ЧАДВАРТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДЭЛ ХИЙСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, хүйсээр**



Мөн 35 хүртэлх насныхны 23.2 хувь нь цахим сургалтын материал ашиглах, 31.3 хувь нь төхөөрөмж хооронд файл, программ дамжуулах, 35-59 насныхны 21.6 хувь нь цахим сургалтын материал ашиглах, 27.7 хувь нь төхөөрөмж хооронд файл, программ дамжуулах үйлдэл хийсэн байна.

**ХҮСНЭГТ 96. АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭХ ҮР ЧАДВАРТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДЭЛ ХИЙСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, насны бүлгээр**

Тийм	Төхөөрөмж хооронд файл, программ дамжуулах	Программ хайх, суулгах, тохируулах	Үйлдлийн систем, программын тохиргоог өөрчлөх	Цахимаар худалдан авалт хийх	Цахимаар борлуулалт хийх	Цахим сургалтын материал ашиглах	Интернет банк хэрэглэх
35 хүртэл	78.9	31.3	34.7	10.9	25.7	6.9	56.8
35-59	76.1	27.7	34.1	8.6	30.9	4.3	57.2
60+	59.0	6.4	16.3	2.9	22.9	4.5	47.6

Асуудал шийдвэрлэх ур чадвартай холбоотой үйлдэл хийсэн иргэдээс бүрэн дунд боловсролтой иргэдийн 25.4 хувь нь программ хайх, суулгах, тохируулах, дээд боловсролтой иргэдийн 36.8 хувь нь төхөөрөмж хооронд файл, программ дамжуулах үйлдэл хийсэн байна.


#### ХҮСНЭГТ 97. АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭХ УР ЧАДВАРТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДЭЛ ХИЙСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард, боловсролын түвшнээр

	Тийм	Төхөөрөмж хооронд файл, программ дамжуулах	Программ хайх, суулгах, тохируулах	Үйлдлийн систем, программын тохиргоог өөрчлөх	Цахимаар худалдан авалт хийх	Цахимаар борлуулалт хийх	Цахим сургалтын материал ашиглах	Интернет банк хэрэглэх
Бага	84.8	17.8	10.0	17.8	17.8	-	17.8	84.8
Суурь	66.2	20.7	30.9	25.4	11.6	3.0	20.9	39.7
Бүрэн дунд	68.1	15.5	25.4	7.4	21.3	5.3	21.0	42.4
Техник, мэргэжлийн	67.2	10.7	24.9	2.3	19.6	6.5	18.8	54.6
Дээд	82.4	36.8	38.5	10.7	31.9	6.1	22.8	63.9

#### 3.5.4 Программ хангамжийн ур чадвар

Уг судалгаанд зөвхөн компьютер ашиглан хийсэн үйлдлүүдийг авч үзсэн болно. Монгол Улсын 15 ба түүнээс дээш насны иргэдийн 45.4 хувь нь сүүлийн 3 сард программ хангамжийн ур чадвартай холбоотой үйлдэл хийсэн байна. Программ хангамжийн ур чадвартай холбоотой үйлдэл хийсэн иргэдийн 37.4 хувь нь текст боловсруулдаг программ хангамж ашиглах, 22.7 хувь нь мэдээллийг цэгцлэх, дүн шинжилгээ хийхэд хүснэгтийн сайжруулсан функцийг ашиглах, 19.0 хувь нь зураг, видео эсвэл аудио файлуудыг засварлахад программ хангамж ашиглах, 11.3 хувь нь илтгэлийн программ хангамж бүхий электрон үзүүлэнг бүтээх, 2.7 хувь нь программчлалын хэлээр код бичих үйлдлийг хийсэн байна.

#### ЗУРАГ 67. ПРОГРАММ ХАНГАМЖИЙН УР ЧАДВАРТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДЭЛ ХИЙСЭН ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, сүүлийн 3 сард



